

**“ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК-ИЙН ДУНДГОВЬ
АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ
“САЛХИТЫН МӨНГӨ-АЛТНЫ УУРХАЙН 2023 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**



2023 он

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН НУТАГ
ДЭВСГЭРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “САЛХИТЫН МӨНГӨ-
АЛТНЫ ОРД” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-021483

РЕГИСТЕРИЙН ДУГААР: 6289754

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ
Ц.ЖАРГАЛНЭМЭХ

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Э.УУГАНБАЯР

ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Ш.НАМСРАЙЖАВ

ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Г.АНХ-АМГАЛАН

2023 он

БҮЛЭГ 1. КОМПАНИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ ТАНИЛЦУУЛГА, БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

/Баяжуулах үйлдвэр, ил уурхай/

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 133 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 49 дүгээр тогтоолоор “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийг стратегийн ач холбогдол бүхий мөнгөний ордуудыг ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах чиг үүрэг бүхий “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 100% эзэмшлийн охин компани хэлбэрээр 2023 оны 07 дугаар сард үүсгэн байгуулсан.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хүрээнд Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн хүрээнд Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэл, Ашигт малтмал, газрын тосны газрын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 341 дүгээр шийдвэрээр Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Салхит” нэртэй 2887.85 га бүхий ашигт малтмал ашиглах ашиглалтын MV-021483 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайг “Эрдэнэс алт ресурс” ХХК-д олгосон. Монгол Улсын Засгийн Газар болон Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамны бодлогын хүрээнд улсын төсвийн тогтвортой эх үүсвэрийг шинээр бий болгох, салбарын нөөц боломжийг зохистойгоор ашиглах үүднээс “Салхит”-ын мөнгө-алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагааг боломжит богино хугацаанд цаг алдалгүй эхлүүлж, Монгол улсын эдийн засагт тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Эрдэнэс алт ресурс ХХК-тай нэгтгэх Эрдэнэс монгол ХХК-ний төлөөлөн удирдах зөвлөлийн 49 дүгээр тогтоол гарч Эрдэнэс алт ресурс ХХК болсон.

Түүнчлэн төрд ногдох өгөөжөөс Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль, түнийг дагаж мөрдөх журмын тухай хууль зэрэг хуулиар заасан тусгай чиг үүргийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зарчим

- Бизнесийн зөвлөгөө өгөх;

Компанийн тусгай зөвшөөрөл

- Дундговь аймгийн Гурвансайхан сумын Салхит нэртэй газарт орших 2,887.85 гектар талбайг хамарсан MV-021483 дугаартай Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл;

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь 2023 онд нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, уул уурхайгаас иргэдийн хүртэх өгөөжийг дээшлүүлэх, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль, түнийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа эрчимжүүлэн ажиллаж байна.

- Компанийн нэр:** • “Эрдэнэс алт ресурс” Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
- Үйл ажиллагааны чиглэл:** • Бизнесийн зөвлөгөө өгөх;
• Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль зэрэг хуулиар заасан тусгай үүргийг мөрдлөг болгон хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
- Компанийн хаяг:** • Монгол Улс, Улаанбаатар хот 14240 Сүхбаатар Дүүрэг 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 17, Блю Скай тауэр, 607 тоот.
Утас: (976) 7535 1111
Е-Майл: info@erdenesgold.mn
Веб хуудас: www.erdenessilver.mn
- Компанийн удирдлага:** • Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Э.Ууганбаяр
- Үүсгэн байгуулагдсан огноо:** • 2023 оны 07 дугаар сарын 05-ний өдөр
- Орон тоо:** • 179
- Салхит мөнгө-алтны ордын байршил:** • Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт оршдог. Улаанбаатар хотоос урд зүгт 280 км, Дундговь аймгийн төв Мандалговь хотоос зүүн хойш 60 км-т, Гурвансайхан сумын төвөөс хойш 35 км зайд байрлана.
- Талбайн хэмжээ:** • 2887.85 гектар (га)
- Тусгай зөвшөөрлийн дугаар:** • MV-021483
- Хүчин чадал:** • 600 мян.тн
- Нөөцийн хэмжээ:** • 600,000 тонн/жил хүдэр
Ордын нийт нөөц-2,920.9 мян.тонн /982.87 тонн мөнгө, 1,353.7 кг алт/.
Таамагласан нийт баялаг-4,649.6 мян.тонн

Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээлэл:

Баяжуулах үйлдвэр нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар **551'712 тн** хүдэр боловсруулж 11'291.3 тн баяжмал үйлдвэрлэсэн байна.

2023 ОНЫ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

№	Үйлдвэрлэлийн мэдээ	2023 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар
1	Ил уурхайн нийт олборлосон хүдрийн материал буюу уулын цул /хөрс, хүдэр нийлсэн хэмжээ/ (мян/м3) Үүнээс:	1'975'800 мян/м³
2	Боловсруулсан хүдэр (мян/тонноор)	551'712 тн
3	Үйлдвэрлэсэн баяжмал (мян/тонноор)	11'291.3 тн

Уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл /11 дүгээр сарын байдлаар/

Байгууллагын нэр	Хэмжих нэгж	Оны эхнээс		1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	"ЭСр"	"ЭСр"	"ЭСр"	"ЭСр"	"ЭСр"	"ЭСр"	"ЭСр"	"ЭСр"	"ЭСр"	"ЭСр"	"ЭСр"
Үзүүлэлт			"ЭСр"	дүн	дүн	дүн	дүн	дүн	дүн	дүн	дүн	дүн	дүн	дүн
Ил уурхайн гүн	м		73.64	70.00	70.00	70.00	70.00	70.00	70.00	87.00	87.00	72.00	72.00	72.00
Өрөмдлөгийн хэмжээ	т/м		136,038.40	9786.70	15364.10	15364.10	18540.30	9118.40	19411.80	7750.90	7750.90	10143.40	9062.70	13745.10
Уулын цулаар хөрсний эзлэхүүн	м3	3471959.18	1,896,682.11	170458.94	159813.08	167062.10	192929.66	237733.98	231836.43	184120.62	103429.40	137364.71	118661.84	193271.35
Уулын цулаар хүдрийн эзлэхүүн	м3	253494.92	229,708.59	10455.43	31798.05	28210.55	18347.47	21067.02	30784.00	19846.35	16861.55	13900.89	16661.46	21775.82
Хүдрийн эзлэхүүн/Пүүжин/	тн	600000.00	545,153.70	24689.55	67683.75	72208.85	39780.30	48051.80	77590.15	45661.65	39463.75	33149.20	38733.25	58141.45
Шимт хөрс	м3		57,392.09		6266.12	21785.93		21480.64	5006.40	0.00		0.00	1680.00	1173.00
Тэсэлсэн уулын цул	м3		1,882,333.92	180914.37	170357.83	174634.96	201477.46	261789.88	253319.32	182287.49	125370.65	51941.76	116984.21	163255.99
Тэсрэх бодисын хэмжээ	тн		989,174.50	180914.37	170357.83	174634.96	201477.46	261789.88						
Нийт уулын цул	м3	3725454.10	2,183,782.79	180914.37	197877.25	217058.58	211277.13	280281.64	267626.83	203966.97	120290.95	151265.60	137003.30	216220.17

БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал, мян.төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	10 м/с-ээс дээш хүчтэй салхитай үед олборлолтын үйл ажиллагааг түр зогсоох	Уурхайн хэмжээнд	-	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг ханган ажилласан байна.	Цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн өдрүүдэд олборлолтын үйл ажиллагаа, уурхайн нийт хөдөлгөөнийг тухай бүр зогсоож аюулгүй ажиллагааг ханган ажилласан. 2023 оны тухайд хүчтэй салхи шуурганаас үүдэлтэй түр зогсолт өмнөх жилүүдтэй харьцуулахад харьцангуй цөөн, цаг агаарын харьцангуй хүч багатай жил байсан.
2	Уурхайгаас дотоод гадаад тээврийн гол замын сүлжээ, маршрутыг шинэчлэн тогтоосны дагуу хяналт тавих	Уурхайн хэмжээнд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Тоожилт, агаарын бохирдлоос сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангаж ажилласан байна.	Салхит уурхайгаас Чойр орох чиглэлийн замд нийт 2 удаагийн хяналт шалгалтыг Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны байгаль орчны байцаагчтай хамтран хийсэн. Мөн зам дагуух хог хаягдлыг тухай бүр цэвэрлэж Гурвансайхан сум, Дэлгэрцогт сумын төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж ажилласан. Нийт 26 удаагийн хяналт тавьж ажилласан. Үүнээс гадна гадаад тээврийн технологийн зам болох Салхит уурхайгаас Дэлгэрцогт сумруу чиглэлтэй 60 км технологийн замыг хусах ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэж дуусгасан. Хяналт шалгалтын ажлыг нийт 24 удаа зохион байгуулж ажилласан.
3	Уурхайн дотоод, гадаад тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа, арчилгааг хийх	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Тоожилт, агаарын бохирдлоос сэргийлж ажилласан	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор дулааны улиралд усалгааг тогтмол хийдэг. Уурхайн доторх болон дэд бүтцийн шугамын дагуух замуудыг дулааны улиралд өдөр бүр, түгээмэл ашиглагддаг замуудад өдөрт 2-3 удаа

				байна.	тоосжилт үүсэхээс сэргийлж усалгааг хийж гүйцэтгэдэг. Хүйтний улиралд дулаан өдрийг сонгон усалгааг хийж гүйцэтгэсэн. 2023 онд нийт 3270 м³ усыг зам талбайн усалгаанд зарцуулсан байна.
4	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яаралтай авах, саармагжуулах хэрэгслийг талбайд бэлэн байлгах	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Хөрсөнд нефтийн бүтээгдэхүүний бохирдол, нэвчилт, асгаралт үүсгэхгүй байх арга хэмжээг авч ажилласан байна.	Эрдэнэс алт ресурс ХХК-ийн батлагдсан Байгаль орчны журмуудын хүрээнд нефтийн бүтээгдэхүүн саармагжуулах хэрэгслийг шатахуун станц дээр бүрэн байршуулсан. Одоогоор асгаралт үүссэн тохиолдол бүртгэгдээгүй. Туслан гүйцэтгэгч компаниудад чиглэл өгч, гүйцэтгэлийг газар дээр нь шалгаж тогтмол хяналт тавин ажилласан.
5	Тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд (MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид) болон Олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж, түүнд нийцүүлэх	Уурхайн машин, механизмууд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Холбогдох стандарт дүрэм журмын дагуу хяналт тавин ажилласан байна.	Холбогдох стандарт, дүрэм, журмын дагуу тээврийн хэрэгслүүдэдтэй холбоотой бичиг баримтын бүрдлийг хангуулж, гүйцэтгэлийг тайлагнаж ажилласан.

6	Ашиглагдаж буй машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, агаар бохирдуулсны төлбөрийг төлөх, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Уурхайн машин, механизмууд Уурхайн машин, механизмууд	1'000'000	Техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж ажилласан байна.	“Эрдэнэс алт ресурс” ХХК-ний 17 техник, Сидар ХХК-ний 39 техник, Аглаг хангайн уулс ХХК-ийн 8 техник, Соёолон интернэшнл ХХК-ний 11 техникт үзлэг оношлогоонд бүрэн хамруулсан бөгөөд нийт техникийн үзлэг шалгалтыг өдөр болгон үзлэгийн хуудсаар хийдэг. Засвар үйлчилгээг машин механизмын засварын цехт тухай бүр хийж хэрэгжүүлж ажилласан. Төлөгдөх шаардлагатай төлбөр хураамж зэргийг бүрэн төлсөн. Мөн 2023 оны 10 дугаар сард Дундговь аймгийн тээврийн инженер С.Даваахүү ирж ЭАР ХХК-ний бүх машинд үзлэг шалгалтыг зохион байгуулж ажилласан.
7	Хүдэр бутлах хэсгээс үүсэх тоосжилтыг бууруулж ажиллах талаар туслан гүйцэтгэгч компаниудад шаардлага хүргүүлж ажиллах, тоосжилтыг бууруулж ажиллах	Баяжуулах үйлдвэр, ажилчдын хотхон, хаягдлын сан орчимд	66'000'000	Сар бүрийн гүйцэтгэлийг дүгнэх тайлангийн хурлаар чиглэл өгч, тоосжилтоос сэргийлж бууруулж ажиллана.	Хүдэр бутлах хэсгээс үүсэх тоосжилтыг бууруулж ажиллах талаар шаардлага хүргүүлсний дагуу Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг хариуцдаг туслан гүйцэтгэгч “Соёолон интернэшнл” ХХК нь баяжуулах 2 дугаар үйлдвэрийн конвейрийн хэсэгт ковер суурилуулах ажлыг 2023 оны 04 дүгээр сард эхлэж 5 дугаард сард байршуулж дуусгаж тоосжилтыг бууруулан ажилласан. Мөн шаардлагын дагуу усалгааг тогтмол хийж ажилласан.
Нийт зарцуулсан төсөв			67'000'000		

Зам талбайн усалгаа, арчилгаа:

Замын тоосжилтыг бууруулах зорилгоор дулааны улиралд усалгааг тогтмол хийдэг. Уурхайн доторх болон дэд бүтцийн шугамын дагуух замуудыг дулааны улиралд өдөр бүр, түгээмэл ашиглагддаг замуудад өдөрт 2-3 удаа тоосжилт үүсэхээс сэргийлж усалгааг хийж гүйцэтгэдэг. Хүйтний улиралд дулаан өдрийг сонгон усалгааг хийж гүйцэтгэж байна. 2023 онд нийт **3270 м3** усыг зам талбайн усалгаанд зарцуулсан байна.



Соёолон интернэшнл ХХК нь баяжуулах 2 дугаар үйлдвэрийн канверийн хэсэгт ковер суурилуулах ажлыг 2023 оны 04 дүгээр сард эхлэж 5 дугаард сард байршуулж дуусгасан. Мөн усалгааг тогтмол хийж ажилласан.



ЭАР ХХК-ний 17 техник, Сидар ХХК-ний 39 техник, Аглаг хангайн уулс ХХК-ийн 8 техник, Соёолон интернэшнл ХХК-ний 11 техникт үзлэг оношлогоонд бүрэн хамруулсан бөгөөд нийт техникийн үзлэг шалгалтыг өдөр болгон үзлэгийн хуудсаар хийдэг. Засвар үйлчилгээг машин механизмын засварын цехт тухай бүр хийж хэрэгжүүлж ажилласан. Төлөгдөх шаардлагатай төлбөр хураамж зэргийг бүрэн төлсөн. Мөн 2023 оны 10 дугаар сард Дундговь аймгийн тээврийн инженер С.Даваахүү ирж ЭАР ХХК-ний бүх машинд үзлэг шалгалтыг зохион байгуулж ажилласан.



2.2. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн усны менежментийн бодлогын хүрээнд уурхайн үйл ажиллагаанд усыг зүй зохистой ашиглах, мөн үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулан усны нөөц, чанарыг хэвээр хадгалахыг зорин ажилладаг. Уурхайн зүгээс усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах зорилгын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан.

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал, мян.төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах, төлбөрийг төлөх	Уурхайн хэмжээнд	549'269'847 төгрөг Тайлбар: БОМТ-ний хэрэгжилтийн зардалд оруулаагүй	Ус ашиглах гэрээ, зөвшөөрлийг авч, ус ашигласны төлбөр тооцоог холбогдох хуулийн дагуу төлсөн байна.	Монгол Улсын “Усны тухай хууль”-ийн дагуу Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаатай 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 10 дугаартай ус ашиглуулах гэрээг байгуулсан. Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргааны даргын “Зөвшөөрөл олгох тухай” 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн дугаар 17 албан тоотойр Ус ашиглах зөвшөөрлийг авсан. 2023 оны 11 дүгээр сарын 25-ний өдрийн байдлаар үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрт 549'269'847 төгрөгийг Дундговь аймгийн Татварын хэлтэс, худалдаа хөгжлийн банкны 3220304720676 тоот дансанд төвлөрүүлсэн.
2	Хаягдал усны дүгнэлтийг гаргуулж, төлбөрийг төлөх, Хаягдал усны зөвшөөрөлд сунгалт хийлгүүлэх	уурхайн хэмжээнд		Хаягдал усны дүгнэлтийг гаргуулж тооцоог холбогдох хуулийн дагуу төлсөн байна.	Хаягдал усны дүгнэлтийг 2023 оны 02 дугаар сарын 7-нд Усны газраар гаргуулан авсан. 2023 оны нийт ус бохирдуулсны төлбөр 31,111.533 төгрөг болсон. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн сунгалтыг 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаанаас авсан.


3	Усны бүх эх үүсвэрийг тоолууржуулах, орон нутгийн төрийн захиргааны болон бусад холбогдох байгууллагуудад хандаж, баталгаажуулах, нэмэлт тоолуур суурилуулах шаардлага үүссэн тохиолдолд суурилуулах	Уурхайн гүний худгууд, усан сангийн байгууламж	1'720'000	Орон нутгийн төрийн захиргааны болон бусад холбогдох байгууллагуудад хандаж, баталгаажуулсан байна.	Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг дахь “Салхит” уурхайн худаг, усан сангуудын тоолуурын заалтыг тус бүрээр зурагжуулж тулган баталгаажуулж, актаар хүлээлгэн өгөх ажлыг Гурвансайхан сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч Г.Алтангэрэл, Татварын улсын байцаагч Д.Загдсүрэн, “Эрдэнэс силвер ресурс” ХХК-аас Байгаль орчны мэргэжилтэн Ш.Намсрайжав, сантехникч Б.Төрбат, усны техникч Э.Эрхэмбаяр, “Соёолон интернэшнл” ХХК-ний дэд бүтцийн инженер И.Чулуунбаатар, “Аглаг хангайн уулс” ХХК-ний дулааны инженер С.Мөнхбаатар нарыг байцуулан баталгаажуулж, зурагжуулж ажилласан. Тоолуурын актыг 2023 оны 1 дүгээр сарын 02-ны өдөр ашиглаж буй худаг, усан сангийн тоолуурыг тавьж зургаар баталгаажуулж тооцоо нийлсэн акт үйлдсэн.
4	Эзэмшлийн худгууд болон ойр хавийн малчдын усалгааны худгийн усны түвшин, ундарга хэмжих	Уурхайн гүний худгууд, малчдын хэрэглээний бэлчээрийн худгууд	2'800'000	Түвшинг хэмжсэн байна.	2023 онд түвшин хэмжигчийг шинээр захиалан авч баяжуулах үйлдвэр 1-ийн үйл ажиллагаанд ашигладаг 4-р худаг, 6-р худаг, 7-р худаг, 8-р худаг, 11-р худаг, 12-р худгууд болон Баяжуулах үйлдвэр 2-ийн үйл ажиллагаанд ашигладаг 1-р худаг, 2-р худаг, 3-р худаг, 5-р худаг, 9-р худаг, 10-р худгууд долоо хоног бүрийн лхагва гаригт усны түвшин, ундаргын хэмжилтийг тогтмол хийсэн. Нийт 12 худагт 2023 онд 542 удаа ундарга болон түвшний хэмжилтийг хийсэн.
5	Өөрийн эзэмшлийн болон орчин тойрны гүний болон малчдын хэрэглээний гар худгуудад хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу	Өөрийн эзэмшлийн болон орчин тойрны худгуудад	9'000'000	Ундны усны чанарыг тодорхойлох	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 1, 2, 3 дугаар улирлын ус, хөрс, агаарын дээжүүдийг усны хяналтын төв лабораторт хүргүүлж шинжлүүлж ажилласан. Тус ажлын хүрээнд хамтын оролцоот байгаль орчны мониторингийг хэрэгжүүлж нутгийн иргэдийг

	шинжилгээ хийлгэх				оролцуулж хамтран ажилласнаараа онцлог ажил болсон. Ингэснээр нутгийн иргэдэд зөв, бодит мэдээлэл олгох цаашид хамтран ажиллахад үл ойлголцлын асуудал багасах давуу талтай.
6	Хөрсний усны түвшинд өөрчлөлт гарч буй эсэхийг хянах, хэмжилт хийх	Хяналтын цооногуудад	ОХШХ-ийн төлөвлөгөөний зардалд тусгагдсан	Усны түвшний талаарх мэдээлэл тодорхойлогдсон байна	<p>Хаягдлын далангийн химийн бодисоор бохирлогдсон аюултай хаягдал байгальд асгарч хөрсөнд нэвчилт үүсэхээс урьдчилан сэргийлж 1, 2 дугаар хаягдлын далангийн өргөтгөлийн ажил гүйцэтгэж байгаа PSST ХХК-д 2023 оны 07 дугаар сарын 22-ны өдөр хугацаатай албан шаардлага хүргүүлсний дагуу хөрсний хүнд металлын судалгааг Грийн солюшн консалинг ХХК нь хөрсний 5 цэг /зүсэлтийн аргаар/, усны 2 цэг /DUSTARK багажаар хэмжив/ цэгээс нийт 18 дээжийг Д.Сувд, Б.Энхбаяр, Б.Тунсаг бүрэлдэхүүнтэй 2023 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр ирж ажилласан. Мөн ажлын тайланг авсан.</p> <p>Шинээр ашиглалтанд орсон хаягдлын далангийн байгаль орчны цооног ерөмдөх ажлыг “Гранд холдинг” ХХК 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр ерөмдөж хүлээлгэн өгсөн.</p> <p>Хяналт шалгалтын хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны хяналтын цооногуудаас 2023 онд нийт 3 удаагийн усны дээжийг итгэмжлэгдсэн хяналтын лабораторт шинжлүүлэх ажлыг зохион байгуулсан.</p>
			13'520'000		

УСНЫ БИЧИГ БАРИМТЫН БҮРДЛҮҮД

Ус ашиглах гэрээ, дүгнэлт:

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь 2023 онд Монгол Улсын “Усны тухай хууль”-ийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Усны газраар Ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж, уг дүгнэлтэд үндэслэн Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаатай 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 10 дугаартай Ус ашиглуулах гэрээг байгуулсан.



Ус ашиглах гэрээний мэдээлэл:

Гэрээний дугаар	Хугацаа	Эхлэх	Дуусах
Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаатай гэрээг байгуулсан. 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр дугаар 10	2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр	2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс	2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Ус ашиглах зориулалт:

2023 онд 3'471.6 мян.м³ хөрс хуулж, 600 мян.хүдэр олборлон (үүний 252.0 мян.тн-ыг баяжуулах 1-р үйлдвэрт, 348.0 мян.тн-ыг баяжуулах 2-р үйлдвэрт) баяжуулж, Унд, ахуйн хэрэглээнд ашиглах 25393.5 м³ усыг төлбөрөөс чөлөөлсөн.

- Газрын доорх усны авхан зайлуулсны төлбөр 27,753м³/жил x 888.0 төг/м³=24'644'664 төгрөг
- Ашигт малтмал баяжуулахад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр 1.0 м³ газрын доорх усны үнэ: 3700.0 төг/м³ x 35% x 1.8=2331 төг/м³
302'943 м³/жил x 2331 төг/м³=706'160'130.0 төгрөг

Нийт төлбөр=706'160'130.0 төгрөг+24'644'664 төгрөг=730'804'797 төгрөг

“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн усны менежментийн бодлогын хүрээнд уурхайн бүх үйл ажиллагаанд усыг зөв зохистой хэрэглэх, усыг дахин ашиглах, мөн үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах байгаль дахь усны нөөц, чанарыг хэвээр хадгалахыг зорин ажилладаг.

2023 оны ус ашиглах дүгнэлтээр нийт **356'089.5 м³** ус ашиглахаар тусгасан бөгөөд 2023 оны 11 дүгээр сарын 25-ний өдрийн байдлаар **235637 м³** усыг үйлдвэрлэлийн хэрэгцээнд, уурхайн унд ахуйн хэрэгцээнд **9035 м³** хэрэглсэн. Мөн ногоон байгууламжины усалгаанд **2100 м³**, зам талбайн усалгаа арчилгаанд **3270 м³** шүүрлийн усыг авч ашигласан байна.

Ус ашиглах дүгнэлтийн хэрэгжилт

2023 оны ус ашиглах дүгнэлтээр тооцсон хэмжээ болон 2023 оны ус ашигласан хэмжээг доорх хүснэгтээс харна уу. /Хүснэгт/

Д/д	Гэрээ, УАДүгнэлтэд тусгагдсан зүйл заалтын дагуу хүлээсэн үүрэг	Гүйцэтгэл
1	Усны тухай хуулийн 28.6-д заасныг үндэслэн Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу ус ашиглах гэрээ байгуулах	Монгол Улсын “Усны тухай хууль”-ийн дагуу Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаатай 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 10 дугаартай ус ашиглуулах гэрээг байгуулсан. Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргааны даргын “Зөвшөөрөл олгох тухай” 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн дугаар 17 албан тоотойр Ус ашиглах зөвшөөрлийг авсан.
2	Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус татах шугам хоолой бүрд тоолуур суурилуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх	Уурхайн гүний худгийг тоолууржуулж, ашиглалтын хэрэглээнд хяналт тавих, усны төлбөр хураамжийг бодитойгоор тооцох, үндсэн болон гэрээт компаниудын үйлдвэрлэлийн болон ахуйн бусад хэрэглээний ус ашиглалтыг бодитойгоор тооцох, хяналт тавих зорилгоор тоолууруудыг Гурвансайхан сумын байцаагч нартай тооцоо нийлсэн акт үйлдэж улирал бүрээр тооцоог хийж ажилласан. Нийт 549'269'847 төгрөг төсөвт төвлөрүүлж ажилласан.
3	Жил бүрийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх	Дундговь аймгийн Гурвансайхан сумын Салхит орд (Баяжуулах, боловсруулах үйлдвэр)-ийн 2023 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг тодотгон батлуулж үйл ажиллагаа явуулсан.
4	Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг	Усыг зөвшөөрсөн хэмжээнээс үйлдвэрт илүү ашиглаагүй болно.

	анхаарах	
5	Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу баталгаажуулсан тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 26.3.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх	Усны тоолууруудын заалтыг сар бүр зургаар баталгаажуулан Дундговь аймгийн Гурвансайхан сумын Байгаль орчны болон Татварын байцаагч нарт хүргүүлэн тоолуурын заалтын дагуу төлбөрийг тухай бүрт төлсөн. 2023 онд нийт 549'269'847 төгрөгийг усны төлбөрт төлсөн.
6	Үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед сав газрын захиргаа болон төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэх	УГТХДТСав газрын захиргааны төлөөллүүд уурхайн үйл ажиллагаанд 3 удаагийн хяналт шалгалт хийгдсэн бөгөөд ус ашиглалттай холбоотой асуудлаар тухай бүр холбоотой ажилласан. Мөн уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаанд нэмэлтээр зөвшөөрөл авч өрөмдөх 3 газруудын талаар мэдээлэл солилцож, орон нутгийн мэргэжлийн байгууллага, холбогдох байцаагч нарыг байлцуулан худаг, устай холбоотой зөвшөөрлийн асуудлуудыг яаралтай шийдвэрлэж ажилласан. Худаг, усан сангуудын газруудыг Гурвансайхан сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж газрын зөвшөөрлийг авч ажилласан.
7	Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан (усны хяналт шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г “Усны газар”-т болон сав газрын захиргаанд хүргүүлэх	Тайлангийн хавсралтаар орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн усны хяналт шинжилгээний хариу, ус ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын гэрээ, зөвшөөрөл, тоо хэмжээ, худгуудын 1-11 дүгээр сарын литр секундэн тооцооны акт, усны 1-11 дүгээр сарын актыг бусад устай холбоотой бүх төрлийн бичиг баримтыг хавсаргав.

2023 онд ашигласан усны хэмжээ

№	Ус ашиглалтын төрөл	Эх үүсвэр	Ашигласан усны хэмжээ
1	Үйлдвэрлэлийн хэрэглээнд ашигласан ус	Гүний худгууд, усан сангаас авч ашигласан.	235'637 м³
2	Унд ахуйд ашигласан ус		9035 м³
3	Зам талбайн усалгаанд ашигласан ус	Шүүрлийн уснаас авч хэрэглэсэн.	3270 м³
4	Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаанд		2100 м³

ашигласан ус	
НИЙТ АШИГЛАСАН УСНЫ ХЭМЖЭЭ	250'042 м³

Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээ, тайлан:

Баяжуулах үйлдвэр нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар **551'712 тн** хүдэр боловсруулж 11'291.3 тн баяжмал үйлдвэрлэсэн байна.

2023 ОНЫ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

№	Үйлдвэрлэлийн мэдээ	2023 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар
1	Ил уурхайн нийт олборлосон хүдрийн материал буюу уулын цул /хөрс, хүдэр нийлсэн хэмжээ/ (мян/м3) Үүнээс:	1'975'800 мян/м³
2	Боловсруулсан хүдэр (мян/тонноор)	551'712 тн
3	Үйлдвэрлэсэн баяжмал (мян/тонноор)	11'291.3 тн

Ил уурхайн шүүрлийн усны ашиглалт

2023 оны төлөвлөгөөний дагуу ил уурхайн устай хэсэгт нэвтрэлт явуулаагүй бөгөөд карьерт газрын доорх ус шүүрэн орж ирээгүй, түвшин нэмэгдээгүй болно. Тус карьерт үүссэн байсан усыг шавхаж, ногоон байгууламж, зам талбайн усалгаа арчилгаанд ашигласан болно. 2023 онд нийт **5370 м³** шүүрлийн усыг авч ашигласан байна.

УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР



2023 оны 11 дүгээр сарын 25-ний өдрийн байдлаар үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрт **549'269'847** төгрөгийг Дундговь аймгийн Татварын хэлтэс, худалдаа хөгжлийн банкны **3220304720676** тоот дансанд төвлөрүүлсэн байна. /Төлбөрийн задаргааг доор хүснэгтээр харуулав/

№	Хугацаа	Мөнгөн дүн
1	1 дүгээр улирал	128'689'848
2	2 дугаар улирал	97'659'576
3	3 дугаар улирал	188'048'763
4	10 дугаар сар	66'617'649
5	11 дүгээр сар	68'254'011
	Нийт	549'269'847

1.8. Үйлдвэрлэлийн хэрэглээнд ашигласан усны хэрэглээ:

/2023 оны 11 сарын 25-ны байдлаар/

Огноо 2023 он	Баяжуулах үйлдвэрүүдэд ашигласан усны хэрэглээ
1-р сар	28932 м ³
2-р сар	18555 м ³
3-р сар	7721 м ³
4-р сар	9884 м ³
5-р сар	10691 м ³
6-р сар	21321 м ³
7-р сар	30918 м ³
8-р сар	27978 м ³
9-р сар	21777 м ³
10-р сар	28579 м ³
11-р сар	29281 м ³
Нийт дүн	235'637 м³




Худгуудын усны ундрагын хэмжилтүүд


Баяжуулах үйлдвэр №1-ийн үйл ажиллагаанд ашигладаг 4-р худаг, 6-р худаг, 7-р худаг, 8-р худаг, 11-р худаг, 12-р худгуудад долоо хоног бүрийн лхагва гаригт усны ундаргын хэмжилтийг хийдэг. Худгуудын усны ундаргыг доорх графикаас харна уу









9-р худаг




10-р худаг






Хаягдлын сангийн өргөтгөлийн ажил

1, 2 дугаар хаягдлын сангийн эзлэхүүн 350 мян.м³ багтаамжтай бөгөөд “ПИ ЭС ЭС ТИ” ХХК гүйцэтгэж хүлээлгэн өгсөн.



УСАН ХАМГАМЖИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

Умард Гүвээт-халхын дундад талын сав газрын хамгаалалтын захиргаа, Дундговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас 2023 онд нийт 3 худгийн зөвшөөрөл авсан.



Худаг гаргах цэгийг “Жи И энд Си” ХХК-аар хийлгүүлж тодорхойлуулсан.



Худаг гаргах ажлыг Гранд хойлдинг дриллинг ХХК гүйцэтгэж байна.



Худаг усан сан, худгуудыг “Соёолон интернэйшнл” ХХК, “Аглаг хангайн уулс” ХХК хувааж хариуцуулан хүлээлгэн өгч засвар үйлчилгээг тухай бүрт нь хийлгүүлж ажилласан.



2.3. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Олборлолт нэмэгдэх бүрт шимт хөрсийг хуулж, тусгай талбайд стандартын дагуу байршуулж, хэлбэржүүлж хамгаалах	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Шимт хөрсний чанарыг хамгаалсан байна.	Уурхайн хаягдлын овоолгыг тэлэх, зам талбай шинээр байгуулах, хаягдлын сан, тохижилт бүтээн байгуулалт, хүдрийн талбай бэлдэх ажлуудыг гүйцэтгэхээс өмнө шимт хөрсийг хуулахдаа стандартын дагуу хуулж 2 шимт хөрсний овоолгод тээвэрлэж төвлөрүүлсэн. 2023 онд нийт 5 удаагийн шимт хөрс хуулах зөвшөөрлийг уулын ажлыг хариуцан үйл ажиллагаа явуулж байгаа туслан гүйцэтгэгч “Сидар” ХХК-д өгч нийт 57392.09 м ³ шимт хөрсийг 2 дугаар шимт хөрсний овоолго дээр төвлөрүүлж ажилласан. Мөн шимт хөрсний стандартын дагуу 5 метрээс хэтрэхгүй хэлбэршүүлэх ажлыг хийж гүйцэтгүүлсэн.
2	Техникийн эвдрэл гэмтлийг зориулалтын талбай (засварын цех)-д байрлуулж засах	-	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Хөрсний бохирдлоос сэргийлэн ажилласан байна.	ЭСР ХХК-ний 17 техник, Сидар ХХК-ний 39 техник, Аглаг хангайн уулс ХХК-ийн 8 техник, Соёолон интернэшнл ХХК-ний 11 техникт үзлэг шалгалтыг өдөр болгон үзлэгийн хуудсаар шалгадаг. Уурхайн том оврын машин механизмын засварын цех ажиллаж байгаа бөгөөд туслан гүйцэтгэгч “Сидар” ХХК-д хариуцуулан ажиллуулдаг. Уурхайн засварын цех нь 30 метрийн урттай, 8 метрийн өргөнтэй, 6 метрийн өндөртэй сэндвич нь барилга байгууламжтай. Гадна болон дотор талбайн бетонон талбайтай. Компанийн батлагдсан Байгаль орчны журмуудын дагуу тогмол хяналт тавин ажилладаг.
3	Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт хуримтлал ихээр үүссэн тохиолдолд	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Ахуйн хог хаягдлыг холбогдох хуулийн дагуу ангилан ялгаж,	Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа дахин ашиглагдах боломжгүй хог хаягдлыг Гурвансайхан сумын хогийн цэгт төвлөрүүлэх ажлыг 2023 онд дампаар 7 удаагийн тээвэрлэлт, шланзаар 2 удаагийн тээвэрлэлтээр нийт 290 тонн ахуйн дахин боловсруулах боломжгүй хогийг Гурвансайхан сумын төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж

	зөөвөрлөн хаяж байх			тээвэрлэж төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн байна.	ажилласан.
4	Шимт болон шимэрхэг хөрсийг алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, хадгалах талбайг зөв тодорхойлох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих	Уурхайн үйл ажиллагааны талбайн хэмжээнд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Холбогдох стандартын дагуу шимт хөрсийг хадгалах	Уурхайн хаягдлын овоолгыг тэлэх, зам талбай шинээр байгуулах, хаягдлын сан, тохижилт бүтээн байгуулалт, хүдрийн талбай бэлдэх ажлуудыг гүйцэтгэхээс өмнө шимт хөрсийг хуулахдаа стандартын дагуу хуулж шимт хөрсний овоолгод тээвэрлэж төвлөрүүлэх ажилд хяналт тавьж ажилласан. 2023 онд нийт 5 удаагийн шимт хөрс хуулах зөвшөөрлийг уулын ажлыг хариуцан үйл ажиллагаа явуулж байгаа туслан гүйцэтгэгч Сидар ХХК-д өгч нийт 57392.09 м ³ шимт хөрсийг 1, 2 дугаар шимт хөрсний овоолго дээр стандартын дагуу хэлбэршүүлж төвлөрүүлж ажилласан.
Нийт: 500'000 төгрөг					

1. ХӨРС ХУРДАС, ЛАГ ХАГШААС

1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт байрлах "Салхитын мөнгөний" ил уурхайн хаягдлын сан орчмын хөрсний болон санд хуримтлагдсан лаг хагшаасны хортой ба био идэвхт хүнд металлын өнөөгийн агууламжийг тодорхойлох, үр дүнг хөрс бохирдүүлэгч бодис элементийн MNS 5850:2019 стандарттай харьцуулах, улмаар сангийн өргөтгөл шинэчлэлтийн бүтээн байгуулалтын ажлын үйл ажиллагаанаас шалтгаалан хаягдлын сангийн лаг хагшааснаас хөрсний гүнд бохирдол үүсгэсэн эсэх дүгнэлт гаргана.

1.2 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Багаж хэрэгсэл: Хөрсний талбайн судалгаанд хүрз, метр, дээжний уут, дээжний хутгуур, фото аппарат, GPS, 10%-ийн давсны хүчлийн уусмал зэрэг багаж хэрэгсэл ашигласан. Гүний зүсэлтүүдийг тухайн талбайд ажиллаж байсан экскаватор трактор ашиглан хийж гүйцэтгэсэн.

Талбайн судалгаа ба хөрсний дээж авалт: Судалгааны талбайд хөрсний хээрийн судалгаа буюу дээж авалт болон ажиглалт хэмжилтийг 2023.09.1-д хийж гүйцэтгэсэн. Нийт судалгааны талбайн хэмжээнд хөрсний хэмжилт дээжлэлтийг 3 цэгт (Хүснэгт 1, Зураг 1) шимт хөрсний буюу 0-30, 40-90 хүртэлх гүнүүдээс, гүний дээжлэлтийг 2 цэгт 2.5 метр гүнтэй хийж нийт 12 ширхэг дээж авсан. Мөн хаягдлын сангийн гүний усны мониторингийн 2 цооноогоос усны дээж авсан. Хөрсний хүнд металлын дээжийг холимог байдлаар авсан. Дээжийг авахдаа "Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990" стандартыг баримталсан. Хөрсний болон усны дээжлэлт хийсэн цэгүүдийн талаарх мэдээллийг Хүснэгт 1- Т тусгав.

Хүснэгт 1. Хөрсний дээж авсан цэгийн ерөнхий мэдээлэл

Цэгийн дугаар	Дээж авсан газар	X	Y
Шимт хөрс-1	Хаягдлын сангийн урд хэсэг	106.996418	45.845888
Шимт хөрс-2	Хаягдлын сангийн хойд хэсэг	106.99793	45.84967
Шимт хөрс-3	Хаягдлын сангийн хойд хэсэг	107.000313	45.85151
Зүсэлт-1	Хаягдлын сангийн зүүн хойд хэсэг	106.998547	45.847288
Зүсэлт-2	Хаягдлын сангийн зүүн урд хэсэг	106.997531	45.846139
Хагшаас-1	Хаягдлын сангийн лаг	106.99685	45.846571
Хагшаас-2	Хаягдлын сангийн лаг	106.997477	45.847246
Хагшаас-3	Хаягдлын сангийн лаг	106.996822	45.847808
Цооног-1	Хаягдлын сангийн мониторинг цооног	106.997528	45.849534
Цооног-2	Хаягдлын сангийн мониторинг цооног	106.999299	45.85045

Лабораторийн задлан шинжилгээ: Талбайгаас авсан шимт хөрсний дээжүүдэд хими-физикийн шинж чанарын ерөнхий үзүүлэлтүүдийг ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лабораторид доорх аргаар тодорхойлов. Үүнд:

№	Хөрсний үзүүлэлтүүд	Задлан шинжилгээний арга
1	Ялзмагийн бодис	Тюрин
2	Органик нүүрстөрөгч	Шатаалтын алдагдал
3	Урвалын орчин (pH)	Потенциометрийн (H ₂ O, 1:2.5)
4	Карбонат	Эзлэхүүний
5	Цахилгаан дамжуулах чанар (EC)	Ионометр
6	Хөдөлгөөнт фосфор	Спектро фотометр
7	Хөдөлгөөнт кали	Дөлт фотометр

Хөрсөн дэх болон усан дахь онцгой хортой (As, Cd, Cr, Pb) ба хортой био-идэвхт (Cu, Co, Mo, Ni, Sr, V, Zn) элементүүдийг магадлан итгэмжлэгдсэн KhanLab олон улсын лабораторид ICP40B аргазүйгээр Optical Spectrometer (OS)-ийн багажаар тодорхойлсон.

Зураглал: Хөрсний дээж авсан цэгүүдийн байршлын зураглалыг хийхдээ Газарзүйн Мэдээллийн Системийн ArcGIS 10.4.1 программ дээр хийж гүйцэтгэсэн. Хэвлэлийн эхийг А4 хуудсан дээр 1:7500 масштабтай бэлдсэн.

1.3 СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1.3.1 Судалгааны талбай ба хөрсний онцлог


Судалгааны талбай (хаягдлын сан) нь үүрхэйн баруун урд байрлах бөгөөд нам толгод болон тэдгээрийн өргөн хормой бэл бүхий д.т.д 1384-1427 м өндөртэй, нөлөөлөлд өртөөгүй газруудад 2-10 градус, сангийн далан болон суваг шуудуу, хөрсний овоолго бүхий газруудад 20-70 градус эгц хэвгий гадаргатай байна. Судалгаанд хамрагдсан талбайд Монгол орны хөрсний ангиллаар Цайвархүрэн хөрсний дэд хэв шинжид багтах элсэрхэг, мараалаг болон сайргархаг төрлийн хөрснүүд дангаараа болон бүрдэл байдлаар тархсан байна (Зураг 1). Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин маш бага, шимт үе давхарга нь нимгэн (0-30 см), хэврэгдүү бөөмөрхөг болон үйрмэг бүтэцтэй, механик нөлөөлөлд тэсвэр муутай, байгалийн аясаараа нөхөн сэргэх чадамж сулавтар байдаг онцлогтой. Хөрсний үе давхарга нь ихэвчлэн А-В-ВС-С гэсэн дараалалтай, хөрсний дээд үе давхаргын (0-30 см) ялзамагийн агууламж 1.2-1.3%, дээд үе давхарга карбонатжилтгүй, урвалын орчин 8.5-9.0 буюу хүчтэй шүлтлэг, хялбар уусах давожилт хөрсний бүх үе давхаргад маш сүл (0.02-0.07 dS/m) агууламжтай байна. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд том ширхэгтэй элсэн фракц зонхилсон элсэнцэр бүрэлдэхүүнтэй байна (Хүснэгт 2, Хүснэгт 3). Энд шимт хөрсний шинжилгээний үр дүнг зөвхөн ердийн хөрсний нөөц болон экологийн засгийн суурь үнэлгээг тооцоход ашиглах зорилгоор шинжилгээ хийлгэсэн болно.

Хүснэгт 2. Шимт хөрсний химийн шинж чанар

Дээжний дугаар	Гүн, см	pH _{H2O} (1:5)	CaCO ₃ %	Ялмаг, %	EC _{1:5} dS/m	Хадалгөөнт, мг/100г	
						P2O5	K ₂ O
Шимт хөрс-1	0-40	8.91	0.00	0.82	0.072	1.12	10.5
	40-90	9.56	3.39	0.16	0.073	0.44	8.6
Шимт хөрс-2	0-30	8.76	0.00	1.32	0.034	1.53	16.7
Шимт хөрс-3	0-30	8.49	0.00	1.24	0.028	1.38	14.3

Хүснэгт 3. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүн

Дээжний дугаар	Гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)			Нэршил
		Элс (2-0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (< 0.002мм)	
Шимт хөрс-1	0-40	70.2	14.5	15.3	Элсэнцэр
	40-90	74.6	10.2	15.2	Элсэнцэр
Шимт хөрс-2	0-30	74.6	11.7	13.7	Элсэнцэр
Шимт хөрс-3	0-30	79.0	8.1	13.0	Нарийн элс



Зураг 1. Тамбайнуудын хөрсөн бүрхэвч ба газар шилжилт

1.3.2 Дээж авсан цэгүүдийн хөрсний гадаргын ба үе давхаргын морфологи шинж чанар

Гүний зүсэлт-1: 2: Гүний зүсэлтүүдийг шинэчлэн өргөтгөж буй хуучин сангийн зүүн хойд болон зүүн урд хэсгийн лаг хагшаастай залгаа газруудад сонгож гадаргаас доошоо 2-2.5 м гүнтэйгээр ухаж хийсэн (Зураг 2, Зураг 3). Эдгээр гүний зүсэлтүүд нь сангийн өргөтгөл баригдаж байгаа талбайд байрлах учраас шимт хөрсний хуулалт бүрэн хийгдсэн буюу хөрс үүсгэгч байгалийн үндсэн хурдас чулуулагтай байна. Өнгөний хувьд бор шаргал, хар бараанаас цайвар саарал өнгөтэй, ширхгийн хувьд нарийн элс хайрганаас эхлэн том хэмжээтэй чулуу хүртэлх харилцан адилгүй хэмжээтэй байна. Эдгээр гүний зүсэлтүүдэд ил харигдахуйц шүүрлийн үс байхгүй, зөвхөн бага зэрэг өлөн чийгтэй байгаа нь хаягдлын сангийн лаг хагшааснаас шалтгаалж гүн рүү үс алдагдаагүйг эхний ээлжид баталж байна. Мөн түүнчлэн эдгээр зүсэлтүүдийн үе давхаргыг ажиглаж харахад лаг хагшааснаас гаралтай нь шаргалдуу өнгөтэй, нарийн ширхэгтэй тоосорхог болон шаварлаг материалтай огт харагдахгүй байна.



Зураг 2. Гүний зүсэлт-1 цэгийн гадаргын ба үе давхаргын төлөв



Зураг 3. Гүний зүсэлт-2 цэгийн гадаргын ба үе давхаргын төлөв

Лаг хагшаас: Хаягдлын санд хуримтлагдсан лаг хагшаас нь бор шаргал өнгөтэй, нарийн тоосорхог болон шаварлаг механик бүрэлдэхүүнтэй, гадарга хэсгийн хатаж хуурайшсан хэсгээрээ давсны цагаан өнгөр тогтсон, призм хэлбэр үүсгэн хагарч бутарсан байдалтай байна. Сан руу хаягдал нийлүүлдэг хэсэг рүү дөхөх тусам чийг нь ихсэж нялцгай шаварлаг болно. Зах хэсгээрээ буюу сангийн зүүн, зүүн урд хэсгийн лаг нь сайн хатаж бэхэжсэн учраас хүн гишгэхэд цөмрөхгүй байсан.



Зураг 4. Лаг хагшаасны төв хэсгийн гадаргын төлөв



Зураг 5. Лаг хагшаасны зах хэсгийн гадаргын төлөв



Зураг 6. Хаягдлын сангийн гүний усны мониторингийн цооног

1.3.3 Хөрс хурдас, лаг хагшаас болон гүний усны хүнд металлын өнөөгийн түвшин

Хөрсөн дэх хортой хүнд металл гэдэгт дараах 12 элемент багтана. Үүнд: Хар тугалга (Pb), кадмий (Cd), хүнцэл (As), хром (Cr), молебден (Mo), цайр (Zn), кобальт (Co), никель (Ni), зэс (Cu), стронций (Sr), ванадий (V) орно, цагаан тугалга (Sn). Эдгээрээс As, Cd, Cr, Pb нь онцгой хортой, Co, Cu, Mo, Ni, Sn, Sr, V, Zn нь хортой био-идэвхт хүнд металлууд гэж үздэг. Онцгой хортой хүнд металлууд нь амьд организмд учруулах хор нөлөөлөл ихтэй, амьд организмд их хэмжээгээр орсон тохиолдолд өвчин үүсгэх улмаар үхүүлэх хүртэл аюултай байдаг. Харин хортой био-идэвхт


хүнд металлууд нь хоруу чанарын хувьд онцгой хортой хүнд металлуудаас арай бага, тодорхой хэмжээгээр амьд организмд байх ёстой боловч амьд организмд их хэмжээгээр хуримтлагдвал эндемик буюу орогномол өвчин үүсгэдэг аюултай. Судалгааны талбайгаас авсан дээжинд агуулагдах хүнд металлуудын агууламжийг (Хүснэгт 4) харуулав. Судалгааны үр дүнг МУ-ын "MNS5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ" стандартад заасан хөрсний органик биш (хүнд металл) бохирдуулагч бодисуудын хүлцэх агууламж, уул уурхайн бүсэд зөвшөөрөгдөх дээд хэмжээ болон стандартын аюултай түвшинтэй харьцуулав. Хүнд металлын шинжилгээний үр дүнгээс үзэхэд хаягдлын сангийн лаг хагшаасанд As, Cu, Pb, Zn гэсэн 4 металл маш их агууламжтай, мөн мөн хортой биш элементүүдээс сурьма (Sb) нэлээд их агууламжтай гарсан байна (Зураг 7, Зураг 8, Зураг 9, Зураг 10). Харин лаг хагшааснаас доошоо гүний нэвчилт алдрал байгаа эсэхийг шалгахар хийсэн 2 үндсэн зүсэлтүүдээс авсан дээжүүдэд эдгээр 4 металл болон бусад металлууд хэвийн түвшинд, сурьмагийн агууламж маш бага байна (Хүснэгт 4). Гүний усны мониторинг цооногуудаас авсан дээжүүдэд хийсэн шинжилгээний үр дүнгээс харахад урвалын орчин, нийт хатуулаг болон анион катионууд зэрэг усны ерөнхий химийн үзүүлэлтүүд хэвийн түвшинд байна. Усанд агуулагдах хүнд металлуудаас As, Pb-ийн агууламж хүлцэх хэмжээнээс бага зэрэг өндөр, бусад металл хэвийн түвшинд байна. Энд лаг хагшаасан өндөр агууламжтай байсан Cu, Zn гэсэн металлууд усанд маш бага агууламжтай байна (Хүснэгт 5).

Хүснэгт 4. Хөрс хүрдасны хүнд металлуудын агууламж


ДЭЭЖИЙН ДУГААР	ЭЛЕМЕНТ, мг/кг											
	As	Cd	Co	Cr	Cu	Mo	Ni	Pb	Sb	Sr*	V	Zn
Хагшаас-1	735.3	2.66	9.65	37.25	416.8	8.72	10.11	654	123.5	129.3	76.68	544.8
Хагшаас-2	293.0	1.25	5.27	9.82	302	<5.0	<5.0	468.1	35.3	97.94	29.95	309.2
Хагшаас-3	528.9	2.19	7.53	24.29	387	<5.0	8.99	629.5	84.55	147	57.19	465.1
Зүсэлт-1,50см	23.2	<1.0	4.45	10.52	7.54	<5.0	10.91	24.23	<10.0	226.2	29.67	45.84
Зүсэлт-1, 100см	22.4	<1.0	4.6	12.66	6.04	<5.0	6	19.99	<10.0	241.5	32.85	46.68
Зүсэлт-1, 150см	22.6	<1.0	5.92	11.72	7.76	<5.0	10.54	24.63	<10.0	202.2	36.24	67.13
Зүсэлт-1, 200см	17.1	<1.0	9.04	11.86	10.87	<5.0	6.22	103.4	<10.0	98.18	102	337
Зүсэлт-2, 50см	48.7	1.03	33.15	42.2	35.27	<5.0	35.97	82.45	<10.0	182.5	94.35	116.1
Зүсэлт-2, 100см	59.0	1.46	45.62	45.83	35.75	<5.0	58.24	80.52	<10.0	155.4	116.7	118.3
Зүсэлт-2, 150см	61.3	2.3	44.65	27.76	21.98	<5.0	61.03	64.82	<10.0	166.3	98.6	89.5
Зүсэлт-2, 200см	49.0	1.88	15.52	20.41	11.17	<5.0	16.52	27.05	<10.0	203.3	81.13	167.1
Зүсэлт-2, 250см	105.3	1.23	21.77	5.85	18.09	<5.0	13.39	37.74	<10.0	275.9	159.4	331.8
Хүнд металлын агууламж	20	3	50	150	100	5	150	100	-	800	150	300
Гүний усны бүсийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	50	10	500	400	500	20	1000	500	-	3000	600	1000
Аюултай агууламж	100	20	1000	1500	1000	50	1000	1200	-	6000	1000	1000

Хүснэгт 3. Хаягдлын сангийн түүний мониторинг цооногийн усны хими шинж ба гүнд металлын агууламж

Шинжилгээний үзүүлэлтүүд	НЭГЖ	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН		ЗӨВШӨӨРӨГДӨХ хэмжээ /MNS 0900:2018/
		1-р цооног	2-р цооног	
pH		7.42	7.28	6.5-8.5
Кали (K ⁺)	мг/л	0.71	1.33	-
Натри (Na ⁺)	мг/л	135.60	119	200
Кальци (Ca ²⁺)	мг/л	50.60	67.07	100
Магни (Mg ²⁺)	мг/л	33.08	42.93	30
Аммони (NH)	мг/л	0.11	0.13	1.5
Хлорид (Cl)	мг/л	103.80	100.1	350
Сүльфат (SO ₄)	мг/л	149.2	169.5	500
Нитрит (NO ₂)	мг/л	0.06	0.3	1
Нитрат (NO ₃)	мг/л	2.14	2.56	50
Карбонат (CO ₃ ²⁻)	мг/л	9	6	-
Гидрокарбонат (HCO ₃ ²⁻)	мг/л	256.3	341.7	-
Тягт Халууллаг	мг-эв/л	3.25	6.68	7
Хуурай улсжлал: TSS	мг/л	643	704	1000
Цахиурын хүчил, H ₂ SiO ₃	мг/л	27.27	22.85	-
Исэлдэх чадвар (KMnO ₄)	мгO ₂ /л	2.56	4.0	-
Мөнгө, Ag	мг/л	<0.01	<0.01	0.1
Хөнгөнцагаан, Al	мг/л	<0.025	<0.025	0.5
Мышьяк, As	мг/л	0.02	<0.01	0.01
Бор, B	мг/л	0.3	0.3	2.4
Бари, Ba	мг/л	0.02	0.05	0.7
Берелли, Be	мг/л	<0.001	<0.001	0.0002
Висмут, Bi	мг/л	<0.01	<0.01	-
Кадми, Cd	мг/л	<0.005	<0.005	0.003
Кобальт, Co	мг/л	<0.001	<0.001	-
Хром, Cr	мг/л	<0.005	<0.005	0.05
Зэс, Cu	мг/л	<0.03	<0.03	2
Төмөр, Fe	мг/л	<0.03	<0.03	0.3
Лити, Li	мг/л	0.07	0.05	-
Марганец, Mn	мг/л	<0.01	0.29	0.1
Молибден, Mo	мг/л	<0.005	<0.005	0.07
Никель, Ni	мг/л	0.01	0.01	0.02
Фосфор, P	мг/л	<0.05	<0.05	-
Хартүгалга, Pb	мг/л	0.09	0.09	0.01
Сурьма, Sb	мг/л	<0.01	<0.01	0.02
Селен, Se	мг/л	<0.05	<0.05	0.04
Стронци, Sr	мг/л	1.14	1.45	2
Тори, Th	мг/л	<0.01	<0.01	-
Уран, U	мг/л	<0.10	<0.10	0.03
Цайр, Zn	мг/л	<0.10	0.05	5.0




Зураг 7. Хөрс, хурдас хягшаас дахь хүндлийн агууламж



Зураг 8. Хөрс, хурдас хягшаас дахь хар тугалганы агууламж



Зураг 9. Хөрс, хурдас хягшаас дахь зэсийн агууламж



Зураг 10. Хөрс, хурдас хайгууламж дахь цайрын агууламж

1.4 ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- Энэхүү судалгааны үр дүнг дүгнэхдээ тухайн судалгааны талбар металлын орд газар гэдгийг харгалзаж хэрэгтэй. Өөрөөр хэлбэл аливаа орд газарт үндсэн металлаа дагаж бусад металлууд нь бүлэг байдлаар илэрч байгалийн өөрийнх нь аномаль (гажиг) үүсгэдэг геологийн зүй тогтол байдаг. Энэхүү ордын хувьд хэдийгээр мөнгөний орд боловч Cu, Pb, Zn гэсэн металлууд дагалдах байдлаар түгээмэл илэрч байгаа нь шинжилгээний үр дүнгээс харагдаж байна. Энэхүү ойлголттой холбоотойгоор нэг зүйлийг нэмж дурдахад хаягдал лаг гэдэг бол металлуудын өндөр агуулга бүхий хүдрийг бүтэлж баяжуулаад зөвхөн хэрэгтэй буюу мөнгө (Ag)-ийг ялгаж аваад бусад металлууд нь хаягдал лагтайгаа хамт үлдэж байгаа.
- Бидний судалгааны гол зорилго болох хаягдлын сангийн өргөтгөл шинэчлэлтийн ажлын явцад хуучин санд хуримтлагдсан лаг хайгууламжаас ердийн хөрс хурдасны гүн рүү алдагдаж бохирдол үүсгэсэн эсэхийг тодруулахад чиглэгдэж байгаа учраас лаг хайгууламж хүнд металлын агууламжийг гүний зүсэлтүүдээс авсан хурдас чулуулгийн металлын агууламжтай харьцуулж тодорхойлсон.
- Ингээд эцэст нь дүгнэж үзэхэд хаягдлын сангийн лаг хайгууламж дахь As, Cu, Pb, Zn гэсэн 4 металлын агууламж маш өндөр гарсан боловч сангийн сууриас доошоо байрлалтай 2-2.5 м хүртэлх гүнтэй зүсэлтүүдээс авсан дээжинд эдгээр металлууд маш бага буюу стандартын хүлцэх агууламжийн түвшинд байгаа нь лагаас шалтгаалсан аливаа бохирдол үүсээгүй байгааг нотолж байна. Мөн усны дээжинд эдгээр металлууд мөн бага илэрсэн.
- Зүсэлтүүдээс авсан дээжүүдэд As, Zn-ийн агууламж нь зүсэлтийн доод хэсгийн буюу суурь чулуулаг ихтэй үе давхаргуудад стандартын хүлцэх агууламжаас бага зэрэг давсан боловч хаягдлын сангийн лаг хайгууламж дахь As, Zn-ийн агууламжаас харьцангуй бага байна.

Уурхайн хаягдлын овоолгыг тэлэх, зам талбай шинээр байгуулах, хаягдлын сан, тохижилт бүтээн байгуулалт, хүдрийн талбай бэлдэх ажлуудыг гүйцэтгэхээс өмнө шимт хөрсийг хуулахдаа стандартын дагуу хуулж шимт хөрсний овоолгод тээвэрлэж төвлөрүүлэх ажилд хяналт тавьж ажилласан. 2023 онд нийт 5 удаагийн шимт хөрс хуулах зөвшөөрлийг уулын ажлыг хариуцан үйл ажиллагаа явуулж байгаа туслан гүйцэтгэгч Сидар ХХК-д өгч нийт 57392.09 м³ шимт хөрсийг 1, дугаар шимт хөрсний овоолго дээр стандартын дагуу хэлбэршүүлж төвлөрүүлж ажилласан.




2.4 Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Хөрсний овоолго шинээр байгуулах, барилга бүтээн байгуулалт, газар шорооны ажил гүйцэтгэх бүрт ургамлан нөмрөг дарагдахаас сэргийлэх ажлыг зохион байгуулах	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Тээвэр, барилга бүтээн байгуулалтын нөлөөгөөр ургамлан нөмрөг доройтохоос сэргийлсэн байна.	Уурхайн хаягдлын овоолгыг тэлэх, зам талбай шинээр байгуулах, хаягдлын сан, тохижилт бүтээн байгуулалт, хүдрийн талбай бэлдэх ажлуудыг гүйцэтгэхээс өмнө шимт хөрсийг хуулахдаа стандартын дагуу хуулж шимт хөрсний овоолгод тээвэрлэж төвлөрүүлэх ажилд хяналт тавьж ажилласан. 2023 онд шимт хөрс хуулах зөвшөөрлийг уулын ажлыг хариуцан үйл ажиллагаа явуулж байгаа туслан гүйцэтгэгч Сидар ХХК-д 5 удаа, Соёолон интернэшнл ХХК-д 1 удаа өгч нийт 57392.09 м ³ шимт хөрсийг 1, 2 дугаар шимт хөрсний овоолго дээр стандартын дагуу хэлбэршүүлж төвлөрүүлж ажилласан.
2	Уурхайн авто замуудыг дулааны улиралд болон тоос ихээр босох үед усалгаа хийж чийгшүүлэх, олон салаа замуудыг цэгцэлж, шаардлагагүй замуудыг хаах арга хэмжээ авах	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Тоожилтоос сэргийлж ажилласан байна.	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор дулааны улиралд усалгааг тогтмол хийдэг. Уурхайн доторх болон дэд бүтцийн шугамын дагуух замуудыг дулааны улиралд өдөр бүр, түгээмэл ашиглагддаг замуудад өдөрт 2-3 удаа тоосжилт үүсэхээс сэргийлж усалгааг хийж гүйцэтгэдэг. Хүйтний улиралд дулаан өдрийг сонгон усалгааг хийж гүйцэтгэж байна. 2023 онд нийт 3270 м ³ усыг зам талбайн усалгаанд зарцуулсан.
3	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах,	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авч ажилласан байна.	Асгаралтын журмын хүрээнд асгаралтыг удирдах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай бэлтгэлийг хангаж ажилласан. Мөн асгарах эрсдэлтэй хаягдал тосны цэгийг стандартын журмын дагуу хяналт тавьж ажилласан. Одоогоор

	саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах				асгарсан зөрчил гараагүй болно. 2023 онд 21'000'000 төгрөгийн өртөгтэй аюултай шингэн хаягдлын цэгийг тохижуулах ажлыг даалгаврыг боловсруулж тендер зарласан. Тус ажил нь 2024 онд хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна. Тус ажил хийгдснээр стандартын зориулалтын талбай, савтай болох юм.
4	Хяналтын талбай бүрт ургамлын судалгааг хийж гүйцэтгэх Зүйлийн тодорхойлж, бичиглэл хийх бүрдлийг ургамлын	Мониторингийн цэгүүдэд Төслийн талбайд ойр орших ургамлын бүлгэмдлийн хяналтын цэгүүдэд	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөнд зардлыг тооцсон.	Мониторингийн цэгүүдэд ургамлын бичиглэл хийж гүйцэтгэсэн байна.	Ургамлын судалгааг 2023 оны 07 дугаар сарын 17-ноос 2023 оны 07 дугаар сарын 19-ны хооронд Салхит уурхайн орчинд хийж гүйцэтгэсэн. Нийт 5 дээж талбайд 25 удаагийн ургамалжлын бичиглэл хийсэн. Зүйл ургамлын арви, өндөр, бүрхэцийг Друдегийн үнэлгээгээр хийж ургамлан нөмрөгийн өнөөгийн төрх байдлыг тодорхойлсон. Ургамлын судалгаагаар Хялгана-харганат, Алаг өвс-харганат, Таана-харганат гэсэн 3 хэв шинжийн бүлгэмдэлтэй байна. Нийт 22 овгийн 37 төрлийн 48 зүйл ургамал бүртгэгдсэн. 2021 оны судалгаатай харьцуулахад ургамлын зүйлийн бүрдэл нэмэгдсэн, ургамлын арви, өндөр, бүрхэцийг илүү байсан.
5	Ногоон зориулан мод, өвөлжилт, чадварыг хийх байгууламжид тарьсан сөөгний амьдрах хянах, тооллого	Уурхайн ногоон байгууламж байгуулсан нийт талбайд	Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний зардлаас	Тооллого судалгааг хийж, амьдрах чадамжийг тодорхойлсон байна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон эрдэнэс” төглийг байгуулах ажлыг 2021 онд “Эрдэнэс силвер ресурс” ХХК нь эхлүүлсэн бөгөөд одоогоор “Эрдэнэс алт ресурс” ХХК нь хариуцан ажиллаж байна. Энэхүү төгөлд 2021 оноос 2023 он хүртэл

					33000 хайлаас мод тарьсан. Цаашид ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх ургамлын төрлийг зүйлийг олон болгох, Хаалтын нөхөн сэргээлтийн ажлын үндсэн бааз суурь болох мод үржүүлгийн газар байгуулах ажлуудыг төлөвлөн ажиллаж байна. Тарьсан моднуудын амьдрах чадвар 89%-тай буюу маш сайн ургалттай байсан.
Нийт: 500'000 төгрөг . Тус бүлэгтэй холбоотой зардлуудыг ОХШХ-ийн зардалд тооцсон.					

Зам талбайн усалгаа, арчилгаа: Замын тоосжилтыг бууруулах зорилгоор дулааны улиралд усалгааг тогтмол хийдэг. Уурхайн доторх болон дэд бүтцийн шугамын дагуух замуудыг дулааны улиралд өдөр бүр, түгээмэл ашиглагддаг замуудад өдөрт 2-3 удаа тоосжилт үүсэхээс сэргийлж усалгааг хийж гүйцэтгэдэг. Хүйтний улиралд дулаан өдрийг сонгон усалгааг хийж гүйцэтгэж байна. 2023 онд нийт **3270 м3** усыг зам талбайн усалгаанд зарцуулсан байна.



2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, геологийн нөөцөөс хөдөлгөөн хийхийг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

3. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллах, техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1-ийг, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт тус байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан төслийн хүчин чадал, техник, технологид өөрчлөлт орсон, ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

5. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Салхит" нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 1-ийг, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивт, Уул уурхай, судалгааны хэлтэст тус тус хүлээлгэн өгөхийг Эрдэнэс Силвер Ресурс ХХК -д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН



**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 7/15.

Улаанбаатар хот

**Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн т/19-18-01 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Эрдэнэс силвер ресурс ХХК-ийн Салхит нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг хүлээн авсанд тооцсугай.

2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т зөвшөөрсүгэй.

3. Техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажил явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан үйлдвэрийн хүчин чадал, техник, тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс (Д.Хангай)-т даалгасугай.

5. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Салхит нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг Эрдэнэс силвер ресурс ХХК -д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН

53700154



УУЛ УУРХАЙ. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ. ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2019 оны 12 сарын 31 өдөр

Дугаар Т/19-18-01

Улаанбаатар хот

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй Салхит нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг хэлэлцсэн тухай

“Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн захиалгаар уул уурхайн зураг төслийн “Топазия” ХХК боловсруулсан Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Салхит нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-д Доктор, дэд проф. Б.Чинзориг, уул уурхайн мэргэшсэн инженер Г.Амартүвшин нар шинжээчийн дүгнэлтийг гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Салхит нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь Ордын эдийн засаг газарзүйн тодорхойлолт, Ордын геологийн тогтоц, Нөөцийн тооцоо, Ил уурхайн төлөвлөлт, Ил уурхайн тооцоо, Технологийн туршилт судалгаа, Салхитын мөнгө-алтны хүдрийг баяжуулах үйлдвэр, Уурхайн усан хангамж, Цахилгаан хангамж, Уурхайн дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй эрсдэлийн менежмент, Байгаль орчин нөхөн сэргээлт, Зохион байгуулалт хүний нөөц, Төслийн үнэлгээ, Дүгнэлт зөвлөмж, хавсралт материал, хавсралт тооцоо бүхий 262 хуудас тайлбар бичиг, 14 ш хавсралт зургуудаас бүрдсэн байна.

2. Ордын нөөцийг 2015-2016 онд нэмэлт хайгуулын ажлыг хийж гүйцэтгэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ХХ-12-03 тоот дүгнэлтээр 2016 оны 7 сарын 1-ний байдлаар Салхит мөнгө-алтны үндсэн ордын нөөцийн бодитой буюу В зэргээр 1,714,953.36 т хүдэрт дунджаар экв.мөнгө 344.59 г/т агуулгатай 590,956.64 кг металл экв.мөнгө (мөнгө 546,785.86 кг, алт 747.67 кг), боломжтой буюу С зэргээр 1,058,288.46 т хүдэрт дунджаар экв.мөнгө 227.98 г/т агуулгатай 241,270.08 кг (мөнгө 221,129.38 кг, алт 340.92 кг), В+С зэргээр 2,773,241.82 т хүдэрт дунджаар экв.мөнгө 300.09 г/т агуулгатай 832,226.72 кг (мөнгө 767,915.24 кг, алт 1,088.58 кг) экв.мөнгөний нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. Мөн тус компанийн нөөцийн агуулахад 176,701.84 тн хүдэр 530.86 гр/тн, агуулгатай 93,804 кг мөнгө, 0.82 гр/тн агуулгатай 145.11 кг алтны нөөцтэй байна.

3. 2019 онд маркшейдерийн хэмжилтийн үр дүнд ордын нөөцийн хөдөлгөөнийг

"Аглаг Уул" ХХК-аар тооцоо хийлгэсэн байна. Үүнд:

	Эзлэхүүн, мян.м3	Хүдэр, мян.тн	Эзлэхүүн жин, гр/см3	Ag, г/т	Au, г/т	Металл Ag, тн	Металл Au, кг
В+С	934	2,491.5	2.67	247.8	0.25	617.5	899
Овоолго /склад/	208.8	429.4	2.57	850.6	1.06	365.3	454.6
Нийт	1,142.90	2,920.9		336.4	0.46	982.8	1,353.7

4. Ил уурхайн хүрээнд нийт геологийн нөөц (В+С) зэргээр 1.75 сая.тн хүдэр, үүнээс бодитой (В) зэргээр 1.19 сая.тн, боломжтой (С) зэргээр 0.55 сая.тн хүдэр өртөж байна.

5. Ашиглалтын үеийн хаягдал бохирдолтын тооцоонд олборлолтын доголын өндрийг 6м, хүдрийн биет дэх хоосон чулуулгийн эзлэх хувь 2%, хүдрийн биетийн дундаж хэвтээ зузаан нь 20м, хүдрийн биетийн уналын өнцгийг 71-90 градусаар тус тус үзүүлэлтийг авч тооцоолоход ордын хэмжээнд ашиглалтын үеийн бохирдол 3.94%, хаягдал 2.79% гэж тооцож, уурхайн хэмжээнд нийт /В+С/ 1.77 сая тн хүдэр, таваарын хүдэр дэх мөнгө дундаж агуулга 311.47 гр/тн, металлын хэмжээ 552.49 мян.тн, алт дундаж агуулга 0.41 гр/тн, 720 кг, мөн 429 мян.тн овоолгонд 855.66 гр/тн агуулга бүхий 365.3 тн Ag, 1.06 гр/тн агуулна бүхий 454.69 кг алтыг нийт 5 жилийн хугацаанд ашиглахаар тооцжээ.

6. Ашиглалтын нийт хугацаанд 3.59 сая м³ хөрс хуулж, 2.2 сая тн таваарын хүдрээр баяжуулах үйлдвэрийг хангана. Үүнээс нөөцийн агуулахын үлдэгдэл 0.42 сая тн., ил уурхайгаас 1.77 сая тн хүдэр, уурхайн хөрс хуулалтын дундаж илтгэлцүүр 2.03 м /тн байхаар тооцжээ.

7. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын нөөцийн тогтоц болон байршил, хөрсний зузаан, хөрсний чулуулгийн шинж чанар, зэргийг харгалзан үзэж Салхит нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглах нь зөв гэж үзжээ.

8. Ил уурхайн хөрс, хүдрийн өрөмдлөгийн ажилд Atlas Copco фирмийн Rock L8 маркийн 150 мм диаметр бүхий өрмийн хошуутай өрмийн машин тус бүр 1 ш, хөрс хуулалтад 4.6 м³ шанаганы багтаамжтай CAT 390 маркийн урвуу утгуурт экскаватор 3 ш, хүдэр олборлолтод мөн 2.6 м³ шанаганы багтаамжтай CAT 349 маркийн урвуу утгуурт экскаватор 1 ш, хөрс тээвэрт 70 тн даацтай, Howo 70 маркийн автосамосвал 9 ш, хүдэр болон хаягдал тээвэрт 70 тн даацтай Howo 70 маркийн автосамосвал тус бүр 2 ш, хөрсний овоолгод асгац түрэх, тэсэлгээгээр үүсэх нурлын хормой шуух ажилд Shantui SD16 бульдозер 3ш ажиллах ба туслах ажилд ажиллахаар төсөлд тусгажээ.

9. Салхитын мөнгө-алтны ордын технологийн туршилтын тайланг "МАК" лаборатори гүйцэтгэсэн байна. Туршилтаар тогтоогдсон горим, схемийн дагуу 5.59% гарцтай, мөнгө 5278г/т, алт 5.9 г/т агуулгатай, 95.01% мөнгө авалттай, 82.67% алт авалттай эцсийн баяжмал гарган авах боломжтой байна.

10. Технологийн туршилтын тайланд үндэслэн баяжуулалтын тооцооллыг хийж гүйцэтгэсэн. Технологийн тооцооны үр дүнгээр төслийн нийт хугацаанд мөнгөний 404.3 гр/тн, алтны 0.53 гр/тн агуулгатай 2,020,651 тн хүдрийг 600.0 мян.т/жил хүчин чадалтай битүү циклтэй флотацийн аргаар баяжуулах үйлдвэрт

баяжуулан, мөнгөний 6955 гр/тн, алтны 1.7 гр/тн шуудангийн үйлдвэрлэл 112,954 тн баяжмал үйлдвэрлэнэ.

11. Олборлолтын явцад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг MNS5915:2008, MNS5916:2008, MNS5918:2008, MNS5850:2008 зэрэг Монгол улсын стандарт зааварчилгааны дагуу гүйцэтгэж, уулын ажлын үр дүнд үүссэн ухашийг нөхөн дүүргэж тэгшлэх, тухайн бүсийн уур амьсгалын нөхцөл байдалд тохирсон мод, бутлаг ургамлаар биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж гүйцэтгэхээр зардлыг төсөлд тусгасан байна.

12. Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх, хаалтын ажлын зардалд нийт 1,892.65 сая төгрөгийг төсөвлөсөн бөгөөд үүнээс 200.83 сая төгрөгийг байгаль орчин хамгаалах, 562.5 сая төгрөгийг гадаад зам арчилгааны зардал, 298.0 сая төгрөгийг дүйцүүлэн хамгаалах зардал, 447.1 сая төгрөгийг техникийн нөхөн сэргээлтийн зардал, 291.9 сая төгрөгийг биологийн нөхөн сэргээлтийн зардал, 92.3 сая төгрөгийг хаалтын дараах мониторингийн ажлын зардалд тус тус зарцуулахаар төсөлд тусгажээ.

13. Салхит нэртэй мөнгө-алтны уурхайд нийт 309 хүний ажлын байр шинээр бий болох ба дунджаар 1 ажилтны сарын дундаж цалин 2,152-2,307 мян.төг байхаар тооцжээ.

14. Төслийн хугацаанд нийт 41.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдаж нийт 253.3 тэрбум төгрөгийг татвар төлбөр хэлбэрээр улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх бөгөөд үүний 244.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт, 9.1 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тусгажээ.

15. Төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV@20) үед 292.2 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 320.6 хувь, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 0.35 жил байгаа нь энэхүү төсөл хэрэгжих боломжтой харуулжээ.

16. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаль орчныг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байхыг ЭБМЗ-өөс даалгаж байна.

17. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэл нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

18. Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилсон комисс уурхайг хүлээн авсны дараа уг уурхайг энэхүү техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу ажиллуулж эхлэхийг "Эрдэнэс силвер ресурс" ХХК (Т.Мөнхбаяр)-д анхааруулах.

19. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник

тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж, ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байх нь зүйтэй.

20. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан овоолгийн нөөцийг Эрдэс баялаг мэргэжлэлийн зөвлөлийн "Геологи судалгаа, ашигт малтмалын хайгуулын асуудал" хэлэлцэх салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж нөөцийг тодотгохыг ЭБМЗ-өөс "Эрдэнэс силвер ресурс" ХХК (Т.Мөнхбаяр)-д анхааруулж байна.

21. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Салхит нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, баяжуулах үйлдвэрийн төлөвлөлт, цахилгаан болон усан хангамж, дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан уул уурхайн зураг төслийн "Топазия" ХХК хариуцах, түүний үнэн бодит байдал, чанарт гаргасан дүгнэлтийг шинжээч доктор, дэд проф. Б.Чинзориг, уул уурхайн мэргэшсэн инженер Г.Амартүвшин нар хариуцах.

22. Захиалагч компани Техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах тухай Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын шийдвэр гарснаас хойш 5 хоногт багтаан Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын дарга гаргасан шийдвэрээ түдгэлзүүлэх, цуцлах эрхтэйг анхааруулах нь зүйтэй.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмал, газрын тосны газрын даргад Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн "Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй Салхит нэртэй мөнгө-алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл тодотгол"-ыг хүлээн авах шийдвэр гаргахыг уламжлагаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.МӨНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ХУРАЛДААНЫ ДАРГА

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.БОЛД-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 11/46

Улаанбаатар хот

Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн ХХ-01-06 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Салхитын мөнгө-алтны үндсэн ордын ХШ-03-08-ын хооронд 2020 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуул, нөөцийн шинэчилсэн тооцооны ажлын үр дүнгийн тайлан дахь MV-021483 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах мөнгө, алтны нөөцийг бодитой (B) зэрэглэлээр 2,473,610.97 тн хүдэрт агуулагдах 266.51 г/т дундаж агуулгатай мөнгө 659,242.49 кг, 0.36 г/т дундаж агуулгатай алт 902.27 кг, боломжтой (C) зэрэглэлээр 696,204.52 тн хүдэрт агуулагдах 126.30 г/т дундаж агуулгатай мөнгө 87,929.93 кг, 0.23 г/т дундаж агуулгатай алт 159.85 кг, нийт бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 3,169,815.49 тн хүдэр буюу 235.71 г/тн дундаж агуулгатай 747,172.42 кг мөнгө, 0.34 г/тн дундаж агуулгатай 1,062.12 кг алтны нөөц, 8 хүдрийн овоолгод буй нөөцийг бодитой (B) зэрэглэлээр 280,475.18 тн хүдэрт агуулагдах 381.07 г/т дундаж агуулгатай 106,879.62 кг мөнгө, 0.42 г/т дундаж агуулгатай алт 116.81 кг, үйлдвэрийн агуулахад хадгалагдаж буй бодитой (B) зэрэглэлээр 409.17 тн баяжмалд агуулагдаж буй 19.118 гр/тн дундаж агуулгатай 7,960.0 кг мөнгө, 22 г/т дундаж агуулгатай 9,0 кг алт, нийт ордын хэмжээнд газрын хэвлийд байгаа хөндөгдөөгүй геологийн нөөц, хүдрийн овоолго, баяжмалд агуулагдах мөнгө, алтны нөөцийг нийт бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр мөнгө 862,011.68 кг, алт 1,187.9 кг-аар хүлээн авсугай.

2. Хүлээн авсан геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Гео-мэдээллийн төв /Ц.Минжинсор/-д зөвшөөрсүгэй.

3. Хүлээн авсан нөөцийг бүртгэхтэй холбогдуулан АМГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 4/08 дугаар тушаалаар ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 2,773,241.8 тн хүдэрт дунджаар экв.мөнгө 300.09 г/т агуулгатай 832,226.72 кг экв. мөнгө (мөнгө 767915.24 кг, алт 1088.58 кг)-ний нөөцийг хасаж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Гео-мэдээллийн төв /Ц.Минжинсор/-д зөвшөөрсүгэй.

180101 245

4. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Салхитын мөнгө-алтны үндсэн ордын ХШ-03-08-ын хооронд 2020 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуул, нөөцийн шинэчилсэн тооцооны ажлын үр дүнгийн тайланг бичвэр дискийн хамт Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдааны дүгнэлт, түүний дагуу гаргасан Үндэсний Геологийн Албаны даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК /Т.Мөнхбаяр/-д даалгасугай.

ДАРГА  О.ЧУЛУУН





УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2021 оны 01 дугаар сарын 21

№ ХХ-01-06

Улаанбаатар хот

*Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших
Салхитын мөнгө-алтны үндсэн ордын ХШ-03-08-ын хооронд
2020 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуул, нөөцийн шинэчилсэн
тооцооны ажлын үр дүнгийн тайланг хэлэлцсэн тухай*

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Салхит нэртэй MV-021483 талбай дахь Салхитын мөнгө-алтны ордод 2020 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр Монгол Улсын мэргэшсэн геологич Г.Батбуян, Г.Ишдорж, геологич Н.Шийрэвдорж, Д.Батсайхан, Д.Мөнхтөр, Л.Дэлгэрсайхан, Б.Бүтэмж, Д.Тэгшжаргал, Б.Баттулга, Б.Батзаяа, М.Золбаатар, Ж.Мягмарцэвээн нарын зохиосон тайлан, уг тайлан болон ордын нөөцийн тооцоонд Монгол Улсын зөвлөх геологич Ч.Энх-Амгалан, Монгол Улсын мэргэшсэн геологич Х.Төмөрбаатар нарын хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна. Үүнд:

1. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Зүүн нэртэй MV-017368 (хуучнаар 7991X) тусгай зөвшөөрлийн талбайг анх 2004 оны 7 дугаар сарын 23-нд АМХЭГ-ын Геологи Уул Уурхайн Кадастрын Албаны даргын шийдвэрээр иргэн Батсүхийн Батсайханд олгосон. 2010 оны 11 сарын 19-нд АМГазрын Геологи Уул Уурхайн Кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр “Жи Пи Эф” ХХК-нд шилжүүлсэн.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Салхит нэртэй XV-012772 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг анх 2007 оны 10 дугаар сарын 05-нд АМГТГ-ын даргын шийдвэрээр “Монгол Цамхаг” ХХК-д олгосон ба 2010 оны 11 сарын 19-нд АМГазрын Геологи Уул Уурхайн Кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр “Жи Пи Эф” ХХК-д шилжүүлсэн байна. Энэ тусгай зөвшөөрлийн талбайд “Жи Пи Эф” ХХК хайгуул хийж нөөц тооцоолсоны дараа “Салхит” нэртэй MV-021036 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр олгосон байна.

Дээр дурдсан “Жи Пи Эф” ХХК-д эрхийг нь олгосон “Зүүн” нэртэй MV-021035 тоот “Салхит” нэртэй MV-021036 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын КХ-ийн даргын шийдвэрээр 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн шийдвэрээр цуцалсан байдаг.

Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэл, Ашигт малтмал, газрын тосны газрын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 341 дугаар шийдвэрээр Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Салхит” нэртэй 288 га бүхий ашигт малтмал ашиглах ашиглалтын MV-021483 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани болох “Эрдэнэс силвер ресурс” ХХК-д олгосон байна.

Салхит талбай нь Улаанбаатар хотоос урагш 280 км, Дундговь аймгийн төвөөс зүүн тийш 65 км, Гурвансайхан сумын төвөөс хойш 35 км-т байрлана.

2. “Эрдэнэс силвер ресурс” ХХК нь 2020 онд тус тусгай зөвшөөрлийн талбай дахь Салхитын мөнгө-алтны үндсэн ордод нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэн ордын нөөцийг бодитой (В) болон боломжтой (С) зэрэглэлээр тогтоон хайгуулын ажилд нийт 2,225,045,253.0 төгрөг зарцуулсан байна.

3. Тус дүүргийн геологийн судалгааны түүх нь 1862-1865 онд Андерсон, Рафаел, Пемпелли нар, 1876-1885 онд Н.М. Прижевалский нар Төв Азийн нутгаар дайран, Хаалган дайрч Бээжин орох замдаа геологийн анхны мэдээлэл цуглуулснаар эхэлсэн байдаг. 1922-1923 онд Монголын зүүн өмнөд нутагт ажилласан Америкийн геологич Ч.Берки нар тухайн нутгийн геологийн зураг зохиож цэрд, гуравдагчийн хурдсыг нарийвчлан судалж, олон тооны амьтан ургамлын үлдвэрт тулгуурлан хурдас зузаалаг давхарга зүйн хэлтэс, свитүүдэд дүйцүүлэн ангилсан талаар дурдагдсан байдаг. 1953 оноос геологийн системчилсэн судалгааны ажил хийгдэж В.И.Браташийн удирдлагаар Өндөршилийн хотгорын орчимд 1:500000-ны масштабтай геологийн зураглалын ажил хийж дунд, дээд эрт төрмөл, дунд төрмөлийн хурдсууд ялгаж, интрузив чулуулгийг барагцаалсан байдлаар герцин, хожуу герцений насанд ангилсан байна.

Салхитын илрэлийг анх Л.В.Заботкин нарын 1:200000-ны бүлэгчилсэн зураглалын ажлаар олж тогтоосон. Илрэлийг доод пермийн цаг үеийн вулканоген үүсэлтэй хүчиллэг-дундлаг найрлагатай өргөргийн дагуу суналтай, салбарласан хэлбэртэй, риолитийн хэд хэдэн дэлээс бүрдэх субвулкан биетийг зүссэн кварцын судалтай холбоотой гэж тогтоосон. Металлогений мужлалаар Дундговь-Буянтын металлогений бүсийн Гурвансайханы хүдрийн дүүрэгт хамрагдах бөгөөд геологи хайгуулын судалгаа харьцангуй сул хийгдсэн боловч үнэт металл /Au/-ын ач холбогдолтой орд илэрч болох шалгуур шинж тэмдэг бүхий талбайд хамруулж байжээ.

Энэ дүүрэгт 1988-1991 онд Ж.Нармандах нар 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэсэн байна.

2012-2013 онд “Жи Пи Эф” ХХК “Зүүн” нэртэй MV-017368 тусгай зөвшөөрлийн талбайн “Салхит”-ын мөнгө-алтны илрэл дээр геологи-хайгуулын ажлыг хийж баганат өрөмдлөгийн 34 цооног, 17 суваг 1470 ширхэг дээжийн үр дүнг ашиглан ордын нөөцийг бодитой зэрэглэлээр 676.61 тонн экв.мөнгө, үүнээс мөнгө 663.31 тн, алт 0.87 тн, боломжтой зэрэглэлээр 226.72 тонн экв.мөнгө, үүнээс мөнгө 199.09 тн, алт 0.29 тн, нийт бодитой боломжтой” В+С зэрэглэлээр 903.33 тонн экв.мөнгө тооцож Улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн байна.

Салхитын ордыг 2013 оноос эхлэн ашиглаж эхэлсэн бөгөөд 2014-2015 онд нийт 228,890.0тн хүдэр олборлож 96,125.0тн хүдэр экспортонд гаргасан байна. 2016 оноос 2020 оны 1 дүгээр сар хүртэл ямар хэмжээний хүдэр олборлосон, боловсруулж борлуулалт хийсэн талаар албан ёсны мэдээ тайлан байхгүй байна.


2016 онд “Жи Пи Эф” ХХК нэмэлт хайгуулын ажлаар MV-017368 болон XV-012772 тусгай зөвшөөрлүүдийн талбайд хамаарах Салхитын ордын хэмжээнд 25-50 х 50 метрийн торлолоор 65-304.30 метрийн гүнтэй 42 ширхэг цооног өрөмдөж 5079.6 тууш метр өрөмдлөгийн ажил хийж гүйцэтгэн 2013 онд батлагдсан нөөцийн зэрэглэлийг ахиулан тооцож гадаргуугаас 1400-1190 метр хүртэл гүний түвшинд нөөцийн дахин тооцоо мөн ашиглалтын тусгай зөвшөөрлийн баруун хилээр зааглаж буй хүдрийн биетийн баруун үргэлжлэл болох “Жи Пи Эф” ХХК ний эзэмшиж буй XV-012772 тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Ордын нөөцийг бодитой зэрэглэлээр 1,714,953.4 тонн хүдэр, үүнээс мөнгө 546.7 тн, алт 747.67 кг, боломжтой зэрэглэлээр 1,058,288.5 тонн хүдэр, үүнээс мөнгө 221.1 тн, алт 340.92 кг, нийт бодитой, боломжтой 2,773,241.8 тонн хүдэр үүнээс мөнгө 767.91 тн, алт 1088.58 кг гэж тооцон Улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн байна.

4. “Эрдэнэс силвер ресурс” ХХК нь Салхит талбайн мөнгө-алтны ордын үргэлжлэлд 2020 онд геологи хайгуулын нарийвчилсан ажлыг гүйцэтгэсэн. Талбайн зураглалын ажлыг 2000 га талбайд хийж, эрлийн маршрут 120т.км-т, хоёрдогч геохимийн дээжлэлтийг 67 шугамд 2006 ширхэг дээж авсан. Хайгуулын өрөмдлөгийг 14 шугамын дагууд дунджаар 175м гүнтэй 52 цооногоор нийт 7084 тууш метр өрөмдлөгийн ажил хийж, 2528 ширхэг чөмгөн дээж, 7 суваг буюу 3372.8м.куб суваг малтаж 353 ширхэг ховилон дээж авсан байна. Геофизикийн соронзон хайгуул 2887.85 га талбайд, цахилгаан хайгуулын ажлыг 141,1т.км, 11км шугамын зүсэлт, цооногийн каротажийн ажлыг 3133.1 т.м, байр зүйн зураглалын ажил 970 га талбайд, гидрогеологийн судалгааг үйлдвэрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор 622 т.м гүйцэтгэж, технологийн туршилтанд 1620кг дээж авч, минерографи, петрографийн бүрэн бичиглэл 53ш дээжинд тус тус хийжээ.

Баганат өрөмдлөгийн ажлыг “Кали Хаккин” ХХК, хүдрийн найрлага, технологийн шинж чанар болон бодисын найрлагын баяжуулах технологийн туршилтын судалгааны ажлын лабораторийн шинжилгээг “МАК” компанийн технологи туршилтын төвийн лабораторид, чөмгөн, ховилон, геохимийн болон цэглэн дээжийн лабораторийн шинжилгээг “Эс Жи Эс Ай Эм Эм Монголиа” ХХК, “ХАНЛАБ” ХХК, топо зураглалын ажлыг “Хос Алтан Пирамид” ХХК, чулуулгийн бат бэхийн шинжилгээг “Барилга архитектур корпорац” тус тус гүйцэтгэжээ.

5. Тус орд нь Дундговийн вулкан-плутон бүслүүрт металлогенийн мужлалаар Говь-Угтаал, Баянжаргалын металлогений бүсийн Гурвансайханы хүдрийн дүүрэг, Зодохын чулуут хүдрийн зангилаанд байршина. Ордын байрших хэсэгт олон насны, олон төрлийн хурдас тархаагүй бөгөөд доод пермийн Сахалгол формацын тунамал-вулканоген, түрүү пермийн Сизурал серийн хүчиллэг, шүтлэгдүү хүчиллэг риолит, трахириолит, игнимбрит, андезит, андезит дацит, риодацит тэдгээрийн туфууд болон хүдрийн биетийг агуулагч кварцын судал штокверк судал судланцарууд тэдгээрийг хучсан дөрөвдөгчийн насны делюви-аллювийн хурдас тархсан байна. Хүдрийн биет нь Дундговийн хагарлаар хойд талаасаа 40-50° уналтай хязгаарлагдаж, тус хагарлын дагуух босоо хөдөлгөөний улмаас үүссэн босоодуу уналтай кливажийн бүсээр хянагддаг. Дундговийн хагарлыг дагасан доод пермийн үеийн трахириолитийн биетүүдийн түрэлтийн нөлөөгөөр орд үүсэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд орон зай, цаг хугацааны хувьд өөр чиглэлийн хагарал, хагарлын системээр орд хянагдаж байгаагаас деформацийн чиглэл байнга өөрчлөгдөж террейны давхацмал байдал, нийлмэл байдлыг бий болгосон байна. Ордын гол хүдэржилт нь хагарлын тэлэлтийг дүүргэсэн эпитеpmаль кварц болон кварцын брекчид голдуу агуулагдах боловч бага хэмжээгээр агуулагч чулуулаг болох андезит болон трахириолитод мөн агуулга өгдөг. Хүдрийн биетүүд нь тусгай зөвшөөрлийн талбайн зүүн хилээр хязгаарлагдаж зүүн хойш 70°-р ойролцоогоор 720м урт, дунджаар 30-50м өргөнтэй, шургалт байхгүй бөгөөд урагшаа 80-85° уналтай. Агуулагч чулуулгийн хүдэржилт нь голдуу ан цав дагаж гарч ирсэн кварцын судлуудад агуулагдаж, үндсэн кварцын эпитеpmаль судлаасаа хоёр талдаа ойролцоогоор 2-5м-ээс илүүгүй хүчтэй цахиуржсан бүсэд тохиолддог.

6. Мөнгө нь галенит, сфалерит, халькопирит, пиритэнд изоморф байдлаар орших бөгөөд байгалийн мөнгөтэй галенит, сфалерит, халькопиритийн нарийн мөхлөгүүд тархсан байдалтай, аргентит нь бие даасан эрдсийн хэлбэрээр, зарим эрдэс нь хүдрийн болон агуулагч чулуулгийн эрдсийн завсарт маш нарийн ширхэглэл хэлбэрээр оршиж байна. Ширхэглэлийн хэмжээ нь 0.02-0.2 мм. Алт нь сфалерит, халькопирит, пиритийн дотор хэсэг газарт ан цав байдлаар, алтлаг шар өнгөтэй, тод бараан өнгийн хүрээтэй, хүдрийн бус эрдсүүдээр коррозилондон цоорч, долгиолог хил заагтай шигтгээлэг мөхлөг үүсгэнэ.



Мөнгө-алтны хүдрээс авсан дээжинд химийн шинжилгээгээр мөнгөний дундаж агуулга 310,4г/тн, алтны дундаж агуулга 0,42г/тн, ордын хэмжээнд хүдрийн найрлага, технологийн шинж чанар болон бодисын найрлагын баяжуулах технологийн туршилтын судалгааны ажлыг 2020 онд “МАК” компанийн Технологи туршилтын төвийн лабораторид гүйцэтгүүлсэн. Хүдрийн найрлага, технологийн шинж чанар, баяжигдах үйл явцын туршилтын үр дүнд мөнгө-алтны хүдрийн баяжмал 5.59%-ийн гарцтай, мөнгө 5278 г/т, алт 5.9 г/т агуулгатай, 95.01% мөнгөний металл авалттай, 82.67% алтны металл авалттай эцсийн баяжмал гарган авах боломжтой ба тухайн ордын хүдрийг флотацийн аргаар баяжуулах нь үр дүнтэй гэсэн дүгнэлт гарсан байна.

7. Зохиогчид хээрийн ажиглалт, лабораторийн судалгааны ажлын үр дүнгээр мөнгө-алтны хүдрийн биетэд ордын нөөцийн тооцоог гүйцэтгэхдээ дараах жишиг үзүүлэлтүүдийг баримталжээ. Үүнд:


- | | |
|---|-----------------------|
| • Хүдэр дэх мөнгөний эквивалентын захын агуулга | 20 г/т |
| • Нөөцийн хэсэгшил дэх мөнгөний эквивалентын хамгийн бага агуулга | 22.8 г/т |
| • Үйлдвэрлэлийн хамгийн бага мөнгөний эквивалентын захын агуулга | 40 г/т |
| • Хүдрийн биетийн хамгийн бага зузаан | 2.0 м |
| • Нөөцийн тооцоонд орсон хоосон чулуулгийн хамгийн их зузаан | 2.0 м |
| • Ил аргаар ашиглах үеийн хөрс хуулалтын коэффициент | 2.65м ³ /т |

Хүдрийн эзэлхүүн жинг өмнөх судлаачдын болон 2020 онд Барилга Архитектурын корпораци (БАК)-д хийсэн шинжилгээний 2.67см³ байна гэж тодорхойлсон үр дүнгээр нөөцийн тооцоонд ашигласан байна.

8. Ордын хэмжээнд бодитой (В) нөөцийн 37 блок, боломжтой (С) нөөцийн 45 блок буюу нийт нөөцийн 82 блок 6 хүдрийн биетэд нөөцийн тооцоолол хийгдсэн. Зохиогчид ордын геологийн нөөцийн тооцоог Датамайн программ ашиглаж геологийн загварчлал, геостатистик шинжилгээнд үндэслэн “Энгийн Кригингийн” аргаар блокт мөнгө-алтны агуулгыг тархаах замаар, нөөцийн тооцооны хяналтыг “Урвуу зайн хамаарал”-ын аргаар болон “Зүсэлт”-ийн аргаар тооцоолон гүйцэтгэжээ. Ингэхдээ газрын хэвлийд байгаа хөндөгдөөгүй геологийн нөөцийн хүдэр дэх мөнгөний эквивалентын хамгийн бага захын агуулгыг 20г/т гэсэн хувилбараар тооцож нөөцийг нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 3,169,815.49тн хүдэр буюу 235,71г/тн дундаж агуулгатай 747,172.42кг мөнгө, 0,34г/тн дундаж агуулгатай 1,062.12кг алтны нөөц, 8 хүдрийн овоолгод буй нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 280,475.18тн хүдэрт агуулагдах 381.07г/т дундаж агуулгатай 106,879.62кг мөнгө, 0.42г/т дундаж агуулгатай алт 116.81кг, үйлдвэрийн агуулахад хадгалагдаж буй 409.17тн баяжмалд агуулагдаж буй 19.118гр/тн дундаж агуулгатай 7,960.0кг мөнгө, 22г/т дундаж агуулгатай 9.0кг алт, нийт ордын хэмжээнд газрын хэвлийд байгаа хөндөгдөөгүй геологийн нөөц, хүдрийн овоолго, баяжмалд агуулагдах мөнгө, алтны нөөцийг нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 3,450,699.84 тн хүдэрт агуулагдах 862,011.68кг мөнгө, 1,187.93кг алт гэж тооцоолжээ.

Салхитын ордын хэмжээнд илрүүлсэн баялаг (Р) 203,586.0 тн хүдэрт дунджаар 16.8 г/т агуулгатай 3,425.71 кг мөнгө, 0.46 г/т агуулгатай 93,75 кг алтаар тооцоолсон байна.

Шинжээчид тайлан болон дээрх нөөцийн тооцоонд хяналтын тооцоо хийж, ордын нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар хүлээж авахыг санал болгосон ба ЭБМЗ-ийн хуралдааны үед зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар ордын нөөцийг шинжээчийн санал болгосноор зохиогчийн тооцоолсон хувилбараар хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх, 2016 онд бүртгэгдсэн нөөцөд хасалт хийж хөдөлгөөн хийх нь зүйтэй гэж үзсэн. Уг ордыг II бүлгийн ордод хамааруулсан.



9. 2014 онд гидрогеологийн судалгааг ордын хэмжээнд хийсэн бөгөөд орд нь гидрогеологийн таааламжтай нөхцөлтэй ордод хамаарах ба одоо ашиглаж байгаа дунджаар 6.7л/сек-ийн ундаргатай 6 гүний худгууд нь 1тн хүдэр боловсруулахад 1.8м³ ус болон 1 хүн/өдөр гэсэн хэрэгцээг бүрэн хангадаг. Мөн ордоос баруун зүгт 15-20 км орчим Сумангийн говийн хөндийн зүүн хажууд газрын доорхи усны 466.5м³/хоног нөөц бүхий орд тогтоогдсон байна. 2020 онд үйлдвэрлэлийн усан хангамжийг сайжруулах зорилгоор 622т.метр өрөмдлөгийн ажил гүйцэтгэжээ.

10. Ордыг ашиглах техник эдийн засгийн урьдчилсан тооцоонд ордыг ил аргаар ашиглаж хүдрийг флотацийн аргаар баяжуулан, борлуулахаар тусгажээ. Техник эдийн засгийн урьдчилсан тооцоогоор ордыг нийт 4.3 жил ашиглахаар төлөвлөж тооцоог хийсэн байна. Ордын хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 0.96 жил ба төслийн хугацаанд нийт 948.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, татварын өмнөх ашиг 471.2 тэрбум төгрөг, цэвэр ашиг 355.7 тэрбум төгрөг, бэлэн мөнгөний урсгал буюу дансны хуримтлал 305.5 тэрбум төгрөг гэж тооцжээ.

11. Цаашид ордын хүдэржилтийн онцлог, геологи орчин, хувирлыг нэмж судлах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон орд ашиглах ТЭЗҮ-г эрх бүхий хуулийн этгээдээр хийлгэх, ус ашиглах дүгнэлтийг холбогдох газраар гаргуулах, холбогдох хууль тогтоомж, ялангуяа “Ашигт малтмалын тухай” хууль түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан заавар журам болон холбогдох хууль тогтоомжыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

Нөөцийн тооцоонд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3, 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.3 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Үндэсний геологийн албаны даргад уламжлахаар шийдвэрлэв. Үүнд:

Нэг, “Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Салхитын мөнгө-алтны үндсэн ордын ХШ-03-08-ын хооронд 2020 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуул, нөөцийн шинэчилсэн тооцооны ажлын үр дүнгийн тайлан” (Ордын нөөц 2020 оны 09 дүгээр сарын 01-ний байдлаар) дахь мөнгө, алтны нөөцийг бодитой (В) зэрэглэлээр **2,473,610.97 тн** хүдэрт агуулагдах 266.51 г/т дундаж агуулгатай **мөнгө 659,242.49кг**, 0.36 г/т дундаж агуулгатай **алт 902.27 кг**, боломжтой (С) зэрэглэлээр **696,204.52 тн** хүдэрт агуулагдах 126.30 г/т дундаж агуулгатай **мөнгө 87,929.93кг**, 0.23 г/т дундаж агуулгатай **алт 159.85кг**, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр **3,169,815.49тн** хүдэр буюу 235,71г/тн дундаж агуулгатай **747,172.42кг мөнгө**, 0,34г/тн дундаж агуулгатай **1,062.12кг** алтны нөөц, 8 хүдрийн овоолгод буй нөөцийг бодитой (В) зэрэглэлээр **280,475.18тн** хүдэрт агуулагдах 381.07г/т дундаж агуулгатай **106,879.62кг** мөнгө, 0.42г/т дундаж агуулгатай **алт 116.81кг**, үйлдвэрийн агуулахад хадгалагдаж буй бодитой (В) зэрэглэлээр **409.17тн** баяжмалд агуулагдаж буй 19118гр/тн дундаж агуулгатай **7,960.0кг** мөнгө, 22г/т дундаж агуулгатай **9.0кг** алт, нийт ордын хэмжээнд газрын хэвлийд байгаа хөндөгдөөгүй геологийн нөөц, хүдрийн овоолго, баяжмалд агуулагдах мөнгө, алтны нөөцийг нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр **мөнгө 862,011.68кг**, **алт 1,187.9кг**-аар зохиогчдын тооцоолсон хувилбараар энэхүү дүгнэлтийн хавсралт хүснэгт №1-ийн дагуу хүлээн авах.

Handwritten signatures and stamps in red ink, including a large rectangular stamp with illegible text.

Хоёр. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан мөнгө-алтны үндсэн ордын нийт геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг ҮГА-ны Гео-мэдээллийн төв (Ц.Минжинсор)-д зөвшөөрөх.

Гурав. Дээрх нөөцийг хүлээн авсантай холбогдуулан АМГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 4/08 дугаар тушаалаар ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 2,773,241.8 тн хүдэрт дунджаар экв.мөнгө 300.09г/т агуулгатай 832,226.72кг экв.мөнгө (мөнгө 767915.24кг, алт 1088.58кг)-ний нөөцийг хасаж, нөөцийн хөдөлгөөн хийхийг ҮГА-ны Гео-мэдээллийн төв (Ц.Минжинсор)-д зөвшөөрөх.

Дөрөв. Энэхүү дүгнэлтийн 11 дүгээр заалтыг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК (Т.Мөнхбаяр)-д анхааруулах.

Тав. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан ҮГА-ны даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан, Геологийн баримтын төв архивт хүлээлгэн өгөхийг “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК /Т.Мөнхбаяр/-д даалгах.

Зургаа. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Салхитын мөнгө-алтны үндсэн ордын ХШ-03-08-ын хооронд 2020 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуул, нөөцийн шинэчилсэн тооцооны ажлын үр дүнгийн тайлан, түүний бүх төрлийн дээжлэлтийг Монгол Улсын мэргэшсэн геологич Г.Батбуян, Г.Ишдорж, геологич Н.Шийрэвдорж, Д.Мөнхтөр, Л.Дэлгэрсайхан, Д.Батсайхан, Б.Бүтэмж, Д.Тэгшжаргал, Б.Баттулга, Б.Батзаяа, М.Золбаатар, Ж.Мягмарцэвээн нар, геофизикийн ажлыг “Мон-Каротаж” ХХК болон “ДашМагИнж” ХХК, цооногийн каротажийн ажлыг “Юниверсаль Логгинг” ХХК, өрөмдлөгийн ажлыг “Кали Хаккин” ХХК, Гидрогеологийн судалгааны ажлыг “Тайширын хүрээ” ХХК, байр зүйн зураглалын ажлыг “Хос алтан пирамид” ХХК, химийн шинжилгээ, лабораторийн ажлыг “Эс Жи Эс Ай Эм Эм Монголиа” ХХК болон “Ханлаб” ХХК, технологи туршилтын ажлыг “МАК” компанийн Технологи туршилтын төвийн лаборатори тус тус хариуцах, тайлан түүн дэх ордын нөөцийн тооцоонд гаргасан шинжээчийн дүгнэлтийг Монгол Улсын зөвлөх геологич Ч.Энх-Амгалан, Монгол Улсын мэргэшсэн геологич Х.Төмөрбаатар нар, хайгуулын ажлын үнэн бодит байдлыг “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК хариуцах.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ
ДАРГА

А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Б.МӨНХ-ЭРДЭНЭ



ЭБМЗ-ийг оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн хуралдааны
 АХ-01-06 дүгээр дүгнэлтийн хавсралт

Салхитын мөнгө-алтны үндсэн ордны нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт
 (Ордын нөөц 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар)

Тусгай зөвшөөрлийн дугаар MV-021483

Д/д	Хүдрийн биетийн дугаар	Нөөцийн зэрэг	Блок дугаар	Эзэлхүүн, м3	Эзэлхүүний жин, т/м3	Хүдрийн нөөц, тн	Дундаж агуулга			Металлын нөөц	
							Ag, г/т		Au, г/т	Ag, кг	Au, кг
							Ag, г/т	Au, г/т	Ag, кг	Au, кг	
1	1	B	1B_1	47,381.11	2.67	126,507.56	165.16	0.47	20,894.09	59.22	
2	1	B	1B_10	43,455.45	2.67	116,026.05	156.61	0.16	18,170.92	18.62	
3	1	B	1B_11	19,212.46	2.67	51,297.27	116.37	0.14	5,969.45	7.19	
4	1	B	1B_2	44,563.11	2.67	118,983.51	225.64	0.56	26,848.01	66.62	
5	1	B	1B_3	62,003.03	2.67	165,548.10	357.44	0.6	59,173.41	98.52	
6	1	B	1B_4	84,808.39	2.67	226,438.40	428.1	0.6	96,937.72	136.85	
7	1	B	1B_5	61,077.78	2.67	163,077.67	299.91	0.41	48,908.69	66.87	
8	1	B	1B_6	45,120.01	2.67	120,470.42	415.74	0.51	50,084.41	61.6	
9	1	B	1B_7	29,193.72	2.67	77,947.24	600.01	0.63	46,769.36	49.13	
10	1	B	1B_8	27,080.09	2.67	72,303.83	601.48	0.54	43,489.47	39.24	
11	1	B	1B_9	26,949.28	2.67	71,954.58	227.12	0.23	16,342.60	16.51	
12	2	B	2B_1	38,549.16	2.67	102,926.27	307.08	0.29	31,606.31	30.27	
13	2	B	2B_10	8,037.46	2.67	21,460.01	29.18	0.17	626.19	3.72	
14	2	B	2B_11	10,526.99	2.67	28,107.06	109.06	0.26	3,065.29	7.42	
15	2	B	2B_12	8,867.20	2.67	23,675.42	60.45	0.16	1,431.16	3.82	
16	2	B	2B_13	9,894.00	2.67	26,416.98	76.68	0.2	2,025.53	5.16	
17	2	B	2B_14	660	2.67	1,762.20	58.7	0.18	103.45	0.31	
18	2	B	2B_2	73,782.12	2.67	196,998.27	442.18	0.39	87,108.72	77.62	

Хүснэгт №1

19	2	B	2B_3	84,989.13	2.67	226,920.98	251.91	0.23	57,163.95	52.7
20	2	B	2B_4	72,439.56	2.67	193,413.63	143.94	0.14	27,840.40	27.9
21	2	B	2B_5	31,492.67	2.67	84,085.44	75.08	0.14	6,312.72	11.62
22	2	B	2B_6	12,471.60	2.67	33,299.18	41.81	0.16	1,392.20	5.36
23	2	B	2B_7	8,919.64	2.67	23,815.45	21.96	0.12	523.04	2.79
24	2	B	2B_8	12,139.62	2.67	32,412.79	11.75	0.13	380.85	4.37
25	2	B	2B_9	7,659.60	2.67	20,451.13	16.12	0.2	329.7	4.14
26	4	B	4B_1	1,687.60	2.67	4,505.89	152.99	0.05	689.36	0.21
27	4	B	4B_2	4,070.68	2.67	10,868.72	56.86	0.13	617.96	1.45
28	4	B	4B_3	14,184.58	2.67	37,872.84	55.56	0.09	2,104.28	3.54
29	4	B	4B_4	10,378.80	2.67	27,711.40	48.66	0.08	1,348.42	2.12
30	4	B	4B_5	1,154.40	2.67	3,082.25	54.39	0.09	167.63	0.27
31	9	B	9B_1	483.6	2.67	1,291.21	9.06	0.23	11.7	0.3
32	9	B	9B_2	2,468.40	2.67	6,590.63	6.01	0.21	39.6	1.35
33	9	B	9B_3	7,081.20	2.67	18,906.80	10.57	0.75	199.91	14.23
34	9	B	9B_4	10,064.00	2.67	26,870.88	14.11	0.73	379.08	19.59
35	9	B	9B_5	2,914.80	2.67	7,782.52	13.78	0.16	107.22	1.23
36	9	B	9B_6	683.2	2.67	1,824.14	43.33	0.22	79.04	0.4
37	9	B	9B_7	1.6	2.67	4.27	153.5	0.4	0.66	0
Газрын хэвлий дэх нооц нийт бодитой (B) зэрэглэлээр				926,446.06	2.67	2,473,610.97	266.51	0.36	659,242.49	902.27
38	1	C	1C_1	11,796.62	2.67	31,496.97	95.59	0.07	3,010.67	2.32
39	1	C	1C_1	12,331.82	2.67	32,925.96	60.08	0.19	1,978.31	6.14
40	1	C	1C_10	4,502.19	2.67	12,020.84	52.02	0.03	625.31	0.4
41	1	C	1C_11	27,922.69	2.67	74,553.57	114.28	0.1	8,519.67	7.3
42	1	C	1C_12	3,696.59	2.67	9,869.89	63.68	0.04	628.54	0.35
43	1	C	1C_2	3,859.83	2.67	10,305.75	58.76	0.27	605.56	2.81
44	1	C	1C_3	5,748.14	2.67	15,347.54	47.35	0.37	726.63	5.63
45	1	C	1C_4	6,544.89	2.67	17,474.86	46.52	0.57	812.96	10.01
46	1	C	1C_5	5,272.55	2.67	14,077.70	14.7	0.27	207	3.81

ТҮСГЭГЧИЙН

47	1	C	1C_6	5,513.31	2.67	14,720.54	37.79	0.14	556.33	1.99
48	1	C	1C_7	11,986.25	2.67	32,003.30	214.51	0.32	6,865.15	10.39
49	1	C	1C_8	5,582.51	2.67	14,905.31	217.8	0.22	3,246.41	3.28
50	1	C	1C_9	3,674.64	2.67	9,811.30	364.12	0.32	3,572.52	3.15
51	10	C	10C_1	230.8	2.67	616.24	63.94	0.43	39.4	0.26
52	10	C	10C_2	141.2	2.67	377	140.99	0.43	53.15	0.16
53	10	C	10C_3	281.2	2.67	750.8	137.08	0.43	102.92	0.32
54	2	C	2C_1	20,106.41	2.67	53,684.11	360.81	0.43	19,369.86	22.89
55	2	C	2C_11	3,363.09	2.67	8,979.44	36.81	0.23	330.52	2.06
56	2	C	2C_12	6,480.79	2.67	17,303.71	72.41	0.26	1,252.94	4.47
57	2	C	2C_13	11,777.60	2.67	31,446.19	88.94	0.22	2,796.76	7.02
58	2	C	2C_14	10,592.40	2.67	28,281.71	48.76	0.13	1,379.10	3.7
59	2	C	2C_2	13,855.71	2.67	36,994.75	554.81	0.49	20,524.91	18.16
61	2	C	2C_3	5,500.00	2.67	14,685.00	80.65	0.08	1,184.30	1.23
62	2	C	2C_4	8,668.37	2.67	23,144.54	64.64	0.06	1,495.96	1.43
63	2	C	2C_5	12,668.80	2.67	33,825.69	78.26	0.08	2,647.19	2.84
64	2	C	2C_6	8,683.39	2.67	23,184.66	37.68	0.18	873.67	4.11
65	2	C	2C_7	2,089.85	2.67	5,579.91	22.56	0.16	125.88	0.89
66	2	C	2C_8	2,382.40	2.67	6,361.01	18.91	0.18	120.32	1.12
67	2	C	2C_9	3,498.00	2.67	9,339.66	24.96	0.15	233.09	1.42
68	4	C	4C_1	2,411.20	2.67	6,437.90	145.84	0.05	938.93	0.3
69	4	C	4C_2	2,676.80	2.67	7,147.06	115.95	0.06	828.69	0.43
70	4	C	4C_3	3,494.65	2.67	9,330.71	45.48	0.08	424.39	0.77
71	4	C	4C_4	1,682.57	2.67	4,492.46	51.56	0.39	231.62	1.76
72	4	C	4C_5	1,948.00	2.67	5,201.16	53.3	0.33	277.24	1.7
73	4	C	4C_6	2,247.20	2.67	6,000.02	65.86	0.1	395.14	0.62
74	4	C	4C_7	192.8	2.67	514.78	89.71	0.12	46.18	0.06
75	6	C	6C	4,752.40	2.67	12,688.91	8	0.28	101.49	3.56
76	9	C	9C_1	398.8	2.67	1,064.80	4.22	0.42	4.5	0.45
77	9	C	9C_2	1,646.40	2.67	4,395.89	4.93	0.33	21.67	1.44

TYG-0010

78	9	C	9C_3	4,443.20	2.67	11,863.34	9.25	0.21	109.7	2.52
79	9	C	9C_4	9,092.40	2.67	24,276.71	13.34	0.48	323.74	11.73
80	9	C	9C_5	4,755.60	2.67	12,697.45	8.98	0.29	114.02	3.69
81	9	C	9C_6	808.8	2.67	2,159.50	10.2	0.17	22.03	0.37
82	9	C	9C_7	689.2	2.67	1,840.16	45.97	0.2	84.59	0.38
86	9	C	9C_8	758.7	2.67	2,025.74	59.73	0.19	120.99	0.39
Газрын хэвлий дэх нөөц нийт боломжтой (C) зэрэглэлээр				260,750.76	2.67	696,204.52	126.3	0.61	87,929.93	159.85
Газрын хэвлий дэх нийт нөөц бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр				1,187,196.81	2.67	3,169,815.49	235.71	0.34	747,172.42	1,062.12
Овоолго бодитой (B) зэрэглэлээр				116744	2.67	280,475.18	381.06	0.42	106,879.26	116.81
Баяжмал бодитой (B) зэрэглэлээр				-	2.67	409.172	19.118	22	7,960	9.0
НИЙТ В НӨӨЦ						2,754,495.32			774,081.75	1,028.08
НИЙТ С НӨӨЦ						696,204.52			87,929.93	159.85
НИЙТ В+С НӨӨЦ						3,450,699.84			862,011.68	1,187.93



MV-021483 тоот "САЛХИТ"-ын АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙД 2020 онд ГХА-ЫН ЗАРДАЛ

Хүснэгт №-1-1

Д/д	Ажлын төрөл	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал
1	1	2	3	4	5
2	1.Бэлтгэл ажил				
3	Төлөвлөгөө зохиох	х/ө	30	1,666.67	50,000
4	Агаар, сансрын зургийн тайлалт	га	2000		
5	Бэлтгэл судалгаа	х/ө	20	133,265.00	2,665,300
6	2.Талбайн зураглал				
7	1:10000 масштабтай Геологийн зураглал	га	884.1	24,967.35	22,073,634
8	1:1000 ордын геологийн зураглал	га	68.16	24,967.35	1,701,775
9	3.Эрлийн маршрут				
10	Эрлийн маршрут	тууш.км	120	93,795.14	11,255,417
11	Эрлийн маршрут	АЦ-ийн тоо	96	93,795.14	9,004,333
12	5.Талбайн сорьцлолт				
13	Хоёрдогч Геохимийн	ш	2006	21,338.69	42,805,412
14	Цэглэн	ш	44	21,338.69	938,902
15	Анхдагч геохими	ш	7	21,338.69	149,371
16	6.Геофизикийн ажил				
17	Цооногийн каротаж	тууш м	3,133.10	17,839.05	55,891,528
18	Соронзон хайгуул	т.км	1,210.00	31,774.55	38,447,206
19	Цахилгаан хайгуулын судалгаа	ф.цэг	141.15	373,088.91	52,661,500
20	8.Өрөмдлөг				
21	Кернтэй өрөмдлөг	тууш м	7,084.00	199,119.14	1,410,560,000
22	Гидрогеологийн цооног өрөмдлөг	тууш м	622	203,135.05	126,350,001
23	10.Уулын ажил				
24	Суваг малталт /экскаватор/	куб.м	3,372.80	1,301.61	4,390,070
25	Гидрогеологийн үнэлгээ, судалгаа тайлан боловсруулалт	гэрээ			-
26	12.Сорьцлолт				
27	Чөмгөн сорьцлолт (ICP)	ш	2,528.00	5,259.27	13,295,435
28	Ховилон	ш	353	5,259.27	1,856,522
29	Петрографи ба минералогийн	ш	11	5,259.27	57,852
30	Петрографийн	ш	25	5,259.27	131,482
31	13.Топо геодезийн ажил	гэрээ			-
32	14.Хээрийн суурин боловсруулалт				
33	Керний бичиглэл	тууш м	7,084.00	3,216.99	22,789,157
34	Сувгийн бичиглэл	суваг	7	3,273,664.29	22,915,650
35	15.Байгаль орчин, хамгааллын хяналт	х/ө	90	119,777.78	10,780,000
36	16.Эрүүл мэндийн хяналт	х/ө	150	16,314.55	2,447,183
37	17.Хөдөлмөр хамгааллын хяналт	х/ө	150	38,067.29	5,710,094



38	18.Цооногийн нөхөн сэргээлтйн зардал				
39	Өрмийн талбай нөхөн сэргээх	цооног	52	120,000.00	6,240,000
40	Суваг булалт /экскаватор/	куб.м	3,373.00	228.64	771,203
41	19.Лабораторийн шинжилгээ				
42	Цэглэн дээж /ICP/	ш	44	28,165.53	1,239,283
43	ICP-н шижилгээ чөмөг	ш	2528	28,165.53	71,202,460
44	Хоёрдогч Геохимийн дээж	ш	2006	28,165.53	56,500,053
45	Нягтын дээжийн хэмжилт	ш	5	28,165.53	140,828
46	Цацраг-идэвхжилийн шинжилгээ	ш	5	28,165.53	140,828
47	20.Лаборатори	1 удаа	т.туршилт		157,992,546
48	Петрографи Минерграфийн шинжилгээ	ш	53	151,603.77	8,035,000
49	21.Тээвэр				
50	Ачаа тээвэр Ланд 64-20	т.км	21,000	89.83	1,886,430
51	Хүн тээвэр	т.км	7,650	166.88	1,276,632
52	22.Эцсийн суурин боловсруулалт				
53	Тайлан боловсруулалт	х/ө	88	34,671.59	3,051,100
54	Нөөцийн тайлан /б.цаас, плотерийн цаас, п.хор, тайлан хавтаслах,	ш	3	5,007,022.67	15,021,068
55	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	гэрээ			
56	Нөөцийн урьдчилсан ТЭЗҮ	гэрээ			15,120,000
57	Байгаль орчны суурь судалгаа	гэрээ			27,500,000
	Нийт				2,225,045,253

"Эрдэнэс силвер ресурс" ХХК-ний

тамга

Гүйцэтгэх захирал:

Геологич:

Санхүү бүртгэлийн албаны дарга:



/ Т. Мөнхбаяр /


/ Н. Шийрэвдорж /

/ Б. Ичинноров /

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ТАЛБАЙД НӨХӨН СЭРГЭЭЛТ
ХИЙСЭН ГАЗРЫГ ХҮЛЭЭЖ АВАХ АКТ**

2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

1. Байршлын мэдээлэл		
1.1	Аймаг, нийслэлийн нэр	Дундговь аймаг
1.2	Сум, дүүргийн нэр	Гурвансайхан сум
1.3	Газрын нэр	Чулуут баг, Салхит уурхай
2. Нөхөн сэргээлт хийсэн байгууллагын нэр		
2.1	Аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаар	Эрдэнэс алт ресурс ХХК, РД-6289754
2.2	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-021483
2.3	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ (га)	4.5 га
	Хийсэн ажлын хэмжээ (мян. м ³)	89,48 м ³
	Зардал (төгрөгөөр)	14,000,000
2.4	Нөхөн сэргээлт хийсэн аж ахуйн нэгжийн нэр, регистр	Эрдэнэс алт ресурс ХХК, РД-6289754
2.5	Компаний хаяг, утас	Монгол Улс, Улаанбаатар хот 14240 Сүхбаатар Дүүрэг 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 17, Блю Скай тауэр, 607 тоот. Утас: (976) 7535 1111
2.6	Нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн хүний албан тушаал, нэр, утас	Эрдэнэс алт ресурс ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн Ш.Намсрайжав, 88080733
3. 2022 онд хүлээлгэн өгч буй нөхөн сэргээлтийн мэдээлэл		
3.1 Техникийн нөхөн сэргээлт		3.2 Биологийн нөхөн сэргээлт
Талбайн хэмжээ (га) 2 га		-
Зардлын хэмжээ (төг)- 20,000,000		-
4. Орон зайн мэдээлэл		



4.1 Нөхөн сэргээлт хийгдсэн газрын фото зураг

4.2 Хэмжилт, зураглал хийсэн
Эрдэнэс алт ресурс ХХК-ний маркшейдр
Г.Цогзолмаа

Хэмжилтэд ашигласан программ Autocad
2019, тоног төхөөрөмж- DJI PHANTOM 4
RTK, Stronedone gnss
Холбогдох утас: 99950594

4.3 Нөхөн сэргээлт хийсэн газрын
солбилцол

654125.4257	5079093.38
654130.0422	5079095.658
654131.5099	5079100.716
654125.2813	5079107.153
654116.7462	5079115.27
654108.5279	5079121.826
654100.4815	5079127.269
654093.9579	5079132.187
654088.1663	5079138.58

Нөхөн сэргээлт хийсэн газарт хэмжилт хийж талбайн хэмжээг тогтоон полигон хэлбэрээр *shape.file* үүсгэн флашанд хуулж акттай хавсаргасан.

5. Мэдээллийн сангийн бүртгэл

Мэдээлэл оруулсан хүний нэр, албан тушаал:

Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Нямтуяа

Нэмэлт мэдээлэл:

Нөхөн сэргээлтийн дүгнэлт: Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон, нөхөн сэргээлт хийгдэх шаардлагатай газруудын нөхөн сэргээлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилготойгоор орон даяар "Нөхөн сэргээлт-2024" арга хэмжээг тодорхой үе шаттайгаар зохион байгуулах ажлын хүрээнд өөрийн ашиглалтын талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгээд байна.

Дээр дурдсан ажлыг Дундговь аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, хүлээж авах ажлын хэсэг өмнөх оны буюу 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний жилийн эцсийн дүгнэлтийн 2023 оны төлөвлөгөөнд зайлшгүй тусгах арга хэмжээний хэсэгт тодорхой тусгаж оруулсан байдаг.

Орон нутгийн зүгээс "Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд уг ажлыг тусган хэрэгжүүлэхийг даалгасны дагуу 2023 оны 10 дугаар сарын 13 -наас 2023 оны 10 дугаар сарын 20-ны хооронд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөсөн хэмжээнд бүрэн хийж хүлээлгэн өгсөн.

Тус ажлын явцын болон эцсийн гүйцэтгэлд Гурвансайхан сумын ажлын хэсэг газар дээр нь очиж хяналт тавьж, хүлээн авч ажилласан. "Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн Маркшейдерийн хэмжилтээр нийт 4,5 га талбайд 89,48 м³ шорооны ажлыг ухмалын талбайд зөөвөрлөж техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хангалттай сайн зохион байгуулж ажилласан гэж дүгнэж байна.

АКТ ГАРГАСАН:

КОМИССЫН ДАРГА:

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН
СУМЫН ЗАСАГ ДАРГА



Э.АДЪЯАБААТАР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН



Г.АЛТАНГЭРЭЛ

ГИШҮҮД:

ЧУЛУУТ БАГИЙН ЗАСАГ ДАРГА

ЧУЛУУТ БАГИЙН МАЛЧИН



Д.ЭРДЭНЭБАТ


ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС ХХК-НИЙ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС ХХК-НИЙ
МАРКШЕЙДР



Ш.НАМСРАЙЖАВ



Г.ЦОГЗОЛМАА

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000156316

2018.03.23

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011734009

/ Хувийн хэргийн дугаар /

6289754

/ Регистрийн дугаар /

Эрдэнэс алт ресурс

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол

6

2018.03.13

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

8299

/ код /

Бизнесийн зөвлөгөө

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

1

100,000.0

/ хугацаа /

/ гишүүдийн тоо /

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, чингисийн өргөн чөлөө, 15-р барилга, 15 давхарт, Утас1: 0, Утас2: ,
Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Оюуны өмч, улсын бүртгэлийн
ерөнхий газар Хуулийн этгээдийн
бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /



Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлийн бүртгэл
Хувийн хэргийн гэрээгээр үйлдвэрлэлийн хувьцаа эзэмшдэг байгууллага

Д/д	Нэмэлт өөрчлөлийн агуулга	Огноо	Бүртгэсэн Ажилтан тэмдэг Б.Лхаасурэн
1	Сумъяа овогтой Эрдэнэбулган-агийнхэн гэгээтэй иргэнийн хувьцаа эзэмшдэг байгууллага Эрдэнэбулган-агийнхэн гэгээтэй иргэнийн хувьцаа эзэмшдэг байгууллага	2018.03.23	Б.Лхаасурэн
1	Дорж овогтой Арунболд -агийнхэн гэгээтэй иргэнийн хувьцаа эзэмшдэг байгууллага Дорж овогтой Арунболд -агийнхэн гэгээтэй иргэнийн хувьцаа эзэмшдэг байгууллага	2018.05.03	Б.Лхаасурэн Ж.Нямдорж Г.Алтани
2	Дүрмийн шинэчилсэн нэвтрүүлэг бүртгэв.	2018.07.09	
3	Бондаатар овогтой Ачуйсдэвхэн -агийнхэн гэгээтэй иргэнийн хувьцаа эзэмшдэг байгууллага Дүрмийн 1.2, 5.1, 6.1, 7.2, 7.3.1, 7.3.5, 7.3.7, 7.3.9, 7.3.12, 7.3.13, 11.1, 11.2, - т оруулсан өөрчлөлт бүртгэв.	2019.03.05	Ш.Очирсүрэн
4	Дүрмийн 5.1 заалт оруулсан өөрчлөлт бүртгэв.	2022.11.28	Ш.Очирсүрэн
5	Дүрмийн 5.1 заалт оруулсан өөрчлөлт бүртгэв.	2023.01.09	Ш.Очирсүрэн
6	Шинэчилсэн дүрэм бүртгэв.	2023.05.22	С.Бавсандулам
7	Эрдэнэчулуун овогтой Ш.Ганбаяр-агийнхэн гэгээтэй иргэнийн хувьцаа эзэмшдэг байгууллага Орлон гэгээтэй иргэнийн хувьцаа эзэмшдэг байгууллага	2023.10.18	С.Бавсандулам

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлийн бүртгэл



БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТААР ИЛЭРСЭН ҮЛ НИЙЦЛИЙГ АРИЛГАХ 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН



2023 он

ОРШИЛ

“Эрдэнэс алт ресурс” ХХК –ийн хэрэгжүүлж буй Дундговь аймгийн Гурвансайхан сумын Чулуут багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Салхитын мөнгө-алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаатай танилцаж Монгол улсын байгаль орчны холбогдох хууль, дүрэм, журам, стандартаар тавигдах шаардлагатай хэрхэн нийцэж байгааг тогтоохоор 2022 оны Байгаль орчны төлөвлөгөөт аудитын ажлыг “Мон газар консалтинг” ХХК 2022 оны 6, 7 дугаар сард хийж гүйцэтгэсэн.

“Эрдэнэс алт ресурс” ХХК –ийн “Салхитын мөнгө-алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2022 оны Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг Уурхайн үйл ажиллагааны 2020, 2021 оныг хамрах өмнөх хугацааны хүрээнд хийгдсэн уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хамруулсан бөгөөд агаар болон усан орчны менежмент, хөрс, газар ашиглалт, хог хаягдал, химийн бодис, технологи, хөдөлмөр аюулгүй ажиллагаа, биологийн олон янз байдлын менежмент зэрэг чиглэлүүдээр 2022 оны Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг хийв.

Байгаль орчны төлөвлөгөөт аудитын ажлын хүрээнд Байгаль орчны холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартаас гадна төслийн БОННУ, БОМТ, ОХШХ-ийн хэрэгжилтийг авч үзлээ. Тус “Мон газар консалтинг” ХХК-ийн 2022 оны Байгаль орчны төлөвлөгөөт аудитын дүнгээр 211 шалгуур үзүүлэлтээр байгаль орчны хууль, дүрэм, журам, стандарт болон бусад шаардлагуудын биелэлтийг шалгаж үзэхэд 196 шалгуур нийцтэй, 12 шалгуур үл нийцэлтэй, 1 шалгуур хугацаа болоогүй, 2 шалгуур тодорхой бус гэж үнэлэгдсэн байна. Төсөл хэрэгжүүлэгчийн Байгаль орчны гүйцэтгэл аудитын шалгуурын хүрээнд 93.3%-ийн биелэлттэй гарсан нь **хангалттай** гэж үнэлэгдсэн.

Аудитын дүнг энэ бүлгийн дэд бүлгүүдэд байгаль орчны менежментийн хэсэг тус бүрээр авч үзсэн болно. Аудитын явцад илэрсэн 12 үл нийцлийг ангилж үзэхэд баримт бичигтэй холбоотой 3 үл нийцэл, ажлын гүйцэтгэлтэй холбоотой 9 үл нийцэл байна.

Хүснэгт 13. Байгаль орчны аудитын нэгдсэн хүснэгт



Дээрх аудитын дүнг үндэслэн “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Салхитын мөнгө-алтны үндсэн ордыг ашиглах” төсөлд байгаль орчны хууль, дүрэм, журмын хүрээнд хүлээсэн үүргээ 93.3%-ийн үзүүлэлттэй биелүүлжээ гэсэн нэгдсэн дүгнэлт гарсан.

Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн уурхайн үйл ажиллагаа хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд тухайлбал БОННУ, ТЖБОМТ, БОА, ГТБ, ЧУХБ зэрэг байгаль орчны мэргэжлийн байгууллагаар хийлгэх судалгаа, зөвлөх үйлчилгээний ажлуудыг цаг тухай бүрт нь гүйцэтгэж, жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хангалттай

үнэлгээгээр биелүүлж, орон нутгийн захиргаа, иргэдтэй нягт хамтран ажиллаж, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх талд ач холбогдол өгч ажиллаж ирсэн байна гэж дүгнэсэн.

Аудитын тайлангийн явцад аудит хийлгэгч талбай харилцан санал солилцож, зөвшилцөж ажилласан ба аудитын явцад илэрсэн үл нийцлийг арилгах, цаашид үйл ажиллагааг сайжруулах шат ахиулахад чиглэсэн санал, зөвлөмж өгч аудитын тайланг боловсруулав.

2022 оны Байгаль орчны төлөвлөгөөт аудитын хяналт шалгалтын дүнд өгсөн зөвлөмжийн дагуу 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлж байсан. Мөн 2023 оны хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлж байна.

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТААР ИЛЭРСЭН ҮЛ НИЙЦЛИЙГ АРИЛГАХ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023.11.22

Салхит уурхай

№	Үл нийцэл болон авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд	Гүйцэтгэх хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилт, тайлбар	Хувь
АУДИТЫН ЕРӨНХИЙ НИЙЦЭЛ					
1	Эргэлтийн усан сангийн ашиглаж дууссан хуурай хаягдал, лагийн санг нөхөн сэргээх, дахин ашиглах арга замыг шийдвэрлэх	Жилийн турш	Эргэлтийн усан сангийн ашиглаж дууссан хуурай хаягдал, лагийн санг лайдах ажлуудыг зохион байгуулж ажилласан байна.	Эргэлтийн 3 дугаар усан санг Аглаг хангайн уулс ХХК нь үе шаттайгаар нийт 12 чайныг дренаж насосоор laidан суллах ажлыг хийсэн. Мөн хуурай хаягдлыг 1 дүгээр хаягдлын санд төвлөрүүлж ажилласан. 2022 онд 3 дугаар хаягдлын даланг шинээр барьж ашиглалтанд оруулсан бол 2023 онд 1 болон 2 дугаар хаягдлын даланг нийлүүлж хаягдлын даланг томсгох ажил хийгдсэн. Цаашид хаягдлыг дахин ашиглах талаар богино хугацааны лабораторын туршилт хийсэн бөгөөд үйлдвэрийн насжилтийг нэмэгдүүлэх үүднээс бага агууллагатай хүдэртэй хольж үйлдвэр тэжээх судалгааны ажил 2 дугаар лаборатори бүрэн ашиглалтанд орсны дараа үргэлжлүүлэн хийгдэх юм.	100%
2	2022 оны 4 дүгээр улиралд багтаан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт	2022 оны 4 дүгээр улиралд	Чулуут багийн ИНХ-аар хэлэлцүүлэн хурлын тогтоол,	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг дэмжих тухай	100%

	тодотгол ажлыг боловсруулах, тайланг Чулуут багийн ИНХ-аар хэлэлцүүлэн хурлын тогтоол, тэмдэглэлийг тайланд хавсаргах		тэмдэглэлийг гаргуулж тайланг хавсаргасан байна.	Гурвансайхан сумын Чулуут багийн ИНТ-ын хурлын тогтоолыг 2022 оны 09 сарын 29-нд гаргуулсан. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг “Найчрал Састайнэблэ” ХХК боловсруулсан.	
УСНЫ МЕНЕЖМЕНТ					
3	Баяжуулах үйлдвэрийн хойно байрших 2 дугаар усан сангийн байрыг засаж тохижуулах, дээврийн эвдрэлийг засаж сэлбэх	2022, 2023	2 дугаар усан санг засаж тохижуулсан байна.	Диаметр 76 мм ган хоолойгоор дээврийн бэхэлгээ болон тулаасыг хүчитгэн засварласан. Цаашид хийх засварыг 2023 онд хийхээр төлөвлөн ажиллаж байсан боловч компани татан буугдаж Эрдэнэс алт ресурс ХХК-тай нэгдэх үйл явцаас хөрөнгө оруулалтын ажлууд царцаж ирэх онд хийхээр хойшлогдсон.	50%
4	Уурхайн унд ахуйн хаягдал ус зайлуулах цэг, бие засах газрыг дахин төлөвлөх, одоо ашиглаж буй нүхэн жорлонгийн ашиглалтыг зогсоох, ариутгал халдваргүйжүүлэлт хийж бохирдлыг арилгах	Жилийн турш	Уурхайн унд ахуйн хаягдал ус зайлуулах цэг, бие засах газруудын ариутгал халдваргүйжүүлэлт хийж бохирдлыг арилгах арга хэмжээ авсан байна.	Уурхайн хэмжээнд 2021 онд нийт 6 ширхэг нүхэн жорлон ашиглагддаг байсан бөгөөд 2022 онд 4 ширхэг нүхэн жорлон, 2023 онд 3 жорлон ашигладаг болж багасгасан. Сидар ХХК, Соёолон интернэшнл ХХК-ний ажилчдын кемпийн бохирыг цэвэрлэх байгууламжтай холбосон. Мөн Аглаг хангайн уулс ХХК-ний ажилчдын кемпийн ахуйн хэрэглээнээс үүссэн шингэн хаягдлыг зориулалтын газар доорх бохир ус хадгалах ёмкостонд түр хадгалж их хэмжээгээр	100%

				<p>хуримтлагдсан тохиолдлуудад Дундговь аймгийн бохир ус хүлээн авах газартай гэрээ байгуулан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан. 2022 онд нийт 85 рейс буюу 1275 тн бохир ус, 2023 онд 35 рейс буюу 525 тн бохир усыг Дундговь аймгийн бохир усны байгууламжинд тээвэрлэж төвлөрүүлсэн.</p> <p>Ариутгах хийх ажлын хүрээнд Наранбулаг ХХК-тай гэрээ байгуулж Ариутгал халдваргүйжүүлэлт"-ийн үйлчилгээг уурхайн дээд, доод кемп, оффис, нүхэн жорлонгуудад 2 удаа ариутгах ажлыг зохион байгуулж ажилласан.</p>	
5	Жил бүрийн ус ашиглуулах дүгнэлтэд тусгасан төсөл хэрэгжүүлэгчид тавих шаардлага, цаашид авах арга хэмжээний зөвлөмжийг хэрэгжүүлэх	Жилийн турш	Ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж, зөвлөмжийн дагуу арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүлж ажилласан байна.	Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас 2022 оны ус ашиглуулах дүгнэлтийг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдөр гаргуулсан. 2023 оны ус ашиглуулах дүгнэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр гаргуулсан. Тус дүгнэлтийн дагуу Умард говийн гүвээт-Халхын дундад тал сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, ус бохирдуулсны төлбөрийн гэрээг	100%

				зохих журмын дагуу гаргуулан авч ажилласан.	
6	Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг гаргуулнаас хойш буюу 2021-2022 онд нэмэлтээр худаг гаргуулан ашиглаж байгаа тул Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг БОННУ-ий ажлын хүрээнд 2022 онд багтаан “Усны газар”-аар гаргуулах	2022, 2023	Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг БОННУ-ий ажлын хүрээнд 2022 онд багтаан “Усны газар”-аар гаргуулсан байна.	Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг БОННУ-ий ажлын хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр (04/1088 тоот албан бичиг) гаргуулсан.	100%
7	Хаягдлын сангийн битүүмжлэлийг сайжруулах, гадар геомембран бүрхэвчийн эвдрэл гэмтлээс сэргийлэх, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж байх, хяналт мониторингийн цооногуудын аюулгүй ажиллагаанд байнгын хяналт хийх	Жилийн турш	Хяналт мониторингийн цооногуудын аюулгүй ажиллагаанд байнгын хяналт хийж ажилласан байна.	2022 онд шинээр баригдсан 3 дугаар хаягдлын сангийн хяналт болон байгаль орчны цооног өрөмдөх ажлыг “Энх-Өрнөлт” ХХК-тай гэрээ байгуулж 2022.08.03-2022.08.05 өдрүүдэд талбай дээр өрөмдлөгийн ажлыг гэрээний хугацаанд чанартай хийж гүйцэтгэн дуусгасан. Нийт 4 ширхэг байгаль орчны мониторинг цоонгыг өрөмдөж, өрөмдсөн цоонгоос дээж авч итгэмжлэгдсэн лабораторт хүргүүлж ажилласан. Мөн 1, 2 дугаар хаягдлын сангийн байгаль орчны хяналтын мониторинг цооногт 2022 онд нийт 2 удаагийн мониторинг хийж байнгын хяналт шалгалтыг хийж ажилласан. 2023 онд 1 болон 2 дугаар хаягдлын даланг нийлүүлж хаягдлын даланг томсгох ажлыг PSST ХХК хийж	100%

				гүйцэтгэсэн. 2023 онд хаягдлын далангын оролт, гаралт, байгаль орчны хяналтын цоонгуудаас нийт 5 удаагийн дээж авч Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын хяналтын төв лабораторт хүргүүлж шинжлүүлж ажилласан.	
ХӨРС ХАМГААЛАЛ, ГАЗРЫН МЕНЕЖМЕНТ					
8	Уурхайн техник засварын газрын зүүн хэсэгт уурхайн овоолгын дэргэд их хэмжээгээр хуримтлагдсан хаягдал төмрийг АХХ хураах талбайд зөөвөрлөн шилжүүлэх, улмаар төмрийн хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдэд түүхий эд болгон нийлүүлэх	Жилийн турш	Их хэмжээгээр хуримтлагдсан хаягдал төмрийг АХХ хураах талбайд зөөвөрлөн шилжүүлэх, улмаар төмрийн хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдэд түүхий эд болгон нийлүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	Уурхайн овоолгын дэргэд их хэмжээгээр хуримтлагдсан хаягдал төмрийг 2023 оны 01 дүгээр сарын 27-ноос 2023 оны 01 дүгээр сарын 30-ны хооронд төвлөрсөн талбайд зөөвөрлөн шилжүүлэх ажлыг зохион байгуулсан. Одоогоор дахин ашиглаж байна. Ирэх онуудад гэрээт компаниудад нийлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	90%
9	Тос тосолгооны материалаар бохирдсон авто засварын газар, ШТС-ийн орчмын хөрснөөс дээж авч эрдэс тосны агууламжийг хэмжих талаар хөрсний хяналт шинжилгээний хуваарьт тусгах	Жилийн турш	Орчны хяналт шалгалтын хөтөлбөрийн тогтмол дээж авдаг хяналтын дээж талбайд оруулж, хөрсний дээжийг итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлж ажилласан байна.	Орчны хяналт шалгалтын хөтөлбөрийн хүрээнд засварын газар, шатахуун түгээх станцын ойр орчмоос хөрсний дээжийг улиралд 1 удаа авч итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлж ажилладаг. Хөрсний бохирдол үүсгээгүй гэсэн дүгнэлт гарсан. Нийт 4 удаа дээж авч шинжлүүлсэн.	100%

10	Төслийн талбайд уурхайн суурин болон баяжуулах үйлдвэрийн дэргэдэх уурын зуухны орчимд ил задгай хөрсөн дээр нүүрс буулгахгүй байх, нүүрс хадгалах зориулалтын агуулах барих, нүүрс ачиж буулгах зориулалт бүхий хатуу хучилттай зам талбайг барьж тохижуулах	Жилийн турш	Тус ажлыг зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Уурын болон халаалтын зуухнуудын гадна талбайд нүүрс түр хадгалах зориулалт бүхий ачиж буулгах талбайг бетонон хаалт хашилттайгаар хийж гүйцэтгэн хашаажуулсан. Нүүрс зөөх цутгамал замыг хийсэн. Нүүрс хадгалах, ачиж буулгах талбайн шимт хөрсийг хуулж хайргаар дэвсэлт хийж нягтруулан зориулалт бүхий талбайг тохижуулж ажилласан.	70%
БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ХАМГААЛЛЫН МЕНЕЖМЕНТ					
11	Уурхайн орчимд бүтээн байгуулалтын шатанд эвдэрсэн талбайг нөхөн сэргээх ажлыг хэрэгжүүлж дотоод орчинг зүлэгжүүлэх, тохижуулах, ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	Жилийн турш	Уурхайн орчимд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.	Кемп, оффисын орчимд 7 дугаар сард 4000 ширхэг хайлаасаар нөхөн тарилтыг хийж ногоон байгууламжийг нэмэгдүүлж ажилласан.	100%
12	Монгол улсын ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжиж буй “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тухайн төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс нийгмийн хариуцлагын ажилтай холбогдуулан мод тарих, тарималжуулах ажлыг Гурвансайхан сумын захиргаатай хамтран хэрэгжүүлж ажиллах	2022, 2023	“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд ЭСР ХХК 3 сая мод тарих үүрэг даалгавар авсны дагуу Их газрын чулуу, Салхит уурхайн орчимд мод тарих ажлыг зохион байгуулж ажилласан байна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Тэрбум мод” тарих томоохон төсөл хэрэгжиж байгаа. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК 2022 оны 05 дугаар сарын 20-ний өдөр Их газрын чулууны байгалийн цогцолборт газарт 1 га талбайд усалгааны иж бүрэн систем бүхий ногоон зурвас, чацарганы талбайг байгуулсан. Нийт 1250 мод тарьсан. Мөн Салхит уурхайн орчимд 6 га талбайд 2022 оны 10 дугаар сарын	100%

				15-ний өдөр 20,000 ширхэг хайлаас мод тарих үйл ажиллагааг зохион байгуулсан. 2023 онд намрын бүх нийтээр мод тарих өдөрлөгөөр 5000 хайлас, хаврын мод тарилтаар 3000 хайлас, 2000 шар хуайс Эрдэнэс ногоон төгөлд нэмж тарьсан. Мөн Дундговь аймагт 30000 хайлас хүлээлгэн өгч ажилласан.	
АГААРЫН ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТ					
13	Баяжуулах үйлдвэр болон техник засварын төвийн халаалтын зуухны янданд /нүүрс түлдэг цэгэн эх үүсвэрт/ утаа шүүгч фильтр, шүүлтүүр нэмэлт төхөөрөмжийг суурилуулж ашиглах	Жилийн турш	Тус ажлын хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Баяжуулах үйлдвэр болон техник засварын төвийн халаалтын зуухны янданд утаа шүүгч фильтр суурилуулсан.	100%
14	Уурхайн дотоод тээврийн замыг засвар арчилгаа, усалгааг тогтмол хийх	Жилийн турш	Дотоод тээврийн замыг засвар арчилгаа, усалгааг тогтмол хийж ажилласан байна.	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор дулааны улиралд усалгааг тогтмол хийдэг. Уурхайн доторх болон дэд бүтцийн шугамын дагуух замуудыг дулааны улиралд өдөр бүр, түгээмэл ашиглагддаг замуудад өдөрт 2-3 удаа тоожилт үүсэхээс сэргийлж усалгааг хийж гүйцэтгэдэг. Хүйтний улиралд дулаан өдөр усалгааг хийж гүйцэтгэж байна. 2022 онд нийт 4860 м ³ ус, 2023 онд 3750 м ³ усыг зам талбайн усалгаанд ашигласан.	100%

15	Зуухны галлагаагаар хийж буй дулаан хангамжийн үйл ажиллагаанд хувилбаруудаас (дулаан хангамжийн цахилгаан эх үүсвэрээр орлуулах, шинэ технологийн сэргээгдэх эх үүсвэр буюу нар салхины эх үүсвэр эсхүл байгаль орчинд халгүй эх үүсвэр буюу хийн түлшний эх үүсвэр бүхий дулаан хангамж, өөрийн суурилуулсан эх үүсвэрүүдийг утаа шүүх, хий цэвэрлэх нэмэлт багаж тоног төхөөрөмжөөр тоноглох) дан байдлаар болон хосолмол байдлаар сонгон хэрэгжүүлж агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авах	Жилийн турш	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажилласан байна.	Зуны улиралд хэрэглээний халуун усыг цахилгаан бойлероор халааж байгаа бөгөөд нэмэлтээр 2 ширхэгийг суурилуулсан. Ирэх онд агаар бохирдлыг багасгах зорилгоор үе шаттайгаар арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллаж байна.	50%
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ					
16	Уурхайн хог хаягдлын нэгдсэн цэгийг таглаа битүүмжлэл бүхий, хур бороогоор угаагдах болон салхинд хийсч орчныг бохирдуулах нөхцлийг хязгаарлах төмөр хийц бүхий хогийн цэгийг байгуулах	2022, 2023	Хур бороогоор угаагдах болон салхинд хийсч орчныг бохирдуулах нөхцлийг хязгаарлах төмөр хийц бүхий хогийн цэгийг байгуулсан байна.	2022 онд уурхайн ахуйн хог хаягдлын нэгдсэн цэгийг стандартын дагуу тэмдэгжүүлэлтийн ажлыг хийсэн. Мөн 2023 онд төвлөрсөн хогийн цэгийг тохижуулах ажлын даалгаврыг боловсруулан Худалдан авалтын хэлтэст хүргүүлсэн. Тус ажлын хүрээд 20.000.000 төгрөгийн тендер зарласан боловч одоогоор сонирхсон компани байхгүй байгаа тул 2024 онд хийгдэхээр хойшлогдоод байна.	80%

17	Техник засварын газар болон ШТС-ын орчимд хуримтлагдсан ажилласан тос, техникийн шингэнийг АХХ хураах талбайд зөөвөрлөн шилжүүлэх, улмаар хоёрдогч байгууллагад тушаах	Жилийн турш	Зөвлөмжийн дагуу хуримтлагдсан ажилласан тос, техникийн шингэнийг тусгай зориулалтын талбайд зөөвөрлөн шилжүүлэн хурааж, улмаар хоёрдогч байгууллагад тушаах ажлыг зохион байгуулж ажилласан байна.	<p>Байгаль орчны журмын хүрээнд Эрдэнэс силвер ресурс ХХК-ний инженер, техникийн ажилчид, Сидар ХХК-тай хамтран 2022 оны 08 дугаар сарын 07-ноос 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрүүдэд авто засварын газар, ШТС-ийн орчимд их хэмжээгээр хураагдсан тоснуудыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулсан. Нийт 6 тонн тосыг төвлөрсөн хогийн цэгийн зориулалтын талбайд тээвэрлэж төвлөрүүлж ажилласан. Одоогоор Сидар ХХК, Соёолон интернэшнл ХХК, Аглаг хангайн уулс ХХК, Эрдэнэс алт ресурс ХХК-ны тос, техникийн шингэнийг төвлөрүүлж байнгын бүртгэл хөтөлж ажилласан.</p> <p>2023 онд аглаг хангайн уулс ХХК 5 тонн тосыг хоёрдогч байгууллагад тушаах ажлыг зохион байгуулсан. Ирэх онуудад бусад компаниудыг тушаах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	90%
----	--	-------------	---	---	-----

18	Уурхайн дахин боловсруулах боломжтой барилгын материалын хаягдал, техникийн хаягдал, хаягдал төмрийг төрийн өмчийг зохицуулах төрийн байгууллагад танилцуулж шийдвэрлэх ажлыг “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн удирдлагын түвшинд анхаарч ажиллах, зохих байгууллагад нийлүүлэх	Жилийн турш	Хоёрдогч байгууллагад тушаах ажлыг зохион байгуулж судалсан байна.	Дахин боловсруулах боломжтой барилгын материалын хаягдал, техникийн хаягдал, хаягдал төмөр, хоолойнуудыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлдэг. Төвлөрүүлсэн дахин ашиглах хаягдлуудаа буцаан ашиглаж хэрэглэж байна. Мөн ашиглахгүй хаягдлуудаа мэргэжлийн байгууллагуудад нийлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	70%
19	“Химийн хортой болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахын барилгад тавих ерөнхий шаардлага” MNS 6458:2014 стандартыг мөрдөж ажиллах, баяжуулах үйлдвэрийн химийн бодисын агуулахад нэмэлтээр тавиур болон шалавчыг байршуулах	Жилийн турш	MNS 6458:2014 стандартыг мөрдөж, баяжуулах үйлдвэрийн химийн бодисын агуулахад нэмэлтээр тавиур болон шалавчыг байршуулах ажлыг зохион байгуулсан байна.	Аглаг хангай уулс ХХК нь 2022 онд баяжуулах 1 дүгээр үйлдвэрт 6 нэр төрлийн химийн бодис, Соёолон Интернэшнл” ХХК-ийн баяжуулах 2 дугаар үйлдвэрт 6 нэр төрлийн химийн бодисуудыг технологийн горимын дагуу үйл ажиллагаандаа ашигласан. Тус бодиснуудыг 2 үйлдвэрийн 2 химийн бодисын агуулахад стандартын дагуу ангилан, тэмдэгжүүлж ашигласан. Мөн химийн бодисын агуулахад шат, тавиур, хаягжуулалт, тасалгаа хийж эмх цэгцтэй хураасан.	100%
ТЕХНОЛОГИ, ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА					
20	2022 оны Уурхайн үйл ажиллагааг бүхэлд нь хамруулсан галын аюулын дүгнэлт, зөвшөөрлийг гаргуулах	2022, 2023	2022 оны Галын аюулын дүгнэлт, зөвшөөрлийг гаргуулсан байна.	2022 оны галын аюулын дүгнэлт, зөвшөөрлийг 2022 оны 11 дүгээр сарын 10-нд гаргуулсан. Мөн 2022 оны 4 дүгээр сарын 2, 2022 оны 11 дүгээр сарын 10-нд галын аюул,	100%

				<p>гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх сургалтыг нийт 2 удаа зохион байгуулж ажилласан.</p> <p>2023 оны баяжуулах үйлдвэрийн Галын аюулгүй байдлын дугаар 0005637 дүгнэлтийг 2023 оны 02 дугаар сарын 17-нд авсан.</p> <p>Тэсрэх бодисын агуулах ампо, эмүльс 40 тонн, 7 агуулах, 20 тонн 1 агуулахын галын аюулгүй байдлын дугаар 0005901 зөвшөөрлийг 2023 оны 02 дугаар сарын 17-нд авсан.</p> <p>Шатахуун түгээх станц АИ-92, Дизедь түлш 50 тонн 2 сав галын аюулгүй байдлын дугаар 0005902 зөвшөөрлийг 2023 оны 02 дугаар сарын 17-нд авсан.</p>	
21	Шатахууны агуулахыг ашиглахдаа “Шатахуун түгээх станц барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага” MNS 4628:1998 стандартыг шаардлагыг мөрдөж ажиллах	Жилийн турш	MNS 4628:1998 стандартыг шаардлагыг мөрдөж ажилласан байна.	Шатахуун түгээх станцын байрлал нь уурхайн автозасварын цехийн ойролцоо байрлалд байрладаг. Галын аюулаас хамгаалах хэрэгслүүдийг шинэчлэн байршуулсан, гадна зам талбайг тэгшилж стандартын дагуу болгох болон бусад тохижилт сайжруулалт, засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.	100%

				2021 оны 10 дугаар сарын 14-наас UB OIL ХХК хариуцан үйл ажиллагааг явуулж байна. Тус Шатахуун түгээх станц нь дизель түлшний 50 тоннын 2 ширхэг ёмкос, 3 ширхэг гэрэлтүүлэг, 2 түгээгүүр, цутгамал суурьтай. Тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэдээллийн самбар зэргийг байршуулж ажилласан.	
22	Хөдөлмөрийн аюулгүй байдлын бүх хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажиллах	Жилийн турш	Хөдөлмөрийн аюулгүй байдлын бүх хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажилласан байна.	<p>Ил Уурхайн бүх ажлыг “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн дагуу технологийн үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> • Уурхайн тэсэлгээний ажилд “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн холбогдох заалтуудыг мөрдлөг болгон тэсэлгээний ажлыг гүйцэтгэх компанид гэрээнд заасны дагуу шаардлага тавьж ажилласан. • Уурхайн ажлуудыг аюулгүй явуулахад шаардлагатай хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой журам, зааварчилгаануудыг боловсруулж, ажилтан бүрт танилцуулж, журмын биелэлтэнд тогтмол хяналт тавьж ажилласан. • Объектын болон техник тоног 	100%

				<p>төхөөрөмжийн галын унтраагуурыг бүртгэж, үзлэгийг төлөвлөсөн хугацаанд тогтмол хийж ажилласан.</p> <p>Мөн 3 шатны дотоод хяналтын журмыг даган мөрдүүлэн хяналт тавьж ажилласан.</p>	
23	2022 оны Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гаргаж батлуулах	2022 оны 2 дугаар улиралд	2022 оны Гамшигаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж байна.	<p>2022 оны Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Дундговь аймгийн Онцгой байдлын газраар 2022 оны 4 дүгээр сарын 10-нд батлуулсан. 2023 оны Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Дундговь аймгийн Онцгой байдлын газраар 2023 оны 08 дугаар сарын 14-нд тодотгол хийж батлуулсан.</p> <p>2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр “Дат консалтинг” ХХК-иар Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажил хийгдэж 2023 оны 11 дүгээр сарын 21-нд Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний тайланг хүлээн авсан.</p>	100%

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:

САЛХИТ УУЛЫН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЗАХИРЛЫН

ҮҮРЭГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

САЛХИТ УУЛЫН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН АХЛАХ

ИНЖЕНЕР

Ч.БОЛДБААТАР

М.ЗОЛБААТАР

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ БИЧСЭН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Ш.НАМСРАЙЖАВ

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТТЭЙ ТАНИЛЦСАН:

ХАБЭА-Н АХЛАХ ИНЖЕНЕР

Б.НЯМСҮРЭН

ДЭД БҮТЦИЙН АХЛАХ ИНЖЕНЕР

С.НАРАНБААТАР

2023 оны 11 сарын 22

ДҮГНЭЛТ

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх, ашигт малтмал эрэх, хайх, олборлох, ашиглах, өрөмдлөг хийх ерөнхий чиг үүргээс гадна “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль”, “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-аар заасан тусгай үүргийг мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хүрээнд Засгийн газрын 2019 оны 26 дугаар тэмдэглэл, Ашигт малтмал, газрын тосны газрын 2019 оны 341 дүгээр шийдвэрээр Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Салхит нэртэй 2887.85 га талбай бүхий ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг тус компанид олгосон. Дээрх шийдвэрийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас улсын төсвийн тогтвортой эх үүсвэрийг шинээр бий болгох, салбарын нөөц боломжийг зохистой ашиглах зорилгоор Салхитын мөнгө-алтны ордын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хууль тогтоомжийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл авах, ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагааг боломжит богино хугацаанд цаг алдалгүй эхлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэг чиглэл тус компанид өгсөн. АМГТГ-ын Кадастрын хэлтэст хайгуулын тусгай зөвшөөрлийн Салхитын мөнгө-алтны ордын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хууль тогтоомжийн хүрээнд ашиглалтын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гарган MV-021483 дугаартай Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2019 оны 10 сарын 17-ны өдөр хүлээн авч үйл ажиллагаа эрчимжүүлэн ордын үр өгөөжийг нэмэгдүүлж Монгол Улсын эдийн засагт хувь нэмрээ оруулах төр, хувийн хэвшлийн хамтарсан уул уурхайн салбарын шинэ жишиг төслийг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.

Эрдэнэс алт ресурс ХХК нь уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаварыг тогтмол хянах ажлыг зохион байгуулж ажилласан.

Салхитын мөнгө-алтны ордын олборлолт, уулын баяжуулах үйлдвэр, геологи эрэл хайгуулын ажил болон бусад үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойшхи хугацаанд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон болон байгаль орчны аудитаар илэрсэн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэжээний төлөвлөгөөг боловсруулан, аудитын үл нийцлийг арилгах төлөвлөгөөний дагуу нийт 23 төрлийн ажлын биелэлтийг ханган ажилласан бөгөөд 2022 оны байдлын төлөвлөгөөний хэрэгжилт 79%-тай, 2023 онд үл нийцлийг арилгах төлөвлөгөөний биелэлт 91.3%-тай хэрэгжүүлж ажилласан.



**САЛХИТ УУЛЫН БАЯЖУУЛАХ
ҮЙЛДВЭРИЙН ХИМИЙН БОДИСЫН
АШИГЛАЛТ, ЗАРЦУУЛАЛТЫН 2023
ОНЫ ТАЙЛАН**



2023 он

**САЛХИТ УУЛЫН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ХИМИЙН
БОДИСЫН АШИГЛАЛТ, ЗАРЦУУЛАЛТЫН 2023 ОНЫ
ТАЙЛАН**

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021483

Регистерийн дугаар: 6289754

ХЯНАСАН:

САЛХИТ УУЛЫН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.БОЛДБААТАР

САЛХИТ УУЛЫН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН
АХЛАХ ИНЖЕНЕР

М.ЗОЛБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Ш.НАМСРАЙЖАВ

ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР

Б.ХЭРЛЭНЦОГ




2023 оны 11 сарын 15

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....1
2. БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ХИМИЙН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ.....2-5
3. ХИМИЙН БОДИСЫН ХОГ ХАЯГДАЛ, УСТГАЛ.....5-7
4. ХИМИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ.....7-11
5. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАХ ГЭРЭЭНҮҮД.....11-41

1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:	“Салхитын мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах” төсөл
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:	“Эрдэнэс силвер ресурс” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011734009, Регистрийн дугаар: 6289754
Төсөл хэрэгжүүлэгчийн мэйл хаяг:	info@erdenesgold.mn
Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар:	MV-021483
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, 17, “Блю ский тауэр” 607 тоот. Утас: 70110735
Төслийн байршил:	Дундговь аймгийн Гурвансайхан сумын Чулуут багийн нутагт Зүүн хэмээх газарт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос урагш 280 км, Дундговь аймгийн төвөөс зүүн тийш 75 км, Гурвансайхан сумын төвөөс хойш 35 км зайд, Дэлгэрцогт сумын төв буюу УБ-Дундговь чиглэлийн А0201 авто замаас зүүн урагш 60 км зайд оршино.

Зураг 2.1 Төслийн байршил


2. БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ХИМИЙН БОДИСЫН ХЭРЭГЛЭЭ

Эрдэнэс Алт Ресурс нь 2023 оны 01 сараас 10 сар хүртэлх байдлаар 7 нэр төрлийн химийн бодисыг ашигласан. Баяжуулах үйлдвэрт химийн бодисууд дараах зориулалтаар ашиглагдсан.

- Алт-мөнгөний флотацийн цуглуулагч
- Алт-мөнгөний флотацийн хөөсрүүлэгч
- Алт-мөнгөний флотацийн идэвхжүүлэгч
- Алт-мөнгөний флотацийн орчин тохируулагч
- Флотацийн хаягдлын бодисыг дарагч

Баяжуулах 1 болон 2-р үйлдвэрт ашигласан химийн бодисын мэдээллийг доорх хүснэгтүүдээс харна уу.

Хүснэгт 1. Баяжуулах 1-р үйлдвэрийн 2023.01-10 сард ашигласан нийт химийн бодисын зарцуулалт

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Томьёо	CAS дугаар	Ашигласан он, тоо хэмжээ						
					Зөвшөөрлийн дугаар, хүчинтэйд хугацаа	Зөвшөөрөл авсан тоо, хэмжээ	Импорт лож оруулсан, худалдсан тоо хэмжээ	Ашигласан тоо хэмжээ	Тайлан хамаарах хугацаа (он, сар)		Агуулахад үлдсэн хэмжээ
									Он, сар	Он, сар	
1	Натрийн карбонат	Sodium carbonate	Na ₂ CO ₃	497-19-8	-	-	-	16.7 тн	-	-	0.75 тн
2	Натрийн бутилийн ксантогенат	Sodium butyl xantate	C ₄ H ₉ OCS ₂ Na	141-33-3	-	-	-	61.075 тн	-	-	22.4 тн
3	Аммоний дибутилдитио- фосфат	Ammonium Dibutyl Dithiophosphate	(C ₄ H ₉ O) ₂ PSSNH ₄	53578-51-1	-	-	-	3.55 тн	-	-	6.76 тн
4	Зэсийн сульфат	Copper sulfate, pentahydrate	CuSO ₄ ·5 H ₂ O	7758-99-8	-	-	-	13.025 тн	-	-	2.225 тн
5	Кониферолын тос, нарсны тос	Pine oil	C ₁₀ H ₁₈ O	8002-09-3	-	-	-	2310 л	-	-	1410 л
6	Шохой	Calcium oxide; Lime	CaO	1305-78-8	-	-	-	56.865 тн	-	-	6.215 тн

Хүснэгт 2. Баяжуулах 1-р үйлдвэрийн 2023.01-10 сард ашигласан химийн бодисын зарцуулалт сар тус бүрээр

Сар	Натрийн бутилийн ксантогенат, кг	Аммоний дибутилдитио-фосфат, кг	Зэсийн сульфат, кг	Натрийн карбонат, кг	Шохой, кг	Кониферолын тос, нарсны тос, л
2023 он 01 сар	7450	400	1400	4400	6830	200
2023 он 02 сар	6260	350	1025	0	6725	160
2023 он 03 сар	6300	350	1400	1800	5080	205
2023 он 04 сар	6875	300	1200	4200	4660	245
2023 он 05 сар	6050	250	600	3900	5820	240
2023 он 06 сар	6105	350	800	600	6020	200
2023 он 07 сар	5335	400	1400	900	7540	340
2023 он 08 сар	5700	500	800	0	7840	380
2023 он 09 сар	4950	300	1200	900	2550	140
2023 он 10 сар	6050	350	3200	0	3800	200




График 1. Баяжуулах 1-р үйлдвэрийн ашигласан химийн бодисын хэмжээ сараар

Хүснэгт 3. Баяжуулах 2-р үйлдвэрийн 2023.01-10 сард ашигласан нийт химийн бодисын зарцуулалт

№	Монгол нэр	Олон улсын нэршил	Томьёо	CAS дугаар	Ашигласан он, тоо хэмжээ						
					Зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа	Зөвшөөрөл авсан тоо, хэмжээ	Импортлож оруулсан, худалдан тоо хэмжээ	Ашигласан тоо хэмжээ	Тайлан хамаарах хугацаа (он, сар)		Агуулахад үлдсэн хэмжээ
						Он, сар	Он, сар				
1	Флокулянт-полиакриламид	Flocculante-polyacrylamide	$(\text{CH}_2\text{CH}(\text{ONH})_n$	9003-05-8	-	-	-	0.9 тн	-	-	0.6 тн
2	Натрийн бутилийн ксантогенат	Sodium butyl xantate	$\text{C}_4\text{H}_9\text{OCS}_2\text{Na}$	141-33-3	-	-	-	90.82 тн	-	-	28.925 тн
3	Аммоний дибутилдитио-фосфат	Ammonium Dibutyl Dithiophosphate	$(\text{C}_4\text{H}_9\text{O})_2\text{PSSNH}_4$	53578-51-1	-	-	-	3.72 тн	-	-	7.6 тн
4	Зэсийн сульфат	Copper sulfate, pentahydrate	$\text{CuSO}_4 \cdot 5\text{H}_2\text{O}$	7758-99-8	-	-	-	9.9 тн	-	-	2.85 тн
5	Кониферолын тос, нарсны тос	Pine oil	$\text{C}_{10}\text{H}_{18}\text{O}$	8002-09-3	-	-	-	7645.31 л	-	-	1260 л
6	Шохой	Calcium oxide; Lime	CaO	1305-78-8	-	-	-	145.22 тн	-	-	13.1 тн

Хүснэгт 4. Баяжуулах 2-р үйлдвэрийн 2023.01-10 сард ашигласан химийн бодисын зарцуулалт сар тус бүрээр

Сар	Натрийн бутилийн ксантогенат, кг	Аммоний дибутилдитио-фосфат, кг	Зэсийн сульфат, кг	Шохой, кг	Флокулянт-полиакриламид, кг	Кониферолын тос, нарсны тос, л
2023 он 01 сар	5400	440	700	8750	0	422
2023 он 02 сар	9750	360	950	13375	0	888
2023 он 03 сар	10800	400	950	14605	150	980
2023 он 04 сар	9790	480	1200	14900	150	650
2023 он 05 сар	8550	280	1200	16625	50	460
2023 он 06 сар	7930	240	850	12765	100	898.24
2023 он 07 сар	9000	320	1000	15850	0	800
2023 он 08 сар	11000	440	950	17150	125	1092.33
2023 он 09 сар	9000	360	1000	14700	150	580.3
2023 он 10 сар	9600	400	1100	16500	175	874.44

Байрны нэр, дугаар бүртгэлийн хугацаа
2018 оны 02 сарын 02-ны өдөр А/21 дүгээр тухайлан Т дүгээр өгөгдөл

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАВИЛДЫН ТАГААЛХ БИРИГ
№ 001/2023
Датгалуулагч байгууллага
Хангайн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Увс сум, 21000

1. Үйлдвэрний үндэсний мэдээлэл:
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн бүртгэлийн дугаар: СО80.001.0000.0000.0000.0000.0000.0000.0000.0000
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн бүртгэлийн дугаар: СО80.001.0000.0000.0000.0000.0000.0000.0000.0000

2. Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн төрөл:
Сүлжир: Увс сум / Албан туслахын байр: Увс сум / Өдөр: 2023.08.04 / Гар: 08 / Сүлжир: 99993

3. Тээвэр/гэрээний төлбөр:
1) Тээврийн хэрэгсэлийн хэргийн дугаар: 0382.143 / Тээвэр/гэрээний бүртгэлийн дугаар: 0000-82

4. Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн мэдээлэл:

Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн төрөл	Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн бүртгэлийн дугаар	Хэмжээ	Нэгж	Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн төрөл
1. Салтан шүүх	И	147H	кг	150106
2.				
3.				

5. Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: 76090252

6. Тээвэр/гэрээний төлбөр:
1) Сүлжир: Увс сум / Албан туслахын байр: Увс сум / Өдөр: 2023.08.04 / Гар: 08 / Сүлжир: 99993

7. Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар:
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: ТҮМЭН ЭГИНИГ ХХК
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: 00001
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: Түмэн эгинг ХХК
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: 00001
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: Түмэн эгинг ХХК
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: 00001
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: Түмэн эгинг ХХК
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: 00001

Байрны нэр, дугаар бүртгэлийн хугацаа
2018 оны 02 сарын 02-ны өдөр А/21 дүгээр тухайлан Т дүгээр өгөгдөл

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАВИЛДЫН ТАГААЛХ БИРИГ
№ 001/2023
Датгалуулагч байгууллага
Хангайн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Увс сум, 21000

1. Үйлдвэрний үндэсний мэдээлэл:
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн бүртгэлийн дугаар: СО80.001.0000.0000.0000.0000.0000.0000.0000.0000
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн бүртгэлийн дугаар: СО80.001.0000.0000.0000.0000.0000.0000.0000.0000

2. Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн төрөл:
Сүлжир: Увс сум / Албан туслахын байр: Увс сум / Өдөр: 2023.08.04 / Гар: 08 / Сүлжир: 99993

3. Тээвэр/гэрээний төлбөр:
1) Тээврийн хэрэгсэлийн хэргийн дугаар: 0382.143 / Тээвэр/гэрээний бүртгэлийн дугаар: 0000-82

4. Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн мэдээлэл:

Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн төрөл	Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн бүртгэлийн дугаар	Хэмжээ	Нэгж	Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн төрөл
1. Увс сум, Увс сум, Увс сум	И	147H	кг	150106
2.				
3.				

5. Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: 76090252

6. Тээвэр/гэрээний төлбөр:
1) Сүлжир: Увс сум / Албан туслахын байр: Увс сум / Өдөр: 2023.08.04 / Гар: 08 / Сүлжир: 99993

7. Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар:
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: ТҮМЭН ЭГИНИГ ХХК
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: 00001
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: Түмэн эгинг ХХК
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: 00001
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: Түмэн эгинг ХХК
Аюултай хог хаягдал үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн үнэмлэхүй гэрээний дугаар: 00001

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХҮЛЭЭНЦЭСЭН АКТ

2023 оны 10-р сарын 04 өдөр №01 Салжит 2 төсөл

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт байрших Салхитын мөнгө-алтны ордод баяжуулах үйлдвэрлэлийн ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй "Соёлоон интернэли" ХХК-ийн үйл ажиллагааны явцад үүссэн аюултай хог хаягдалыг шийдвэрлэх ажлын хүрээнд байгуулсан 2023 оны 12 сарын 13-ны өдрийн Т-21, 1205 тоот гэрээний дагуу дараах хог хаягдлын мэргэжлийн эрх бүхий "Түмэн эгинг" ХХК-д холбогдох стандарт, шаардлага, хуулийн нөхцөлийг ханган хүлээлгэн өгсөнийг энэхүү актаар тогтоов. Хүлээлгэн өгсөн хог хаягдлын мэдээллийг 1-ээр хүснэгтээр оруулав.

Хүлээлгэн өгсөн хог хаягдлын мэдээлэл

1-р хүснэгт

№	Аюултай хог хаягдалын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хүлээлгэн өгсөн өдөр
1	Химийн бодисын шуудай	кг	1100	2023.02.15
2	Химийн бодисын шуудай	кг	1200	2023.08.04

ҮҮСЭГЧ ТАЛЫГ ТОЛООЛЖ:
"Соёлоон интернэли" ХХК-ийн
ХАБЭАБО-ны менежер
СӨӨДӨӨН
И
ЭЦолмонгэрэ

ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ ТОЛООЛЖ:
"Түмэн эгинг" ХХК-ийн Ерөнхий менежер
Б.Олбаср

4. ХИМИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Химийн шинжилгээний лабораторын үйл ажиллагааг Эрдэнэс силвер ресурс ХХК нь 2023 оны 5 дугаар сарын 21-ны өдөр хүртэл хариуцаж байсан бөгөөд тус өдрөөс хойш “Трү Ти Ар Си” ХХК-д хариуцан лабораторын үйл ажиллагааг явуулж байна.

1. Химийн бодис урвалжийн хэрэглээ, саармагжуулалт

2023 оны 01 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 21-ны хүртэлх нийт 5 сарын хугацааны химийн бодисын хэрэглээг Хүснэгт-5-д үзүүлэв.

Хүснэгт-5 Эрдэнэс силвер ресурс ХХК

№	Монгол нэр	Томьёо	CAS дугаар	Ашигласан тоо хэмжээ, кг				
				1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар
1	Давсны хүчил	HCl	7647-01-0	21.95	22.74	24.14	21.9	28.23
2	Азотын хүчил	HNO ₃	7697-37-2	9.41	10.00	10.19	9.26	11.94
3	Флакс	PbO: Na ₂ CO ₃ SiO ₂	74-86-2	341.89	435.47	443.33	410.2	492.38
4	Ацетилен	C ₂ H ₂		1	2	1	1	3
5	Хар тугалганы исэл	PbO	1317-36-8	-	-	-	-	-
6	Техникийн сод	Na ₂ CO ₃	497-19-8	-	-	-	-	-

2023 оны 05 дугаар сарын 21-нээс 2023 оны 10 дугаар сарын 25-ны хүртэлх нийт химийн бодисын хэрэглээг Хүснэгт-6-д үзүүлэв.

Хүснэгт-6 Трү Ти Ар Си ХХК

№	Монгол нэр	Томьёо	CAS дугаар	Ашигласан тоо хэмжээ, кг				
				6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар
1	Давсны хүчил	HCl	7647-01-0	3.5	6.75	8.8	8.02	11.04
2	Азотын хүчил	HNO ₃	7697-37-2	1.5	2.5	2.6	2.33	3.19
3	Флакс	PbO: Na ₂ CO ₃ SiO ₂	74-86-2	163.24	425.72	409.6	410	272.0
4	Ацетилен	C ₂ H ₂		2ш	5ш	4ш	4ш	4ш
5	Хар тугалганы исэл	PbO	1317-36-8	-	-	3	6.2	0.46
6*	Техникийн сод	Na ₂ CO ₃	497-19-8	4.6	11.48	11.59	10.82	12.17

Тайлбар: 6* - Химийн лабораторид ашигласан химийн бодисыг Техникийн содоор тогтмол саармагжуулж рН=6-7 ханган устгалд оруулдаг болно.

№	Бараа, материалын нэр	Үзүүлэлт	Хэмжих нэгж	1 дээжийн зарцуулалт	6-р сар		7-р сар		8-р сар		9-р сар		10-р сар	
					6 сар зарцуулалт	6 сар Үлдэгдэл	7 сар зарцуулалт	7 сар Үлдэгдэл	8 сар зарцуулалт	8 сар Үлдэгдэл	9 сар зарцуулалт	9 сар Үлдэгдэл	10 сар зарцуулалт	10 сар Үлдэгдэл
1	Дээжийн уут мөнгөлөг	Нөөц	шпрэг	2		340		774		54		386		19399
		Зарцуулалт			2150		2566		3720		2668		3337	
2	Шуудай	Нөөц	шпрэг			100		170		40		79		119
		Зарцуулалт			100		130		130		111		60	
3	Шамотон тигель	Нөөц	шпрэг	1		140		2539		2305		104		2653
		Зарцуулалт			1166		2566		2613		2786		1853	
4	Капель	Нөөц	шпрэг	1		644		6066		3140		498		4175
		Зарцуулалт			1166		2898		2926		3142		2323	
5	Флакс	Нөөц	килограмм	0.140		552.56		126.84		-282.76		7.24		85.23
		Зарцуулалт			163.24		425.72		409.6		410		272.01	
6	Тасалдаг уут	Нөөц	боодол	1		4		2		2		2		9
		Зарцуулалт			6		12		0		10		13	
7	Хар тугалганы исэл	Нөөц	килограмм	5грамм		0		0		22		15.8		15.34
		Зарцуулалт			0		0		3		6.2		0.46	
8	Давсны хүчил	Нөөц	литр	1.5/3 мл		21.5		14.75		30.95		22.93		36.89
		Зарцуулалт			3.5		6.75		8.8		8.02		11.04	
9	Азотын хүчил	Нөөц	литр	0.5/1мл		23.5		21		18.4		17.07		13.878
		Зарцуулалт			1.5		2.5		2.6		1.33		3.192	
10	Аи-ны стандарт уусмал	Нөөц	сав			8		8		8		7		7
		Зарцуулалт			0		0		0		1		0	
11	Техницийн сод	Нөөц	килограмм	3.96г		32.4		26.92		65.33		54.51		42.343
		Зарцуулалт			4.6		11.48		11.59		10.82		12.167	
12	Ацетилен	Нөөц	баллон	1/700шпр		3		7		3		8		13
		Зарцуулалт			2		5		4		4		4	

Байгууллага доторх бүртгэлийн зураг

2. Ашигласан хортой, аюултай бодисын үстгал

Мөнгө-Алтны шинжилгээнд ашиглан, шинжилгээний дараа хаягдал болон гардаг шамотон тигель, күпель, хайлуулалтын явцад гарсан шилэн хаягдлыг Улаанбаатар хот руу тээвэрлэж, хог хаягдал устгалын “Элемент” ХХК-ийн УБ хот, Налайх дүүргийн 3-р хорооны 77-р байрлал дахь хортой хог хаягдлын цэгт хүргүүлэн 61/22 тоот гэрээний дагуу устгалд оруулдаг. Устгалд оруулсан хэмжээг Хүснэгт-7-т үзүүлэв.

Хүснэгт-7

№	Сар	Хог хаягдлын хэмжээ, кг
1	1-6 дугаар сар	Устгал хийгдээгүй
2	7-р сар	2100
3	8-р сар	1574
4	9-р сар	3174
5	10-р сар	1200.56



Хаягдалын зураг

Хаягдал устгасан “Хог хаягдал устгалын акт”-ын 10 сарын баримтыг жишээ болгон Хавсралт-1-д харуулав. Мөн 9 сарын хог хаягдлыг “Аглаг Хангайн Уулс” буюу Баяжуулах үйлдвэр-1-ийн хаягдалтай хамт “Түмэн эгшиг” ХХК-аар устгуулсан бөгөөд тооцоо нийлсэн баримтаа хавсаргав.

Хавсралт-3

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАЛЫН АКТ
 Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, шатаах, устгах төвлөрсөн байгууламйн
 Хаяг: НД, 3-р хороо Бүс нур 12610 гудамж 77 тоот Утас: 7707-3790, 7717-3131

ЭЛЕМЕНТ LLC

1023 оны 10 сарын 23 өдөр Агтын дугаар: 23/177 Улаанбаатар хот

Аюултай хог хаягдал үүсгэгч: “Тру Ти Ар Си” ХХК

Устгалд оруулсан аюултай хог хаягдалын жагсаалт

№	Хаягдалын нэр, төрөл	Хэмжээ	Нэгж /кг, л	Аюулын ангилал
1	Бодисын хоосон сав (хуванцар)	8.56	кг	Хортой
2	Бодисын хоосон сав (шилэн)	72.0	кг	Хортой
3	Хар тугаланы агуулгатай шавотин тигель	1120.0	кг	Хортой
Нийт		1200.56	кг	-

Ханасан
 Ерөнхий менежер *[Signature]* Б.Ундармаа

Устгал хийсэн
 Химич *[Signature]* Э.Халнуя

Акт хүлээн авсан
[Signature] *[Signature]*

Устгасан аргачлал:
 Дээрх 1200.56 кг химийн хортой хаягдал хог хаягдлыг “Элемент ХХК-ийн аюултай хог хаягдал хүлээн авах, устгах” комисс хүлээн авч саармагжуулан зориулалтын шатаах зууханд 1150°C-т бүрэн шатааж хаягдал үнсийг ландшафтанд устгав.

Жиг: Устгалд орсон бодисын нэр төрөл, жагсаалт, устгалын зураг хавсаргав.

тусгайгаар шинжилгээний ажлыг хоёр байгууллагад хөтөлгөж буй бүртгэлийн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэлийн бичигтээр нэг бүрчлэн нийлж үзсэн Хавсралт-1-ын дагуух сорилт, шинжилгээ нийтлэлийн харилцан батлав.

Тооцооны баримтын жагсаалт /Сорилтын үзүүлэлтийн тоогоор/

Нэхэмжлэгч /"Трү Ти Ар Си" ХХК/				Төлөгч /"Аглаг Хангайн Уулс" ХХК/			
№	Баримтын			№	Баримтын		
	Огноо	Тодорхойлсон үзүүлэлт	Тоо, ширхэг		Тоо, ширхэг	Нэгж үнэ	Дүн ₮
1	2023/10/01	Нунтаглалт	12	1	12	12000	144,000
2	2023/10/01	Мөнгөний агуулга тодорхойлох	56	2	56	20000	1,120,000
Нийт дээжийн тоо			56	Дэд дүн			1,264,000
Нийт сорилтын үзүүлэлтийн тоо			68	НӨАТ (%)			126,400
				Төлөх нийт дүн:			1,390,400

Тооцоо нийлсэн

"Трү Ти Ар Си" ХХК
Нэхэмжлэгч
Чанарын менежер З. АРИУНГОО

"Аглаг Хангайн Уулс" ХХК
Төлөгч
Технологич инженер Б. НЯМХҮҮ

Нярав П. ЛХАГВАДАРЖАА

БАТАЛСАН:
"Аглаг Хангайн Уулс" ХХК
Ахлах технологич инженер Б. ГАНЗАМ

Хартай хол хөдөлгөөн гэрээг хийсэн
Тохиромж
2023/10/09

5. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ УСТГАХ ГЭРЭЭНҮҮД

Эрдэнэс алт ресурс ХХК нь 2023 онд Түмэн эгшиг ХХК-тай, шинжилгээний лабораторын үйл ажиллагааг хариуцан ажиллаж байгаа Трү ти ар си ХХК нь Элемент ХХК-тай, Баяжуулах 1 дүгээр үйлдвэрийг хариуцан ажиллаж байгаа Аглаг хангайн уулс ХХК нь Түмэн эгшиг ХХК-тай, Баяжуулах 2 дүгээр үйлдвэрийг хариуцан ажиллаж байгаа Соёолон интернэшнл ХХК нь Түмэн эгшиг ХХК, Ариун хими ХХК-тай аюултай хог хаягдал устгах гэрээг байгуулан хууль, стандартын дагуу устгах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

БАТЛАВ.

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ТӨГСБУЯН

“ТҮМЭН ЭГШИГ” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ



Г.ЧИНЗОРИГ

ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ

№23-НГ/ЭСР/АГГ/26

2023 оны 8 сарын 16-ний өдөр

Улаанбаатар хот

1. Энэхүү гэрээг “Эрдэнэс силвер ресурс” ХХК (РД:6436226), “Түмэн эгшиг” ХХК (РД:5031923), нарын хооронд байгуулсан 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн ЭСР/АГГ/26 дугаартай “Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ” /цаашид “Үндсэн гэрээ” гэх/-ний ерөнхий нөхцөлийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дэх заалтыг тус тус үндэслэн дараах нэмэлтийг оруулахаар харилцан тохиролцож байгуулав.

2. Гүйцэтгэгч нь “Аюултай хог хаягдал шилжүүлэх” гэрээний хугацааг 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал гүйцэтгэхээр гэрээний хугацааг сунгав.

3. Үндсэн гэрээний бусад зүйл, заалтууд хэвээр дагаж мөрдөгдөх ба энэхүү гэрээ нь үндсэн гэрээний салшгүй хэсэг байна.

4. Энэхүү гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурж тэмдэг (тамга) даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.

5. Гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУДЫН МЭДЭЭЛЭЛ, БАТАЛГААЖУУЛАЛТ:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Бизнес менежментийн газрын захирал

Э.Ууганбаяр

Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга

Д.Батжаргал

Байгаль орчны мэргэжилтэн

Г.Анх-Амгалан

Хаяг: 14240 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 17, Блю ский тауэр 607 тоот
Утас: 7535-1111

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ерөнхий менежер

Б.Одбаяр

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Намъянжугийн-44, Түмэн эгшиг ХХК-ийн өөрийн байр
Утас: 976 92050001, 88990428
Суурин утас: 77110428
И-мэйл: chemicalwasterisk@gmail.com
Шуудангийн хаяг: 51 салбар 499 тоо

Хянаг
Огноо: 2023-08-16
Дугаар: 23-НГ/ЭСР/АГГ/26
Гарын үсэг: [Signature]

БАТЛАВ.
"ТҮМЭН ЭГШИГ" ХХК
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
..... Г.ЧИНЗОРИГ /

БАТЛАВ.
"ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС" ХХК
ЗАХИРАЛ
..... С.БАЯРМӨНХ /

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 08 сарын 15-ний өдөр

№ 9СР/АГГ-26

Улаанбаатар хот

Нэг талаас Түмэн эгшиг ХХК /цаашид "Хүлээн авагч" гэх/ төлөөлж Үйлдвэр хариуцсан дарга албан тушаалтай Б.Одбаяр, Нөгөө талаас "Эрдэнэс Силвер Ресурс" ХХК-г /цаашид "Үүсгэгч" гэх/ төлөөлж албан тушаалтай Гүйцэтгэх захирал албан тушаалтай С.Баярмөнх бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

- 1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
- 1.2. Энэ гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

ХОЁР. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэглэгээтэй байна.
- 2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
- 2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
- 2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ **БОАЖЯ Сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг** бүрдүүлж өгнө.
- 2.5. Аюултай хог хаягдлын савыг суллаж онц хорттой, тэсрэмтгий, шатамхай бодис /түхэйлбал цанид натри гэх мэт/ -г түхэйн бодисын шинж чанарт тохирсон

үүсмалаар цэвэрлэсэн байна. Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

- 2.6. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлж хүлээн авагчид шилжүүлнэ.

ГУРАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ

- 3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2022 оны 08 сарын 15 өдрөөс 2023 оны 08 сарын 15 өдрийг хүртэл 1 /нэг/ жилийн хугацаатай байна.
- 3.2. Эхний нийлүүлэлт нь гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор үүсгэгч нь хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.3. Энэхүү гэрээний 1-р хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдлын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.4. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсвэл chemicalwasterisk@gmail.com хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч тал үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хүлээн авагчийн байранд аюултай хог хаягдал хүргэх хугацааг товлон.
- 3.5. Хүлээн авагч нь үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
- 3.6. Үүсгэгчийн шилжүүлэх аюултай хог хаягдлын хэмжээ, тоо ширхгийг гэрээний хавсралт №1-д заасан төлбөр тооцооны тарифын дагуу харгалзуулан тооцож тухайн үед шилжүүлэх аюултай хог хаягдлын төлбөрийн хэмжээ гарна.
- 3.7. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед үүсгэгчээс ирүүлсэн дагалдах бичигт дурдсан мэдээлэл зөрснөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлнө.
- 3.8. Үүсгэгч нь гэрээний төлбөрийг аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэх тухай захиалга өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор “Түмэн эгшиг” ХХК ийн Худалдаа хөгжлийн банк 499085408 тоот дансанд төлбөрийн нэхэмжлэхийн дагуу 100 хувь төлнө.
- 3.9. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу зохих төлбөрийг төлнө.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:
Монгол Улсын “Усны тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны Газар”-ын гаргасан 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 70 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны даргын олгосон 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/17 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны усны чанар экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н. Солонго, Ус ашиглагчийг төлөөлж: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 17, “Блю Скай” Тауэр, 607 тоот, 9011474118 улсын бүртгэлийн дугаартай, 6436226 регистрийн дугаартай “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн Г. Анх-Амгалан нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: MV-021483 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, Салхитын мөнгөний ордыг ил аргаар олборлон, флотацийн аргаар баяжуулна.

2023 онд 3*471.6 мян.м³ хөрс хуулж, 600.0 мян.тн хүдэр олборлон (үүний 252.0 мян.тн-ыг баяжуулах 1-р үйлдвэрт, 348.0 мян.тн-ыг баяжуулах 2-р үйлдвэрт) баяжуулж, 127*768 кг мөнгө, 147.3 кг алт гарган авна.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 356*089.5 м³/жил

2.2.1. Унд ахуйд: 25*393.5 м³/жил

2.2.2 Баяжуулах үйлдвэрт: 302*943 м³/жил

2.2.3. Шавхан зайлуулалт /дүйцүүлэн хамгаалах ажилд/: 27*753 м³/жил

2.3. Усны чанар, найрлага: Ажилчдын унд, ахуйд хэрэглэх болон технологид ашиглах усыг Гашууны газрын доорх ордод гаргасан 14 ш худгаас хангана. Уурхайн зам, талбайн усалгаанд шүүрлийн ус ашиглана. “Уурхайд орох усны хэмжээг 2012 онд явуулсан судалгааны дүнгээр 84.1м³/хон буюу 3.5м³/цаг гэж тооцсон байдаг. 2020 онд явуулсан судалгаагаар дээр тооцсон уурхайд орж ирэх газрын доорх усны хэмжээ 352.8м³/хон гэж тооцсон ба мөн онд ордын гидрогеологийн нөхцөл болон уурхайд орж ирэх шүүрлийн усны тодотгол тооцоогоор уурхайд

орж ирэх усны хэмжээ $44.48\text{м}^3/\text{хон}$ буюу $1.85\text{м}^3/\text{цаг}$ гэж тооцсон байна. Энэ тооцоо нь ил уурхайн өнөөгийн ашиглалтын хугацаанд уурхайн мөргөцөгт орж ирж буй усны бодит хэмжээтэй тохирохгүй шүүрлийн усны хэмжээ нь 2022 оны судалгаагаар маш бага байна гэж ажиглагдсан. /Гидрогеологич, доктор Н.Лхагвын тооцооллоор $84.1\text{м}^3/\text{хоног} = 80.999\text{м}^3/\text{хон}$ ерөнхийдөө дүйцэж байна/ гэж дүгнэсэн.

2.4. Усны эх үүсвэр: Ажилчдын унд, ахуйд хэрэглэх болон технологид ашиглах усыг Гашууны газрын доорх ордод гаргасан 14ш худгаас хангана. Ногоон байгууламж, зам талбайн усалгаанд шаардагдах усыг уурхайд орж ирэх шүүрлийн усаар хангана. Унд ахуйд хоногт 59.1 м^3 ус хэрэглэнэ.

2.4.1. Байршил: Дундговь аймгийн Гурвансайхан сумын төвөөс хойш 35 км зайд байрлана.

2.4.2. Солбицол:

№	Уртраг	Өргөрөг	Ундарга л/сек	Насосны марк	Тоолуурын	
					Марк	Дугаар
1	106 59 48.00	45 52 29.01	3.0	PROG 7.5 KW	LXLC	202001085
2	107 00 21.0	45 52 19.3	2.2	PROG 7.5 KW	LXLC	202002633
3	107 00 47.2	45 52 29.0	2.2	PROG 7.5 KW	LXLC	202002642
4	107 00 34.4	45 52 17.2	2.2	S150QJ20-149/16-13	LXLC	202002632
5	107 02 25.0	45 86 94.2	2.2	QJ-2.2-100/6T-20	LXSG-40	20222630
6	107 06 08.89	45 86 98.1	3.2	QJ-2.2-100/6T-20	LXSG-40	202001520
7	107 01 77.0	48 86 77.0	2.2	13QJ8-121/14-5.5	LXSG	2107019931
8	107 02 08.7	45 86 82.4	Хуурай	QJ-2.2-100/6T-20	LXSG	202002129
9	107 01 03.33	45 52 35.52	6.0	MS-125-11	LXLC	202002525
10	107 01 17.9	45 52 42.0	4.0	QJ-7.5-125/8T-28	LXLC	202002505
11	107 01 36.08	45 52 30.28	3.5	QJ-7.5-125/8T-28	LXLC	2107019946
12	107 01 21.15	45 52 19.13	3.0	QJ-7.5-125/8T-28	LXLC	2107019913

2.4.3. Барилга байгууламж: Эргэлтийн усан хүртэл 940 м урттай, 100 мм голчтой, ган хоолой, 2544 м урттай 150 мм голчтой ган хоолой нийт 3484 м урт ган хоолойтой. Тус бүр 1000м^3 эзэлхүүнтэй усан сантай. Худгуудаас авч буй цэвэр усны шугамуудад тус бүрт тоолуур суурилуулсан.

2.4.4. Тоног төхөөрөмжийн нэр, марк: LXLC маркийн тоолууртай.

2.5. Хаягдал ус: Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг $30\text{м}^3/\text{хон}$ цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжид хүлээн авч, механик болон биологийн аргаар цэвэрлэн $19,2\text{м}^2$ талбайд нийлүүлдэг.

Хаях цэгийн байршил: Ариутгах татуурга

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

- Жинлэгдэх бодис, кг:.....
- Органик бодис, кг:.....
- Эрдэс бодис, кг:.....
- Хүнд металл, кг:.....
- Аюултай бохирдуулах бодис, гр:.....

2.7. Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

Ахуйн хаягдал бохир усыг Герман WSB технологийн хоногт 30 м³ хүчин чадалтай, бетонон хийцтэй цэвэрлэх байгууламжтай. Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг механик болон биологийн аргаар цэвэрлэн био цөөрөмд нийлүүлнэ. Бохир усыг 97 хувь хүртэл цэвэршүүлдэг.

2022 онд шинээр 458 мян.м³ эзлэхүүнтэй, HDPE геомембран доторлогоотой хаягдлын сан байгуулсан.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.9. Усны тоолуур: LXLC, LXSG маркийн нийт 12 ширхэг тоолууртай.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтын дагуу ажилчдын унд ахуйн хэрэгцээнд хэрэглэх 25'393.5м³/жил усыг төлбөрөөс чөлөөлнө.

Ашигт малтмал баяжуулахад газрын доорх ус ашиглах усны төлбөр:

$$1\text{м}^3 \text{ газрын доорх усны үнэ } 3.700\text{төг/м}^3 \times 35\% \times 1.8 = 2'331\text{төг/м}^3$$

- 3'700төг/м³ Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:
- (35%)- Засгийн газрын 326-р тогтоолын 7(а)-д заасан ашигт малтмал олборлох, баяжуулахад газрын доорх ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээ./Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 416 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон/
- 1.8- Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт ашигт малтмал олборлох, баяжуулахад газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$302'943 \text{ м}^3 \times 2331 \text{ төг/м}^3 = 706'160'130.0 \text{ төгрөг}$$

Шавхан зайлуулахад газрын доорх усны төлбөр:

$$1\text{м}^3 \text{ газрын доорх усны үнэ } 3'700\text{төг/м}^3 \times 0.15 \times 1.6 = 888.0 \text{ төг/м}^3$$

- 3'700төг/м³- Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ:
- (15%)- Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 7(в)-д заасан газрын доорх усыг шавхан зайлуулсныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ
- 1.6- Баяжуулах үйлдвэрт газрын доорх ус шавхан зайлуулсныг тооцох итгэлцүүр

$$27'753 \text{ м}^3/\text{жил} \times 888.0 \text{ төг/м}^3 = 24'644'664 \text{ төгрөг}$$

Нийт төлбөр = 706'160'133.0 төг + 24'644'664 төгр = 730'804'797 төгрөг

/Долоон зуун гучин сая найман зуун дөрвөн мянга долоон зуун ерэн долоон төгрөг /

Баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах 302'943м³/жил ус, шавхан зайлуулах 27'753 м³/жил газрын доорх усны төлбөр 730'804'797 төгрөг /Долоон зуун гучин сая найман зуун дөрвөн мянга долоон зуун ерэн долоон төгрөг /- ийг Дундговь аймгийн Төрийн сан банкны 100080000944/ тоот дансанд төвлөрүүлнэ.

Усны нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлсөн мэдээ тайланг хагас, бүтэн жилээр гаргаж ирүүлнэ.

Гурав. Талуудын эрх үүрэг

3.1. Ус ашиглуулагч нь “Усны тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.9, 17.1.10 дахь заалтын дагуу эрх эдэлнэ.

3.2. Ус ашиглагч нь дараах үүрэгтэй:

3.2.1. Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын дагуу ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх;

3.2.2. Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтын дагуу ус авах нэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах.

3.2.3. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон мэдээг Сав газрын захиргаанд гаргаж өгнө.

3.2.4. Ажилчдын ундны усыг “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS0900:2018 стандартын шаардлагад нийцсэн усаар хангаж, улиралд 1 удаа байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг Сав газрын захиргаанд ирүүлэх;

3.2.4. Ус ашиглалтын байдалтай холбоотой асуудлыг тухай бүрт нь мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд Сав газрын захиргааны холбогдох мэргэжилтнийг дуудаж газар дээр нь шийдвэрлэж байх.

3.2.5. Үйл ажиллагаа зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед Сав газрын захиргаа болон холбогдох төрийн байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж ирүүлэх.

3.2.6. Тухайн сумын Сав газрын захиргаа болон байгаль орчны хяналтын улсын байцаагчдыг тус тус байлцуулан тоолуурын заалтыг сар бүрийн эхний болон эцсийн заалтыг акт, зургаар баталгаажуулалт хийж 1 хувийг Сав газрын захиргаанд ирүүлэх.

3.2.7. Улирал бүр 2-оос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариу дүнг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газар болон Сав газрын захиргаанд ирүүлэх;

3.2.8. Хаягдал бохир усыг стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, цэвэрлэсэн усаа ногоон байгууламжийн усалгаанд ашиглах;

3.2.19. Гэрээнд заасан хэмжээнээс илүү ус ашигласан тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцно.

3.2.10. Усыг гэрээнд зааснаас бусад зориулалтаар, буюу хэмжээнээс хэтрүүлэн ашигласнаа нуун дарагдуулсан, зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, усны төлбөр төлөхөөс зайлсхийсэн болон төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд “Зөрчлийн тухай” хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Ус ашиглуулагч нь 2023 оны 12 дугаар сарын 30-ны дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд, нэмэлт өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг “Усны тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтууд болон дор дурьдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцална.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.

4.5.2. Аль нэг тал нь татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны усны чанар экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

...../Н. Солонго/

Хаяг: Монгол улс, Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 2-р баг, Ногоон хөгжлийн төв, 2 давхарт, 205 тоот

Харилцах утас: 7054-3598, 7054-3599

Ус ашиглагчийг төлөөлж:

“Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн

...../Г. Анх-Амгалан/

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 17, Блю Скай тауэр, 607 тоот

Харилцах утас: 7535-1111, 8900-8524

УС АШИГЛАХ ГЭРЭЭ ДҮГНЭХ АКТ

Ус ашиглах гэрээний дугаар, гэрээ байгуулсан он сар өдөр	Дугаар -17 2022.06.09
Төслийн нэр	Салхитын мөнгөний ордыг ил аргаар олборлон, флотацын аргаар баяжуулна.
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК
Регистрийн дугаар	6436226
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-021483
Төслийн байршил	Дундговь аймаг Гурвансайхан сум
Гэрээ дүгнэсэн он сар өдөр	2023.03.31

ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Гэрээний гол нөхцөл	Гүйцэтгэл
1	1. Усны эх үүсвэр - Унд, ахуйн (Гүний худаг, зөөврөөр) - Технологи (Шүүрлийн ус, гадаргын ус, газрын доорх ус) - Зам тал байна тоосжилт - Ногоон байгууламжийн усалгаа	Ажилчдын унд, ахуйд хэрэглэх болон технологид ашиглах усыг Гашууны газрын доорх гаргасан 12 ш худгаас хангана. Уурхайн зам, талбайн усалгаанд гшшрлийн ус ашиглана. Унд ахуйд хоногт 16.1 м ³ ус ашиглана.
2	2. Ашиглах усны хэмжээ (м ³) 2.1.1. унд ахуй 2.1.2. ашигт малтмал олборлон баяжуулахад ашиглах ус 2.1.3. зам талбайн тоосжилт 2.1.4. ногоон байгууламжийн усалгаа Нийт	Нийт ашиглах усны хэмжээ: 282'467.0 м ³ /жил 2.1.1. Унд, ахуй- 19'503.0 м ³ 2.1.2. Технологийн хэрэгцээнд- 166'043.0 м ³ 2.1.3. Шавхан зайлуулат – 116'424.0 м ³
3	3.1. Усны чанар найрлага	2022 оны 05 сард ундны уснаас 1 удаа, бохир уснаас 1 удаа Ханлаб лаборатори, Цаг уур орчны шинжилгээний газар хийлгэсэн. Монгол-Ус ТӨҮГ-ын итгэмжлэгдсэн лаборторид цэвэр усны микробиологийн шинжилгээг 7 сард тус тус хийлгэсэн. Ундны усны шинжилгээний дүнгээр MNS0900:2018 стандартын шаардлагыг хангаж байна.
4	4.1. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлэх арга, хөрөнгийн хэмжээг төлөвлөж ирүүлэх.	Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлэх арга, хөрөнгийн хэмжээний хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөн 8'744'000 төгрөг зарцуулсан.
5	5.1. Усны тоолуур	LXLC-100 маркийн тоолуур 4 ш, LXLC-150 маркийн тоолуур 1ш, LXLC-80 маркийн тоолуур 1ш, LXLC-65 маркийн тоолуур 1ш, LXLC-50 маркийн тоолуур 5ш, LXLC- 32 маркийн тоолуур 1ш нийт 13 ширхэг тоолуур суурилагдсан.
6	6.1. Усны нөөц ашигласны төлбөрийн	Гүйцэтгэлийг тайланд тусгаснаар ус ашигласны төлбөрт

	хэмжээ (мян.төг) 6.1.1.унд ахуй 6.1.2.ашигт малтмал олборлон баяжуулахад 6.1.3.зам талбайн тоосжилт дарахад Нийт	2022 онд нийт 380'716'240 төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнд: 2.1.1. Унд ахуй – 3'350м ³ 2.1.2.Технологийн хэрэгцээнд- 282'820 м ³ 2.1.3. Шавхан зайлуулалт- 116'424м ³ Нийт - 402'594 м ³ /жил
7	7.1.Тухайн жилийн ус ашиглалтын тайланг хүлээн авах.	2022 оны ус ашиглалтын тайланг 2023.03.21-ний өдөр ирүүлсэн.

Дүгнэлт:

2022 онд нийт 282'467.0м³/жил үүнээс технологийн хэрэгцээнд- 166'043.0м³, шавхан зайлуулалт – 116'424.0 м³ ус ашиглахаар төлөвлөн гэрээ байгуулсан.

Ус ашиглалтын тайланд тоолуурын заалтаар технологийн хэрэгцээнд- 282'820 м³, гүйцэтгэлээр шавхан зайлуулалт- 116'424м³ нийт 402'594 м³/жил ус ашигласан байна.

Үүнээс баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэгцээнд

$282'820 \text{ м}^3 - 166'043.0 \text{ м}^3 = 116'777 \text{ м}^3/\text{жил}$ усыг хэтрүүлэн ашигласан бөгөөд төлбөрийг тооцов.

$116'777 \text{ м}^3/\text{жил} \times 1332 = 155'546'964$ төгрөг

Үүнээс: Ус ашигласны төлбөр 324' 553' 788.0 төгрөг төлөхөөс **380'716'240** төгрөг төлсөн. Илүү төлсөн төлбөр 56'162'452 төгрөг байна.

Төлөх төлбөр **155'546'964** төгрөг - **56'162'452** = **99'384'512** төгрөгийн төлбөрийг нэмж төлөх шаардлагатай.

- Баяжуулах үйлдвэрт хэтрүүлэн ашигласан усны төлбөр болох **99'384'512** төгрөг / ерэн есөн сая гурван зуун наян дөрвөн мянга таван зуун арван хоёр төгрөг/-ийг 2 дугаар улиралд багтаан Дундговь аймгийн төсөвт төвлөрүүлэх шаардлагатай
- Цаашид ус ашиглах гэрээнд илүү ашигласан усны төлбөрийг Засгийн газрын 2018 оны 12 сарын 26-ны өдрийн 391 дугаар тогтоол “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр гооцох журам”-ын дагуу тооцон ажиллахыг анхаарах.
- Усны шинжилгээг байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторт сорьцыг өгч шинжлүүлэх, унд ахуйн усыг улиралд нэг удаа, бохир усны сорьцыг улиралд 2-оос доошгүй удаа өгсөн байх шаардлагыг хангаж ажиллах.
- Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлэх арга, хөрөнгийн хэмжээг төлөвлөж ирүүлээгүй цаашид тайланд тусгаж ирүүлэх шаардлагатай.
- Тоолуурын сар бүрийн бичилтийг Сав газрын төлөөллийг байлцуулан баталгаажуулж, хувийг холбогдох газруудад хүргүүлж байх.
- 2023 оны ус ашиглалт, төлөвлөлтийг зөв тооцоолох шаардлагатай.

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

УС АШИГЛУУЛАГЧ:

УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН ДУНДАД
ТАЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
Б.ОТГОНСҮРЭН

ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ, АШИГЛАЛТЫН
АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
Б.САРАНТУЯА

ХАЯГ: СҮМБЭР МОНГОЛ УЛС, ГОВЬСҮМБЭР
АЙМАГ, СУМ, 3-Р БАГ, 3-Р БАГ, 3-Р БАЙР, 5-Р
ОРЦ, 66 ТООТ
ХАРИЛЦАХ УТАС: 7054-3598, 7054-359

УС АШИГЛАГЧ:

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-НЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.БАЯРМӨНХ

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН
Г.АНХ-АМГАЛАН

ХАЯГ: УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР
ДҮҮРЭГ, 1-Р ХОРОО, ЭНХТАЙВНЫ ӨРГӨН
ЧӨЛӨӨ 17, БЛЮСКАЙ ТАУЭР, 607ТООТ
ХАРИЛЦАХ УТАС: 7535-1111, 8900-8524

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2023 оны 04 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар *40*.....

Улаанбаатар
хот

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

Төрийн өмчийн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани болох 100% төрийн өмчит “Эрдэнэс силвер ресурс” ХХК, гүйцэтгэх захирал С.Баярмөнх, утас: 9911-3684, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 17, “Блю Скай” Тауэр, 607 тоот, холбогдох утас: 7535-1111, 8900-8524, 8900-8524, Вэбсайт: www.erdenessilver.mn, И-мэйл: info@erdenessilver.mn, хувийн хэргийн дугаар: 9011474118, регистрийн дугаар: 6436226.

2. Төслийн нэр, байршил:

“Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн эзэмшлийн Салхитын мөнгө-алтны орд нь Улаанбаатар хотоос урагш 280 км, Дундговь аймгийн төв Мандалговь хотоос зүүн хойш 60 км, Гурвансайхан сумын төвөөс хойш 35 км зайд байрлана. Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хамаарагдана.

3. Төсөл хэрэгжүүлэгч: “Эрдэнэс силвер ресурс” ХХК. Тус компанийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014.04.19-ний өдрийн 133-р тогтоол, 100% төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 15-р тогтоолоор тус компанийн охин компани болгон 2019 оны 05-р сард байгуулсан.

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X, Y/:

АМГТГ-аас Дундговь аймгийн Гурвансайхан сумын “Салхит” нэртэй газарт орших 2,887.85 га талбайд ашигт малтмал ашиглалтын MV-021483 дугаартай тусгай зөвшөөрлийг 2019.10.17-ны өдөр “Эрдэнэс силвер ресурс” ХХК-д анх олгосон.

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021483, ашиглалтын талбай: 2,887.85 га (Солбилцлын 14 цэг)

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	107°00'01.48"	45°51'57.68"	6	107°00'01.48"	45°48'43.64"	11	106°59'29.92"	45°49'24.51"
2	107°00'01.48"	45°51'54.00"	7	106°57'22.8"	45°47'53.22"	12	106°59'29.92"	45°50'47.52"
3	107°01'26.00"	45°51'54.00"	8	106°57'21.24"	45°47'47.95"	13	106°55'49.09"	45°50'47.56"
4	107°01'26.00"	45°51'0.00"	9	106°56'0.03"	45°47'48.01"	14	106°55'49.09"	45°51'57.68"
5	107°00'01.48"	45°51'0.00"	10	106°56'0.04"	45°49'24.45"			

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:


Салхитын мөнгө-алтны ордыг ил аргаар олборлон, флотацийн аргаар баяжуулна.

6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:

Уурхайд ажиллуулах машин техник:

<ul style="list-style-type: none"> • HYUNDAI 520LC-95 маркийн экскаватор 1 ш • CATERPILLAR 385 маркийн экскаватор 1 ш • HYUNDAI 1200 маркийн экскаватор 1 ш • LIUGONG SDLG-956L маркийн утгуурт ачигч 1 ш • SHANTUI SD23 маркийн бульдозер 1 ш • CATERPILLAR D9R маркийн бульдозер 1 ш • SHANTUI Sunward SWD 165 маркийн өрмийн машин 1 ш 	<ul style="list-style-type: none"> • XCMG D700 маркийн өрмийн машин 1 ш • XCMG MT86H маркийн автосамосвал 1 ш • Dong Feng маркийн 10 тн-ын багтаамжтай зам, талбайн тоосжилт дарахад ашигладаг усны машин 1 ш • ЦИСК-13-175 маркийн шүүрлийн усыг шавхахад ашигладаг динамик насос 1 ш
--	--

Эдгээр техникүүд бүгд түрээсийнх



Баяжуулах хоёр үйлдвэрт SEMI 655 маркийн утгуурт ачигч 2 ш, HOWO TRUCK маркийн авто ачигч 3 ш, Hyundai Bongo маркийн үйлчилгээний машин 1 ш, Land cruiser 200 маркийн суудлын авто машин 1 ш-ийг ажиллуулдаг.

Баяжуулах 1-р үйлдвэрт ашиглаж буй техник, тоног төхөөрөмж:

<ul style="list-style-type: none"> • PE600*800 маркийн хацарт бутлуур 1 ш • PYJ300 маркийн алхат бутлуур 1 ш • 2YSZ1848 маркийн чичиргээт шигшүүр 1 ш • ZTMG3645 маркийн бөөрөнцөгт тээрэм 1 ш • ZTMG2145 маркийн бөөрөнцөгт тээрэм 1 ш • SF-4 маркийн механик флотаци 16 ш • SF2.8 маркийн механик флотаци 4 ш • 2PNL маркийн динамик насос 3 ш • 4PNL маркийн динамик насос 3 ш • 100PNJ FA маркийн динамик /зутангийн/ насос 3 ш 	<ul style="list-style-type: none"> • 50PNJ FA маркийн динамик /зутангийн/ насос 4 ш • HG24 маркийн захдаа хөтлүүртэй өтгөрүүлэгч 1 ш • XMZ600 маркийн дотоод шүүх гадаргуутай хүрдэн вакуум шүүлтүүр 2 ш • CV-11 маркийн туузан конвейер 7 ш • XMZ350 маркийн дотоод шүүх гадаргуутай хүрдэн вакуум шүүлтүүр 1 ш • HG-6 маркийн төвдөө хөтлүүртэй өтгөрүүлэгч 1 ш • ZPG80-10 маркийн гадаад шүүх гадаргуутай хүрдэн вакуум шүүлтүүр 1 ш • Чичиргээт (vibration feeder) тэжээх төхөөрөмж 2 ш
---	---

Баяжуулах 2-р үйлдвэрт ашиглаж буй техник, тоног төхөөрөмж:

<ul style="list-style-type: none"> • ZSW-360x95 маркийн чичиргээт тэжээх төхөөрөмж 1 ш • B650 маркийн туузан конвейер 4 ш • B651 маркийн туузан конвейер 2 ш • DK-1500 маркийн чичиргээт тэжээх төхөөрөмж 2 ш • Ф2700*6000 маркийн бөөрөнцөгт тээрэм 2 ш • FX350x3 маркийн гидроциклон гравитаци 4 ш • 100ZGB маркийн динамик насос 4 ш • GBJ3000 маркийн зуурагч 2 ш • SF-8 маркийн механик флотаци 16 ш • SF2.8 маркийн механик флотаци 14 ш 	<ul style="list-style-type: none"> • 100ZJ-I-B42 маркийн динамик насос 2 ш • NXZ-18 маркийн төвдөө хөтлүүртэй өтгөрүүлэгч 1 ш • 200ZJ-I-A60 маркийн динамик насос 2 ш • ZPG2100-4 маркийн гадаад шүүх гадаргуутай хүрдэн вакуум шүүлтүүр 2 ш • FX250-4 маркийн гидроциклон гравитаци 2 ш • ZKJ2445 маркийн чичиргээт шигшүүр 2 ш • Ф2500-2500 маркийн зуурагч 1 ш • Ф1500-1500 маркийн зуурагч 4 ш • TPW200-400 маркийн динамик насос 2 ш • 65ZRL-S23 маркийн динамик насос 6 ш
--	---

Уурхайн хөрс хуулалт болон олборлолт нь өрөмдлөг тэсэлгээ → ухаж ачих → тээвэрлэх → овоолох гэсэн процессоор явагддаг. Уурхайн ухлага одоогоор 66 м-т байгаа.

Баяжуулах үйлдвэрийн технологи нь уурхайгаас ирэх -300 мм ширхэглэлтэй хүдрийг 2 шатны бутлалт, 1 шатны нунтаглалтаар - 0.076 мм (60%) болгож, үндсэн болон цэвэрлэгээ, хяналтын флотациар баяжуулж мөнгө-алтны баяжмал гарган авах бөгөөд хаягдлыг фильтр прессийн тусламжтай шүүн шахаж хатуу байдалтайгаар хаягдал хадгалах байгууламжид хураадаг.

Уурхайн олборлолт болон баяжуулах үйлдвэрт 2023 онд нийт 513 хүн (үндсэн компанийн 137, туслан гүйцэтгэгчийн 376 хүн) хоногт 2 ээлжээр 20 цаг, жилд 330 хоног ажиллуулна.

Баяжуулах 2 үйлдвэрийн чадал нийлбэр хүчин 600.0 мян.тн/жил.

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:



2023 онд 3,471.6 мян.м³ хөрс хуулж, 600.0 мян.тн хүдэр олборлон (үүний 252.0 мян.тн-ыг баяжуулах 1-р үйлдвэрт, 348.0 мян.тн-ыг баяжуулах 2-р үйлдвэрт) баяжуулж, 127,768.0 кг мөнгө, 147.3 кг алт гарган авч борлуулахаар төлөвлөсөн.

Биологийн нөхөн сэргээлтийг хийхгүй, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 4 га-д 50000 ш модыг Салхит уурхайн орчимд тарина.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/:

Ажилчдын унд, ахуйд хэрэглэх болон технологид ашиглах усыг Гашууны газрын доорх ордод гаргасан 14 ш худгаас хангана. Уурхайн зам, талбайн усалгаанд шүүрлийн ус ашиглана. "Уурхайд орох усны хэмжээг 2012 онд явуулсан судалгааны дүнгээр 84.1 м³/хоног буюу 3.5 м³/цаг гэж тооцсон байдаг. 2020 онд явуулсан судалгаагаар дээр тооцсон уурхайд орж ирэх газрын доорх усны хэмжээ 352.8 м³/хоног гэж тооцсон ба мөн онд ордын гидрогеологийн нөхцөл болон уурхайд орж ирэх шүүрлийн усны тодотгол тооцоогоор уурхайд орж ирэх газрын доорх усны хэмжээ нь 44.48 м³/хоног буюу 1.85 м³/цаг гэж тооцсон байна. Энэ тооцоо нь ил уурхайн өнөөгийн ашиглалтын хугацаанд уурхайн мөргөцөгт орж ирж буй усны бодит хэмжээтэй тохирохгүй шүүрлийн усны хэмжээ нь 2022 оны судалгаагаар маш бага байна гэж тодорхой ажиглагдсан. /Гидрогеологич, доктор (PhD) Н.Лхагвын тооцооллоор 84.1 м³/хоног = 80.999 м³/хоног ерөнхийдөө дүйцэж байна/ гэж дүгнэсэн байна.

"Монгол-Ус" ТӨААТҮГ-аас "Эрдэнэс силвер ресурс" ХХК-д 2020.03.26-ны өдрийн 1/137 дугаартай албан тоотоор гаргаж өгсөн усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд: "Гашууны газрын доорх усны ордын нөөц 7.83 л/сек буюу 676.58 м³/хон. Унд, ахуй, зам, талбайн усалгаа, технологийн хэрэгцээ, биологийн нөхөн сэргээлтэд ашиглах нийт 649.6 м³/хон усыг 676.58 м³/хон нөөцтэй Гашууны газрын доорх усны ордоос авахад, мөн ногоон байгууламжийн усалгаанд ашиглах 80 м³/хон усыг шүүрлийн ус (88.9 м³/хон)-наас ашиглахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна" гэсэн. Унд, ахуйд хоногт 59.1 м³ ус хэрэглэнэ.

9. Усны барилга байгууламжууд: /нэр, хүчин чадал, хэмжээ, хийц, дамжуулах шугам сүлжээний урт, диаметр/

Хаягдлын сангийн ажлын зураг төслийг 2020 онд "Эс Ар Ди Констракшн" ХХК-иар гүйцэтгүүлж, зураг төслийн дагуу хаягдлын санг байгуулах ажлыг 2020 онд хийлгэсэн.


2020 онд байгуулсан баяжуулах үйлдвэрийн хаягдлын сангийн эзлэхүүн: 302.0 мян.м³, HDPE геомембран доторлогоотой. 2022 онд шинээр 458.0 мян.м³ эзлэхүүнтэй, HDPE геомембран доторлогоотой хаягдлын сан байгуулсан.

Хуучин ашиглалтанд байсан 100 мм - 159 мм голчтой ган хоолой, нийт 6322.1 м урт шугам хоолойн зарим хэсэг буюу хятадуудын үед хийгдсэн 1-р худгийн шугам хоолой усны хатуулагаас шалтгаалж зэвэрч цоорон битүүмжгүй болж хөрсөнд нэвчиж байсан учир 709 м шугам хойлойг шинэчлэн засварласан байна. Энэ жил хоёрдугаар үйлдвэр ашиглалтанд орсон бөгөөд технологид хэрэглэх цэвэр усны дутагдалыг нөхөж, ундрага сайтай худгуудыг нэмж гаргасан тул шугам хоолойн нэвтрүүлэх чадварыг сайжруулж өргөтгөлийн ажлууд хийгдсэн байна. 11 болон 12-р худгийг 2021 оны сүүлчээр гаргасан бөгөөд 2022 оны 9 сард холболтын ажил хийгдэж ашиглаж эхэлсэн байна. Өргөтгөлийн ажлын хүрээнд: 4-р усан сангаас 1-р усан сан хүртэлх 100 мм голчтой шугам хоолойн нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж 159 мм голчтой шугам хоолойгоор өргөтгөж шинэчилсэн.

БҮ-2-ын 6-р усан санруу 1-р усан сангаас 219 мм голчтой 2660 м шугам хоолой шинээр хийгдсэн, энэ жил шугамын дунд хэсэгт өргөлтийн насосны станц барих ажил хийгдэж, ашиглалтанд орохоор байна.

Нөхөж гаргасан 3-р худгийг 1-р усан санд ойрхон учир шууд холбосон, харин нөхөж гаргасан 5-р худаг ширгэсэн 5-р худагтай ойрхон шугаманд нь 130 орчим м шугамаар шууд холболт хийж ашиглаж байна.

Харин нөхөж гаргасан 6 болон 8-р худгууд нь ундрага ихтэй тул тусад нь усан санд хуримтлуулан 4-р усан сантай холбон ашиглаж байна. Дээрх шугам хоолойнууд газрын



хөрснөөс 3 метр гүн буюу хөлдөлтийн гүнээс доор хийгдсэн байна. Нийт 12 усан сантай. Усан сангийн нийт эзэлхүүн нь 4776.2 м³.

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/:

№	Уртраг	Өргөрөг	Ундарга (л/с)	Насосны марк	Тоолуурын	
					Марк	Дугаар
1	106°59'48.0"	45°52'29.1"	3.0	PROG 7.5 KW	LXLC	202001085
2	107°00'21.0"	45°52'19.3"	2.2	PROG 7.5 KW	LXLC	202002633
3	107°00'47.2"	45°52'29.0"	3.2	PROG 7.5 KW	LXLC	202002642
4	107°00'34.4"	45°52'17.2"	2.2	S150QJ20-149/16-13	LXLC	202002632
5	107°02'25"	45°86'94.2"	4.0	QJ-2.2-100/6T-20	LXSG-40	20222630
6	107°06'08.89"	45°86'98.1"	5.0	QJ-2.2-100/6T-20	LXSG-40	202001520
7	107°01'77"	48°86'77.0"	2.2	13QJ8-121/14-5.5	LXSG	2107019931
8	107°02'08.7'	45°86'82.4"	5.5	QJ-2.2-100/6T-20	LXSG	202002129
9	107°01'03.33"	45°52'35.52"	6.0	MS-125-11	LXLC	202002525
10	107°01'17.9"	45°52'42.0"	4.0	QJ-7,5-125/8T-28	LXLC	202002505
11	107°01'36.08"	45°52'30.28"	3.5	QJ-7,5-125/8T-28	LXLC	2107019946
12	107°01'21.15"	45°52'19.13"	3.0	QJ-7,5-125/8T-28	LXLC	2107019913

Ажилчдын кемп, оффисын ахуйн хэрэглээнд ашиглаж буй худгаас авч буй цэвэр усны шугам, эргэлтийн усан сангаас усыг татах шугам, худгуудаас эргэлтийн усан санд ус дамжуулах шугамд усны тоолуур суурилуулсан.

11. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших "Эрдэнэс силвер ресурс" ХХК-ийн эзэмшлийн MV-021483 дугаартай Салхит мөнгөний орд ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг "Найчрал Састайнэблэ" ХХК 2022 онд боловсруулж, батлуулсан.

12. Онцгой нөхцөл:

- Уурхайн ухлагад шүүрэн орж ирэх усны хэмжээг ашиглалтын жилүүдээр мэргэжлийн байгууллагаар тогтоолгон, тайланг Усны газарт ирүүлэх;
- Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны өдрийн дотор Усны газарт ирүүлэх шаардлагатайг анхаарах.

13. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм"-ын дагуу тооцоход үйлдвэрлэлийн хэрэгцээнд жилд:

$$600,000.0 \text{ тн} \times 3.5 \text{ м}^3 = 2,100,000.0 \text{ м}^3/\text{жил ус шаардагдана.}$$

2,100,000.0 м ³ /жил x 12% = 252,000.0 м ³ /жил	-нөхөн сэлбэлтээр авч ашиглах усны хэмжээ
252,000 м ³ /жил	- баяжуулах үйлвэрийн технологит ашиглах нийт ус
70200 м ² x 2 л/м ² x 1 удаа x 240 хон = 33,696.0 м ³ /жил	-зам, талбайн тоосжилт дарахад ашиглах ус (БОННУТ 71х)
50,000 ш x 50 л/ш x 18 удаа = 45,000.0 м ³ /жил	- "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад ашиглах ус



$252,000.0 + 33,696.0 + 45,000.0 =$ $330,696.0 \text{ м}^3/\text{жил}$	-Жилд ашиглах нийт газрын доорх усны хэмжээ
$84.1 \text{ м}^3/\text{хон} \times 330 \text{ хон} = 27,753.0 \text{ м}^3/\text{жил}$	-уурхайн ухлагаас шавхан зайлуулах шүүрлийн усны хэмжээ (Гидрогеологич, доктор, PhD Н.Лхагва докторын газрын доорх усны шүүрэл, хөдөлгөөний тооцоо 3х) /технологи, зам, талбайн тоосжилт дарах, мод тарихад ашиглана/.
$330,696.0 - 27,753.0 = 302,943.0 \text{ м}^3/\text{жил}$	-Жилд худгаас ашиглах газрын доорх усны хэмжээ
$513 \text{ хүн} \times 150 \text{ л/хон} \times 330 \text{ хон} = 25,393.5 \text{ м}^3/\text{жил}$	-унд, ахуйн усны жилийн хэрэгцээ

14. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу унд, ахуйн зориулалтаар ашиглах **25,393.5 м³/жил** усыг төлбөрөөс чөлөөлнө.

Ашигт малтмал олборлон, баяжуулахад ашиглах **302,943.0 м³/жил**, уурхайн ухлагаас шавхан зайлуулах ус буюу зам, талбайн тоосжилт дарах, дүйцүүлэн хамгаалах ажил болон мод тарихад ашиглах **27,753.0 м³/жил** газрын доорх усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302, 2013 оны 326, 327 дугаар тогтоолоор баталсан усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ, ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тус тус үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

Ашигт малтмал олборлох, баяжуулахад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 3700 \text{ төг/м}^3 \times 0.35 \times 1.8 = 2331.0 \text{ төг/м}^3$

3700 төг/м³: Засгийн газрын 2011 оны 302-р тогтоолоор Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

35%: Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 7.а)-д заасан газрын доорх усыг ашигт малтмал олборлох, баяжуулахад ашигласны төлбөрийн хувь;

1.8: Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолоор Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт газрын доорх усыг ашигт малтмал олборлох, баяжуулах зориулалтаар ашигласныг тооцох итгэлцүүр.

$302,943.0 \text{ м}^3/\text{жил} \times 2331.0 \text{ төг/м}^3 = 706,160,133.0 \text{ төг}$

Уурхайн ухлагад шүүрлээр орж ирэх ус буюу шавхан зайлуулахад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$1 \text{ м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 3700 \text{ төг} \times 0.15 \times 1.6 = 888.0 \text{ төг/м}^3$

3700 төг/м³: Засгийн газрын 2011 оны 302-р тогтоолоор Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;

15%: Засгийн газрын 2013 оны 326-р тогтоолын 7.г)-д заасан газрын доорх усыг шавхан зайлуулсныг тооцох төлбөрийн хувь;



1.6: Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолоор Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт шавхан зайлуулах зориулалтаар газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр.

$27,753.0 \text{ м}^3/\text{жил} \times 888.0 \text{ төг}/\text{м}^3 = 24,644,664.0 \text{ төг}$

Нийт төлбөр: 706,160,133.0 төг + 24,644,664.0 төг = 730,804,797.0 төг

/Долоон зуун гучин сая найман зуун дөрвөн мянга долоон зуун ерэн долоон төгрөг/

15. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар:

- Шавхан зайлуулах шүүрлийн усыг технологийн хэрэглээнд болон зам талбайн тоосжилт дарах, мод тарихад эргүүлэн ашиглах;
- Газрын доорх усны ордын усны түвшний хэлбэлзэл, төлөв байдлыг тогтмол хянаж байх.

16. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө:

- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны эх үүсвэрийн гүний худаг, эргэлтийн усны шугам хоолойн гаргалгаанд баталгаажуулсан тоолуур суурилуулан тоолуурын заалтаар байгалийн нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахгүй байх;
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх;
- Үйл ажиллагаа зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж ажиллах;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт-шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Усны газарт office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах.



УС АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.МЯГМАРЖАВ Х.МЯГМАРЖАВ



УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 117

Сүмбэр сум

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1, 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Усны газар"-ын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 70 тоот ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт байрлах "Эрдэнэс силвер ресурс" ХХК-ийн унд, ахуйн хэрэгцээнд 25'393.5 шоометр, баяжуулах үйлдвэрт 302'943 шоометр, шавхан зайлуулалт /дүйцүүлэн хамгаалах ажилд/ 27'753 шоометр нийт 356'089.5 шоометр усыг 1 жилийн хугацаагаар "Эрдэнэс силвер ресурс" ХХК-д ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. "Эрдэнэс силвер ресурс" ХХК-ийн ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавин ажиллахыг Газрын доорх усны нөөц ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Сарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Монгол Улсын "Улсын тэмдэгтийн хураамжийн тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.20-д заасны дагуу ус ашиглах зөвшөөрлийн хураамжийг Сайнцагаан сумын Төрийн сан банкны дансанд тушаах, Төсвийн тухай хуулийн 23 дүгээр зүйлийн 23.6.5-д заасны дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг Дундговь аймгийн төсөвт гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлэхийг "Эрдэнэс силвер ресурс" ХХК-д захирал /С.Баярмөнх/-д үүрэг болгосугай.

4. Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалтын дагуу ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны ашиглах боломжит нөөцийн хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэхгүй байх болон Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтын дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2023 оны 12-р сарын 25-ний өдрийн дотор ирүүлэхийг "Эрдэнэс силвер ресурс" ХХК-д захирал /С.Баярмөнх/-д даалгасугай.

ДАРГА  Б.ОТГОНСҮРЭН

БАТЛАВ:

УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА

/Б.ОТГОНСҮРЭН/

БАТЛАВ:

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

/С.БАЯРМӨНХ/

ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ

2023 оны 04 сарын 04-ны өдөр

Дугаар-06

Чойр

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу Умард говийн гүвээт-Халхын дундад талын Сав газрын захиргааны гаргасан 2023 оны 04 дугаар сарын 04-ний өдрийн 06 дугаартай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж Умард говийн гүвээт-Халхын дундад талын Сав газрын захиргааны Усны чанар экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Солонго, нөгөө талаас: Ус бохирдуулагчийг төлөөлж: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 17, “Блю Скай” Тауэр, 607 тоотод байрлах 9011474118 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 6436226 тоот регистрийн дугаартай хуулийн этгээдийг төлөөлж “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ны Байгаль орчны мэргэжилтэн Г.Анх-Амгалан нар ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд дагуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

“Эрдэнэс силвер ресурс” ХХК-ны 2022 оны 02 дугаар улиралын шинжилгээний дүн болон 1, 3, 4-р улиралын тоолуурын заалтыг үндэслэн гаргав.

Ус бохирдуулсны төлбөрийн нийт дүн: 17'179'031.06 төгрөг /Арван долоон сая нэг зуун далан есөн мянга гучин нэгэн төгрөг/ Усны газрын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 45 дугаартай хаягдал усны дүгнэлт үндэслэв.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах Татварын албанд төлнө.

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харьяа Татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.4.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

2.4.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.4.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.4.4. Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;

2.4.5. Бохирдуулах бодисын ялгарал шинжилтийн системд усны бохирдлын мэдээллийг бүртгүүлнэ;

2.4.6. Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан.

Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17.1.8 дахь хэсэгт заасны дагуу Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад заасны дагуу Сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно;

3.3. Сав газрын захиргаа болон сум дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа, сум дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолгох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа энэхүү гэрээг болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны эзлэхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл (тоолуур)-ийг “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

Тав. Бусад

- 5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу харьцууцлага хүлээнэ.
- 5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.
- 5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

- 6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:
Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Усны чанар экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н. Солонго



Хаяг: Монгол улс, Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 2-р баг, Ногоон хөгжлийн төв, 2 давхарт, 205 тоот
Харилцах утас: 7054-3598

Ус ашиглагчийг төлөөлж:
“Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн
Г. Анх-Амгалан



Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 17, “Блю Скай” Тауэр, 607 тоот
Харилцах утас: 8900-8524



ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: 08

МУЭТХ Ажилтгал Чинхуу ямар -ын гаргасан
/ Дүгнэлт гаргасан байгууллага /

2021 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн хаягдал ус хаях, зайлуулах 08..... тоот

дүгнэлтийг үндэслэн Улаангаатар аймаг/нийслэл Сүхбаатар

сум/дүүргийн 1 дорно амтлалын цогц 14 байршилтай
/ хаяг /

Салхемтэх номонхой цугил ил цуглар шөрлөх, Флотацийн цугил
/ үйл ажиллагааны чиглэл /

чиглэлээр хаягдал ус гаргаж байгаа Эрдэнэ алдарт рүүрц ахх -д
/ хун, хуулийн этгээдийн нэр /

Дундговь аймаг/нийслэл, Гурван айсан сум/дүүргийн

Цуцал мөрөө 35 км байршилтай хаягдал

ус зайлуулах цэг буюу хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны
шугамд жилд 24340 мян.м³ хаягдал усыг “Хүрээлэн байгаа

орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015”,

“Хүрээлэн байгаа орчин, усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд
нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015” стандартаар

тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг
/ аль нь болохыг доогуур нь зурах /

нэг жилийн хугацаагаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон
дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгагдсанд тооцно.

Хаягдал усны хэмжээ болон хаягдал ус зайлуулах цэг, төвлөрсөн бохир усны
шугамын байршил өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр шинээр зөвшөөрөл олгоно.

Зөвшөөрлийн бичиг олгосон:

МУЭТХ Ажилтгал
/ Зөвшөөрөл олгосон байгууллага /




Г.Сүхбаатар
/ Гарын үсэг /

Б.Сүхбаатар
/ Гарын үсгийн тайлал /

Тамга

2021 оны 08 -р сарын 22 -ны өдөр

СУНГАЛТ

Сунгалт хийсэн шийдвэр	Огноо	Гарын үсэг / тамга
Эрдэнэ сүлжэр ресурсе ХХК-г хяналт үе, хаях, зайлуулах зөвшөөрөл сунгав.	2022.05.17 №108	
Эрдэнэ сүлжэр ресурсе ХХК-г хяналт үе, хаях, зайлуулах зөвшөөрөл сунгав	2023.04.04 № 98	
Эрдэнэ сүлжэр ресурсе ХХК-г хяналт үе, хаях, зайлуулах зөвшөөрөл сунгав	2023.04.21 № 119 1 хүмүүс	



ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗАРТ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН
ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГАА

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас/Факс: (976) 7054 3599,
Цахим шуудан: umardgobi14@gmail.com,
Цахим хуудас: www.gobiwater.mn

2023.11.15 № 998
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг "Салхит" нэртэй нутагт ашигт малтмалын MV-021483 тоот тусгай зөвшөөрөлтэй Салхитын мөнгө-алтны ордын уулын баяжуулах үйлдвэр "Эрдэнэс алт ресурс" ХХК нь баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэгцээний зориулалтаар 3 худаг гаргах хүсэлт ирүүлсэн.

Тус компаниас 2023.11.09-ны өдрийн ирүүлсэн тодруулга тайлбар албан бичигт үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж баяжуулах 2 дугаар үйлдвэрийг шинээр барьж ашиглалтад оруулснаар технологийн усны хэрэглээ 54% нэмэгдэж, ордын нөөц, ашиглалтын хугацаанд өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор технологийн усан хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, байнгын тасралтгүй найдвартай ажиллагааг хангах зорилгоор 3 худаг гаргах шаардлагатай байгаа хүсэлтийн дагуу улсын үйлдвэрийг усан хангамжаар тасалдуулахгүй тогтвортой ажиллах нөхцөл шаардлагын улмаас худгийн зөвшөөрөл олгоход татгалзах зүйлгүй болно.

Баримт бичигт ирүүлсэн худгийн мэдээлэл:

1. Захиалагч иргэн, аж ахуй нэгж байгууллагын нэр: "Эрдэнэс алт ресурс" ХХК
2. Худаг /цооног/ гаргах усны мэргэжлийн байгууллага: "Грандхолдинг" ХХК
3. Худаг / цооног/-ийн ангилал: Инженерийн хийцтэй худаг
4. Худаг / цооног/ гаргах байршил:

Цооног – 1 X 45° 51' 57.07"

Y 107° 2' 30"

Цооног – 2 X 45° 51' 32.5"

Y 107° 10' 5.7"

Цооног – 3 X 45° 51' 47.2"

Y 107° 3' 31.7"

Хаяг: Дундговь аймаг Гурвансайхан сум

5. Өрөмдлөгийн машин механизм, өрөмдөх арга, техник хэрэгсэл: POWER-4000 цохилтот өрөм
6. Худаг /цооног/-ийн гүн: 100 метрээс дээш гүнтэй өрөмдөхөөр төлөвлсөн.
7. Зориулалт: Технологийн хэрэгцээнд

Дээрх баримт бичгийг үндэслэн худгийн зөвшөөрлийг олгоход татгалзах зүйлгүй бөгөөд дараах шаардлагыг тавьж ажиллахыг зөвлөж байна. Үүнд:

1. Технологийн хэрэгцээнд ашиглаж буй худгуудаас ундарга муудсан, шавхагдсан худгуудыг сум орон нутагт хүлээлгэн өгч актлуулах.
2. Усны тухай хуулийн 28.2.2 дэх заалтын дагуу усны ашиглах боломжит нөөцийн талаарх дүгнэлтийг шинэчлэн гаргуулах
3. Усны тухай хуулийн 30.1.4 дэх заалтын дагуу ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулан, ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журмыг хэрэгжилтийг ханган ажиллах
4. Уст цэг тогтоосон цэгээс өөр цэгт өрөмдөхгүй байхад хяналт тавьж ажиллах
5. Худаг уст цэг гаргаж буй мэргэжлийн байгууллагын худаг өрөмдөх явцад хяналт тавьж, худгийн ундарга тогтоох, шавхалт хийх, тохирсон гүнд өрөмдсөн эсэхэд гүйцэтгэлийг хянаж чанартай гүйцэтгэлтэй худаг гаргахад анхаарах шаардлагатай.

ДАРГА



БОТГОНСҮРЭН

Усны газрын даргын
2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн
А/28 дугаар тушаалын 15 дугаар хавсралт

ХУДАГ (ЦООНОГ) ГАРГАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

2023 оны 11 сарын 16 өдөр

Дугаар-13

Дундговь аймаг

Ерөнхий мэдээлэл:

1. Захиалагч аж ахуйн нэгж байгууллагын нэр: "Эрдэнэс алт рөсурс" ХХК
2. Худаг (цооног) гаргах усны мэргэжлийн байгууллага: "Грандхолдинг" ХХК
3. Худаг (цооног)-ийн ангилал: *Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах.*
4. Худаг (цооног) гаргах байршил: Цооног – 1 $X 45^{\circ} 51' 57.07''$, $107^{\circ} 2' 30''$
Цооног – 2 $X 45^{\circ} 51' 32.5''$, $107^{\circ} 10' 5.7''$
Цооног – 3 $X 45^{\circ} 51' 47.2''$, $107^{\circ} 3' 31.7''$

Хаяг: Дундговь аймаг, Гурвансайхан сум, Чулуут баг,

5. Өрөмдлөгийн машин механизм, өрөмдөх арга, техник хэрэгсэл:
Power-4000 цохилтот өрөм
6. Худаг (цооног) –ийн гүн: *Тус бүр 100 метрээс дээш гүнтэй өрөмдөхөөр төлөвлөсөн.*
7. Зориулалт: *Технологийн хэрэгцээнд*

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ

ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА

Н.ГАНТУЛГА

